

МОНГОЛЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2003



МОНГОЛЫН ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИЛТГЭЛ 2003

Хот, хөдөөгийн ялгаатай байдал



Монгол Улсын
Засгийн Газар



Монгол улсад хэвлэв.

Хүний хөгжлийг хангах орчинг бүрдүүлж, иргэдийнхээ амьдралын түвшинг дээшлүүлэх, нийгмийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах нь манай Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацааны дөрвөн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан нийгмийн салбарын чухал зорилт төдийгүй Монгол төрийн холч бодлогын голд тавигдах алсын баримжаа, чиглүүлэгч зарчмуудын нэг юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Нацагийн Багабанди 2002 оны 03 дугаар сарын 20-нд Засгийн газарт чиглэл болгосон “Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах тухай” зарлигтаа “хөгжлийг үзэх үзэл, нийгмийн дэвшлийн шалгуурын тухай ойлголт ч өөрчлөгдөж хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг баримжаалах нийтлэг жишиг тогтож ...” байгааг онцлон тэмдэглэсэн билээ.

Нөгөө талаас, хүний хөгжилтэй холбогдсон дээрх зорилтуудад анхааралтай хандаж, хариуцлагатай хэрэгжүүлэх нь “Нийгмийн хөгжлийн тухай Копенгагений тунхаглал” (1995), “Мянганы хөгжлийн тунхаглал” (2000) зэрэгт Монгол Улс нэгдэн орж тэдгээрийг хамтран батлалцсаны хувьд дэлхийн олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө манай төр, Засгийн газрын хүлээсэн эрхэм үүрэг юм.

Иймээс хүнээ хөгжүүлэх хүрээний зорилтууд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тодорхой тусгагдаж биелэлтэнд нь хяналт, үнэлгээ байнга хийгдэж байгаа билээ.

Сүүлийн жилүүдэд хүн амын боловсрол, эрүүл мэнд, орлогод гарсан эерэг өөрчлөлтүүдийн дүнд Монгол улсын хүний хөгжлийн үзүүлэлтүүд шилжилтийн өмнөх үеийн түвшингээс ахицтай байж, макро эдийн засгийн нөхцөл байдал тогтворжиж, улмаар өсөлт бий болж байна. Энэ нь эдийн засгийн өсөлтийг хангахуйц хүний хөгжлийн чадавхи, нөгөө талаас хүний хөгжлийн цаашдын өсөлтийг хангах эдийн засгийн нөөц боломжийн аль аль нь бүрэлдэн хөгжих баярлууштай хандлага үүссэнийг гэрчилж байна.

Гэвч бид бүхний энэхүү даруухан ололт, амжилт маань сэтгэл ханан тайвшрах ямар ч үндэс болох ёсгүй гэдгийг 2003 оны дэлхийн хүний хөгжлийн илтгэлд манай улс хүний хөгжлийн үзүүлэлтүүдээрээ 175 орноос 117-д орж урдаа 116, ардаа 58 оронтой байгаа жагсаалт сануулан, шавдуулж байна.

Улсын Их Хурлын ээлжит гурав дахь удаагийн сонгуулийн үр дүнд 2000 онд байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлж дуусах шатандаа нэгэнт орж үлдсэн хугацаанд дутуугаа гүйцээж, дундуураа дүүргэхийн зэрэгцээ цаашдын бодлого, үйл ажиллагаагаа тунгаан төлөвлөж буй энэ үед “Монголын хүний хөгжлийн илтгэл, 2003” бэлтгэгдэн гарч байгаа нь сайшаалтай байна.

Монгол Улсын хүний хөгжлийн үндэсний илтгэл нь хэдийгээр уг асуудлын талаарх Засгийн газрын байр суурийг албан ёсоор илэрхийлээгүй, бие даасан судлаачид, эрдэмтдийн чөлөөт бүтээл ч гэсэн манай орны хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаа, тэгш бус байдал, тэдгээрийг үүсгэн бий болгож буй хүчин зүйлс, хандлагыг тогтоож, нэгэнт буй болсон ялгааг багасгах талаар нийтлэг зөвлөмж, дүгнэлт гаргаж байгаагаараа ач холбогдолтой юм.

Хөгжил дэвшлийн эх сурвалж болсон хүний хөгжлийн чадавхи, боломжийг дээшлүүлэх явдал нь нэг талаас төр, Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, нөгөө талаас иргэдийн өөрсдийн хийгээд иргэний нийгмийн зүгээс гаргах хүчин чармайлт, идэвхи оролцооноос онцгой хамаардаг нарийн цогц асуудал тул илтгэлд орсон баримт, мэдээлэл, задлан шинжилгээ, дүгнэлт, зөвлөмж нь бүх түвшний шийдвэр гаргагчид, бодлого боловсруулагчид, иргэд, төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид, оюутан залуус, өргөн олон нийтийн анхааралд өртөж тэдний олон талт үйл ажиллагаа, ажил амьдралд нь ач тусаа өгч шинэ сэдэл, тэмүүлэл өгнө гэдэгт итгэлтэй байна.

Эцэст нь “Монголын хүний хөгжлийн илтгэл, 2003”-ийг бичихэд идэвхитэй оролцсон эрдэмтэд, мэргэжилтнүүд, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтнууд, нийт хүмүүст, түүнчлэн энэ ажлыг амжилттай дуусгахад бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн газарт Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлье.



Монгол Улсын Ерөнхий сайд
Н.Энхбаяр

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр 1990 онд дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэл гаргаснаас хойш улс орнуудад үндэсний хүний хөгжлийн илтгэлээ бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлсээр ирсэн юм. Үндэсний хүний хөгжлийн илтгэл нь тухайн улсын хөгжлийг хүний хөгжлийн шалгуурын дагуу үнэлэхдээ хүний хөгжлийн үндсэн үзэл баримтлалыг улс орны онцлогтой уялдуулан авч үздэг. Эдгээр илтгэлүүд хүмүүсийн ойлголт, хүсэл эрмэлзлийг нарийн томъёолж, эрэгтэй, эмэгтэйчүүдийн боломж, чадамжид гарч байгаа дэвшил, ухралтыг тодруулах, хүн төвтэй бодлогыг түгээх, хөгжлийг төлөвлөх хэрэгсэл болдог.

Монголын хүний хөгжлийн анхны илтгэл (1997) шилжилтийн үеийн Монголын ард түмний аж байдлын түвшинд үнэлгээ өгсөн билээ. Монголын хүний хөгжлийн хоёр дахь илтгэл (2000) өнөөгийн Монгол улсад төрийн гүйцэтгэх үүрэгт анхаарал хандуулан, түүнд задлан шинжилгээ хийх, иргэд төрөөс ямар зүйл хүсэн хүлээж байгаа талаар өргөн шүүмжлэл, мэтгэлцээн өрнүүлэх оролдлого хийсэн юм. Монголын хүний хөгжлийн гурав дахь илтгэл (2003)-д хот, хөдөөгийн ялгаатай байдлыг авч үзлээ. Энэхүү сэдвийг Үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцогсод хот, хөдөөд тэгш бус байдал илт байгааг хүлээн зөвшөөрч сонгосон юм.

Энэ удаагийн илтгэлд эдийн засгийн салбарт зарим нааштай өөрчлөлт гарч байгаа хэдий ч хот, хөдөөгийн хооронд ихээхэн ялгаа бий болж байгааг онцлон тэмдэглэжээ. Орлогын ядуурал хот сууринд хөдөөтэй харьцуулахад илүү түгээмэл байна. Тэгш бус байдал нь дотоод шилжих хөдөлгөөн, хотжих үйл явцад түлхэц өгч, хотын ядуурал нэмэгдэх зэрэг бусад бэрхшээлийг бий болгож байна. Шилжих хөдөлгөөний өнөөгийн байдлаас харахад 2015 он гэхэд Улаанбаатар хотод нийт хүн амын тэн хагас нь суурьших төлөвтэй байна. Монголын хүний хөгжлийн илтгэл (2003) хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгааг задлан шинжилж, эдгээр өөрчлөлтөд төр засаг, иргэдээс үзүүлж буй хариу үйлдлийн талаар өгүүлэн, хот, хөдөөгийн ялгааг арилгахад чиглэсэн бодлогын хувилбаруудыг санал болголоо. Түүнчлэн илтгэлд хүний хөгжлийн төлөв байдлын шинэчилсэн дүр зургийг гаргаж, хүний хөгжлийн индексийг анх удаа аймаг, бүс нутгаар тооцов.

Монголын эдийн засаг энэ жил ч өсөх төлөвтэй байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт ч нэмэгдэж байна. Монгол улсын Засгийн газар Мянганы хөгжлийн зорилтуудын талаархи анхны илтгэлээ эцэслэн гаргаж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийг боловсрууллаа. Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах нь хот, хөдөөгийн хүн ам, ялангуяа нэн ядуу иргэдийн амьжиргааг мэдрэгдэхүйц дээшлүүлэхээс хамаарах болно. Монгол улс ядуурлыг бууруулж, хот, хөдөөгийн хүн амын амьжиргааны наад захын хэрэгцээг хангах зорилгоор хот, хөдөөгийн хөгжилд хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэн хийх хэрэгтэй юм. Хүн амын ядуу хэсэг хөгжлөөс гадуур орхигдох нь олонтаа. Тэд өөрсдийнх нь амьжиргаанд шууд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад оролцохгүй байгаагаас хөгжлийн үр шимийг хүртэж чадахгүй байна. Мөн нийгэм, эдийн засгийн хөгжилд ядуучуудын оруулдаг хувь нэмэр бүрэн хүлээн зөвшөөрөгддөггүй. Эдийн засгийн өсөлт нэн чухал боловч түүнийг ядуу иргэд үр шимээс нь хүртэхүйц, далайцтай, хүний хөгжилд чиглүүлэх төрийн бодлого шаардлагатай. Монголын хүний хөгжлийн илтгэл (2003)-д эдийн засгийн өсөлт нь хүмүүсийн сонголтыг өргөжүүлэх цорын ганц арга хэрэгсэл, хүний сайн сайхан аж байдал нь хөгжлийн зорилт, эцсийн үр дүн гэдэг санааг дэвшүүлэн тавьжээ.

Илтгэлд хот, хөдөөгийн ялгаатай байдлыг багасгахад тэнцвэртэй хөгжил чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэсэн байна. Энэ нь хот, хөдөөд зөвхөн тэгш хөрөнгө оруулалт хийх замаар бус харин хөгжлийн замаа тодорхойлоход нь хот, хөдөөгийн иргэдэд эрх мэдэл олговол зохино гэсэн үг юм. Төвлөрлийг сааруулж эрх мэдлийг доод түвшинд шилжүүлэн, оролцоог хангах нь тэнцвэртэй хөгжилд хүрэх гол хүчин зүйл болдог.

Энэхүү илтгэлийг бэлтгэсэн бие даасан шинжээчид, байгууллагууд, зөвлөлдөх уулзалтуудад оролцон санал зөвлөгөө өгсөн бүх хүмүүст НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр талархал илэрхийлж байна. Илтгэл нь хүний хөгжил, тэгш бус байдлын асуудлаар мэтгэлцээн өрнүүлж, хэрэв хяналтгүй орхивол Монгол улсын хөгжлийг сааруулж болзошгүй ялгаатай байдлын тулгамдсан асуудалд анхаарал хандуулахад тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт бид гүнээ найдаж байна.



НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Суурин төлөөлөгч, НҮБ-ын суурин зохицуулагч
Сарасвати Менон

Энэхүү илтгэл нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Монгол улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлээгүй болно. Илтгэлийг ашгийн бус зорилгоор олшруулан хуулбарлаж, тараахыг зөвшөөрнө.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байр
Нэгдсэн Үндэстний Гудамж 12
Ш/Х49/207
Улаанбаатар-46, Монгол улс

Электрон шуудан: registry.mn@undp.org
Интернетийн хаяг:
<http://www.un-mongolia.mn/undp>

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжих баг
М.Сарантуяа, Хөтөлбөрийн Шинжээч
Д.Сүхжаргалмаа, Шадар суурин төлөөлөгч

Гэрэл зураг:
Гамма Фото Студи

Хэвлэлийн эх, дизайн:
“Мөнхийн Үсэг” ХХК

ISBN 99929-6-143-0 (Монгол)

ISBN 99929-6-144-9 (Англи)

2003 оны Монголын Хүний Хөгжлийн Илтгэлийн эх материалуудыг бэлтгэсэн эх бичигчид

Др. Ц.Адьяасүрэн, Эко-Ази дээд сургуулийн захирал

Др. Н.Баяртсайхан, Улсын Их Хурлын гишүүн

Др. Г.Чулуунбаатар, Шинжлэх Ухааны Академийн Философи, Социологи, Эрхийн Хүрээлэнгийн захирал, Улсын Их Хурлын даргын зөвлөх

Др. Ч.Дагвадорж, Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны Стратегийн Удирдлага, Төлөвлөлтийн газрын дарга

Др. Х.Энхжаргал, ДОХ-той тэмцэх үндэсний сангийн гүйцэтгэх захирал

Др. М.Энхсайхан, Премьер Интернейшнл ХХК-ийн захирал

Редакторууд

Др. Я.Долгоржав, Удирдлагын Академийн профессор, Монгол улсын Ерөнхийлөгчийн зөвлөх

Др. Н.Батнасан, Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуулийн Маркетинг, Олон Улсын Худалдааны Тэнхмийн эрхлэгч

Зөвлөхүүд

Шива Кумар, Энэтхэг улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн зөвлөх

Шахрбану Тажбакш, Нью-Йорк хотын Колумбын Их Сургуулийн дэд профессор

Зохицуулах баг

Б.Алтанцэцэг, Т.Навч, Э.Сайнбилэг, А.Солонго, Г.Цагаач, Ч.Эрдэмжаргал, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэгийн гишүүд, П.Цэцгээ, НҮБХХ/ШОУХА “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн үндэсний менежер

Орчуулагчид

Ж.Гомбосүрэн (эхний хувилбар), Б.Наран (Бүлэг 1), Б.Мөнхжаргал (Тойм, Бүлэг 2), Д.Халиун (Бүлэг 3), Ц.Ганболормаа (Бүлэг 4)

2002-2003 онд зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтуудад оролцон, илтгэлийн талаар санал бодлоо хуваалцаж, үнэтэй хувь нэмэр оруулсан бүх хүмүүст гүн талархал илэрхийлье.

Өмнөх үг	ii	Мал маллах болсон нь	42
Талархал	iv	Албан бус сектор	45
Товчилсон үгсийн жагсаалт	vii	Шилжих хөдөлгөөн, хотжилт	47
ТОЙМ	1	Байгаль орчны нөлөө	48
БҮЛЭГ 1 Хүний хөгжлийн байдал	5	Бодлогын хариу үйлдэл	48
Хүний хөгжлийн хандлага	6	Дүгнэлт	51
1990 оноос өмнөх үеийн хүний хөгжил	6	БҮЛЭГ 4 Урагшлах замд	53
1990 оноос хойшхи үеийн хүний хөгжил	7	Урагшлах замд	54
Хүний хөгжлийг хэмжихүй	7	Тэргүүлэх дөрвөн чиглэл	54
Хүний хөгжлийн хэмжигдэхүүнүүд	7	Ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлт	54
Эсэн мэнд торнихуй	8	Тэнцвэртэй хөгжил	56
Эрүүл мэнд	8	Төвлөрлийг сааруулах үйл явцыг	
Боловсрол	10	бэхжүүлэх	56
Эдийн засаг	11	Хөгжлийн санхүүжилт	57
Орлогын ядуурал	12	Ном зүй	60
Ажилгүйдэл	14	ШИГТГЭЭ	
Жендэрийн тэгш бус байдал	14	1.1 Монголын ядуурлыг хэмжих нь: Арга зүйд	
Жендэрийн хөгжлийн индекс	15	гарч буй өөрчлөлтүүд	13
Дэд бүтэц	15	2.1 Монгол улсад хот, хөдөөг тодорхойлж	
Оролцоо	16	байгаа нь	24
Төвлөрлийг сааруулах бодлого, орон		2.2 Ястан үндэстэн: Хүртээмжийн тэгш байдал	26
нутгийн засаглал	17	2.3 Үнэн мэдээллийг олж авах	27
Хувь хүний баталгаагүй байдал	18	2.4 Цаг ашиглалт: Хот, хөдөөгийн эрэгтэй,	
Хуулиар хамгаалуулах боломж	18	эмэгтэй хүмүүсийн амьдрал	28
Хүрээлэн буй орчны тогтвортой байдал	19	2.5 Ус-Хот, хөдөөгийн ялгааг үүсгэгч	
Дүгнэлт	20	хүчин зүйл	31
БҮЛЭГ 2 Монгол дахь орон зайн тэгш		2.6 Төв аймгийн Арбулаг сумын малчдын санал,	
бус байдал	21	бодол, 1999 оны 8 сарын 31	35
Монгол дахь орон зайн тэгш бус байдал	22	3.1 Эмэгтэйчүүд ба ноолуур	43
Хот, хөдөөгийн ялгаатай байдлыг судлахад		3.2 Зуд	44
тулгарч буй бэрхшээл	23	3.3 Мянгат малчин	45
Хот, хөдөө дэх хүний хөгжил	24	3.4 Албан бус сектор	47
Хот, хөдөөгийн зааг ялгаа	26	3.5 Шилжих хөдөлгөөн	47
Эдийн засгийн боломж	27	3.6 Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал	
Ядуурал, амьжиргааны түвшин	28	хөтөлбөрийн зорилтууд	49
Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж	30	ХҮСНЭГТ	
Боловсролын хүртээмж	32	1.1 Монгол улсын хүний хөгжлийн индекс	8
Орон сууц, дэд бүтцийн хангамж	33	1.2 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн	
Мэдээллийн хүртээмж, ашиглалт	35	үйлчилгээний хүртээмж, хувиар	9
Оролцоо	36	1.3 Дундаас дээш боловсролтой өрхийн тэргүүний	
Дүгнэлт	37	хувийн жин, орлогын түвшингээр, 1998	13
БҮЛЭГ 3 Өөрчлөлтөд үзүүлж буй хариу үйлдэл ...	39	1.4 Ядуурлын түвшин, өрхийн тэргүүний хүйс,	
Өөрчлөлтөд үзүүлж буй хариу үйлдэл	40	байршлаар	15
Нийгмийн өөрчлөлт	40	1.5 Жендэрийн хөгжлийн үзүүлэлтүүд, 2002	15
Иргэдээс үзүүлж буй хариу үйлдэл	41	1.6 Дэд бүтцийн хөгжил, 1992-2002	16
Төрөлтийн түвшний бууралт	41	1.7 Монгол Улсын Ерөнхийлөгчийн ба УИХ-ын	
		сонгууль	17
		1.8 Гэмт хэргийн тоо, төрлөөр, 1990-2002	18
		2.1 Монгол улсын ХХИ хот, хөдөөгөөр,	
		1999-2002	25

2.2 Хүний хөгжлийн түвшин, аймаг, хотоор, 2002	25
2.3 ЖХИ, түүний үзүүлэлтүүд хот, хөдөөгөөр, 2000-2002	26
2.4 Ядуу хүн амын шинж байдал, 1995, 1998	29
2.5 10000 хүн тутамд ногдох өвчлөлийн үндсэн таван шалтгаан, хот, хөдөөгөөр, 2002	30
2.6 Ундны усны хүртээмж, хувиар, 1998-2000	32
2.7 Хот, хөдөөгийн орон сууцны нөхцөл, хувиар	33
2.8 Байшин, орон сууцны нөхцөл, хувиар	34
2.9 Гэрийн нөхцөл, хувиар	34
3.1 Хүн ам зүйн үзүүлэлтүүд, бүсээр, 1989, 2000	42
3.2 Тооллого хоорондын хүн амын өсөлт, бүсээр, 1979-1989, 1989-2000	42
3.3 1977-2002 оны зуданд нэрвэгдсэн малын тоо, толгой (мянгаар)	44
3.4 Албан бус секторт ажиллагсдын нийт ажил эрхлэлт, үйлдвэрлэлд эзлэх хувийн жин, хот, хөдөөгөөр, 1999	45
4.1 Хөрөнгө оруулалтын түвшин, ДНБ-д эзлэх хувиар, 1995-2000	55
4.2 Нийгмийн салбарын санхүүгийн зардал	55
4.3 Хөгжлийн албан ёсны тусламж, 1991-2001	58
4.4 Хөгжлийн албан ёсны тусламжийн гол хандивлагч улс орон, байгууллагууд	58
4.5 1991-2000 онд Монголд үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламж (сая ам.доллар)	59

ДҮРСЛЭЛ

1.1 Эрүүл мэндийн салбарын зардал, 2002	10
1.2 Боловсролын салбарын зардал, 2002	11
1.3 ДНБ-ий өсөлт, 1989-2002	11
1.4 Инфляцийн түвшин, 1991-2002	12
2.1 Монгол улсын засаг захиргааны бүтэц	23
2.2 Малчин эрх, малын тоо, толгойгоор, хувиар, 2002	28
2.3 Жини коэффициент, 1995, 1998, 2002	29

ЗУРАГЛАЛ

1.1 Хүн амын нягтрал, аймаг, хотоор, 2000	viii
---	------

ХАВСРАЛТ

Хүснэгт

X1 Хүний Хөгжлийн Индекс, аймаг, хотоор, 2002	63
X2 Хүний Хөгжлийн Индекс, аймаг, хотоор, 1999-2002	64
X3 Шилжилтийн эдийн засагтай орнуудын ХХИ, 2003	66
X4 Жендэрийн Хөгжлийн Индекс ба үзүүлэлтүүд, аймаг, хотоор, 2002	67
X5 Жендэрийн Хөгжлийн Индекс, аймаг, хотоор, 2000-2002	68
X6 Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр, аймаг, хотоор, 2002	68
X7 Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр, аймаг, хотоор, 2000-2002	69

X8 Хүн амын үндсэн үзүүлэлтүүд, 1989-2002	69
X9 Хүн амын тоо, нягтрал, хот, хөдөөгийн хүн амын хувийн жин, 1918-2002	70
X10 Хот, хөдөөгийн хүн ам, аймаг, хотоор, 2002	71
X11 Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, 1989-2002	72
X12 15 ба түүнээс дээш насны ажил эрхэлж буй хүн амын тоо, байршил, хүйсээр, 2000	72
X13 Ажиллагсдын тоо, салбараар, оны эцэст (мян.хүн)	73
X14 Ажиллагсдын тоо, аймаг, хотоор, оны эцэст (мян.хүн)	73
X15 Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдын дундаж цалин, салбараар, жил бүрийн 4-р улирлын байдлаар (мян.төг)	74
X16 Аж ахуйн нэгжийн тархалт, төрөл, байршлаар*, хувиар, 1998-2002	74
X17 Аж ахуйн нэгжийн тархалт, үйл ажиллагааны төрөл, байршлаар*, хувиар, 1998-2002	75
X18 Аж ахуйн нэгжийн тархалт, ажиллагсдын тоо, байршлаар, хувиар, 1998-2002	75
X19 Ажлын нэг өдөрт хүн амын ҮТС-ийн болон бусад үйл ажиллагаанд зарцуулсан дундаж хугацаа, хүйс, байршлаар, 2000 (минутаар)	76
X20 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалтын түвшин, насны бүлэг, хүйс, байршлаар, хувиар, 2000	77
X21 7 ба түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, аймаг, хотоор, хувиар, 2000	77
X22 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин, аймаг, хотоор, 1990, 1995, 2000, 2002	78

Зураглал

X1 Хүний Хөгжлийн Индекс, аймаг, хотоор, 2002	63
X2 Бага, дунд сургуулийн тоо, байршлаар, 2002-2003 оны хичээлийн жил	76
X3 Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), аймаг, хотоор, 2002	78
X4 Эхийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), аймаг, хотоор, 2002	79
X5 Хүний их эмчийн тоо (10000 хүнд ногдох), аймаг, хотоор, 2002	79

Дүрслэл


X1 Хүн амын өсөлтийн түвшин, 1989-2002	70
--	----

Арга зүйн тэмдэглэл	80
----------------------------------	-----------

Нэр томъёоны тайлбар	83
-----------------------------------	-----------

АХБ	Азийн Хөгжлийн Банк
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТОАТС	Амьжиргааны Түвшинг Оролцооны Аргаар Тодорхойлох Судалгаа
АТТС	Амьжиргааны Түвшний Түүвэр Судалгаа
БЗХ	Бэлгийн Замын Халдвар
ГШХО	Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт
ГТТХАА	Германы Техник Туслалцааны Хамтын Ажиллагааны Агентлаг
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ДБ	Дэлхийн Банк
ДХБ	Дэлхийн Худалдааны Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ЕХ	Европын Холбоо
ЖХИ	Жендэрийн Хөгжлийн Индекс
ЖЭМХ	Жендэрийн Эрх Мэдлийн Хэмжүүр
ЖДУ	Жижиг Дунд Үйлдвэр
МХЗ	Мянганы Хөгжлийн Зорилтууд
МХЗИ	Мянганы Хөгжлийн Зорилтуудын Илтгэл
НУБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НУББОХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль Орчны Хөтөлбөр
НУББШУСБ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
НУБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сан
НУБХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
НУБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
НУБЭХС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийн Хөгжлийн Сан
НЭТ	Нялхсын Эндэгдлийн Түвшин
НҮЭМС	Нөхөн Үржихүйн Эрүүл Мэндийн Судалгаа
ОУВС	Олон Улсын Валютын Сан
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
СЭЗЯ	Санхүү Эдийн Засгийн Яам
ТББ	Төрийн Бус Байгууллага
ТХЖ	Тэгшитгэсэн Хувийн Жин
ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
ҮТС	Үндэсний Тооцооны Систем
ҮЦБ	Үндэсний Цэвэр Бүтээгдэхүүн
ХААХОУС	Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Олон Улсын Сан
РРР	Худалдан Авах Чадварын Паритет (орчуулга)
ХДХВ/ДОХ	Хүний Дархлал Олдмол Хомсдолын Вирус/Дархлалын Олдмол Хам Шинж
ХХИ	Хүний Хөгжлийн Индекс
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХЯИ	Хүний Ядуурлын Индекс
ШОУХА	Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлаг
ЭЗӨДЯБС	Эдийн Засгийн Өсөлтийг Дэмжих, Ядуурлыг Бууруулах Стратеги
ЭЗХТЗ	Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭЭТ	Эхийн Эндэгдлийн Түвшин
ЯБСББ	Ядуурлыг Бууруулах Стратегийн Баримт Бичиг
ЯБҮХ	Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөр
ЯСН	Ядуурлын Судалгааны Нэгж

Зураглал-1. Хүн амын нягтрал аймаг, хотоор, 2000



Эх үүсвэр: Хүн ам, орон сууцны тооллого, 2000, УСГ

Монгол улс шилжилтийн эхний жилүүдэд буюу 1990-1994 онд бодит орлого буурах, ажилгүйдэл эрс ихсэх, хүний амьжиргааны нөхцөл байдал доройтох зэрэг хүндрэл бэрхшээлтэй тулгарч байсан хэдий ч тэдгээрийг даван туулж, эдүгээ зах зээл шинээр нээгдэж, хувийн хэвшил хөгжин цэцэглэх боломжтой орон боллоо. Гэвч энэ бүхний хажуугаар бий болсон шинэхэн үзэгдэл нь хот, хөдөөд хүн амын амьдралын чанарт мэдэгдэхүйц ялгаа гаран, гүнзгийрэх болсон явдал билээ. Энэ удаагийн Хүний Хөгжлийн Үндэсний Илтгэлийн сэдэв болсон хот, хөдөөгийн ялгаатай байдлыг арилгах явдал бол хүний хөгжлийг хурдасгах, Монголын ард түмний өөдрөг, гэрэлт ирээдүйг баталгаажуулах үндэс суурийг тавьж өгөх ач холбогдолтой юм.

Өнгөрсөн хугацаанд Монгол улсын хүний хөгжилд нэлээд ахиц гарчээ. 1999 онд Хүний Хөгжлийн Индекс 1990 оны түвшинд хүрч улмаар түүнээс давсан байна. 1990 онд нялхсын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 64.4 байснаа тууштай буурч 1994 онд 48.0, 2002 онд 29.9 болжээ. Бичиг үсэгт тайлагдалтын түвшин 2000 он гэхэд 98.0 хувьд хүрсэн бөгөөд энэ үзүүлэлт эрэгтэйчүүдийн хувьд 98.5, эмэгтэйчүүдийн хувьд 97.5 хувь байв. Сургуульд суралцагсдын дунд охидын тоо хөвгүүдийнхээс давамгайлдаг бусад орнуудад тэр бүр тохиолдоод байдаггүй “жендэрийн урвуу харьцаа” манайд түгээмэл ажиглагдаж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч, 2002 онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт 4.0 хувьд хүрсэн нь өмнөх жилүүдтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Гэвч энэ нь ядуурлыг бууруулахад шаардагдах 5.5 хувьд хүрээгүй байна. Түүнчлэн орлогын ядуурлыг бууруулахад ч дорвитой ахиц гарсангүй. Сүүлийн жилүүдэд орлого хуваарилалтад тэгш бус байдал нэмэгдэхийн зэрэгцээ ядуурлын гүнзгийрэлт, тархалт буурахгүй байна. 1995 онд ядуурал нийт хүн амын 36.2 хувийг хамарч байсан бол 1998 онд ялимгүй буурч 35.6 хувь болжээ.

Монголын эмэгтэйчүүд бусад орны эмэгтэйчүүдтэй харьцуулахад хүйсээр ялгаварлан гадуурхагдах явдал төдийлэн нэрвэгдээгүй байна. Социализмын үед болон сүүлийн жилүүдэд авч явуулсан арга хэмжээний үр дүнд эмэгтэйчүүдийн байдалд нэлээд ахиц дэвшил гарчээ. Гэвч өрнөн гарсан өөрчлөлтүүд, тэдгээрийн үр дүн эмэгтэйчүүдийн хувьд тэр бүр нааштай байсангүй. 1998 онд ядуу эмэгтэйчүүдийн эзлэх хувь (44.0 хувь) ядуу эрэгтэйчүүдийнхээс (21.0 хувь) хоёр дахин их байв. Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1990 онд 23.0 байсан бол 2000 онд 10.0 хувь болтлоо буурчээ.

Хот, хөдөөгийн хүн амын амьдралын чанар илт ялгагдах боллоо. Хэдийгээр ядуу хүн амын ихэнх нь хот сууринд байгаа ч хөдөөгийн хоцрогдол сэтгэл сэрхийлгэсээр байна. 2002 онд Монгол улсын ДНБ-ий 61.6 хувийг хот сууринд, ердөө 38.4 хувийг хөдөө орон нутагт үйлдвэрлэжээ. Гэтэл 1998 оны

байдлаар хотын ядуурал (39.4 хувь) хөдөөгийн ядуурлаас (32.6 хувь) өндөр байв. Нэн ядуу хүн амын тэн хагасаас илүү (57.0 хувь) хувь нь хот суурин газарт, тэдгээрээс 26.0 хувь нь нийслэл хотод суурьшиж, харин ядуу иргэдийн 43.0 хувь хөдөө орон нутагт амьдарч байна. 2000 онд эхийн эндэгдлийн бараг тал хувь нь малчин өрхүүдэд ногдож байсан бөгөөд тэдгээр өрхүүд хамгийн ойрхон эмнэлэгт морь, мотоциклоор хэдэн цаг явж хүрдэг. Хот суурин газар оршин суугчдын 60.0 хувь нь төвлөрсөн халаалттай, халуун усанд орох бололцоотой байранд амьдарч байхад энэ үзүүлэлт аймгуудад 32.0 хувьтай, харин сум, багуудад ийм боломж бараг байхгүй юм. Хот суурин газрын гэр хороололд амьдрагсдын 4.0 хувь, аймгуудад 10.0 хувь, сум, багуудад 2.0 хувь нь телефон утас хэрэглэж байна.

Газар зүйн хийгээд байр зүйн нөхцөл байдал нь Монгол улс даяар орон зайн ихээхэн ялгааг бий болгож байна. Өргөн уудам нутагт хүн ам нь сийрэг тархан суурьшсан нөхцөлд дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ үзүүлэх нь өндөр өртөг зардал шаардсан ажил бөгөөд хөдөөгийн эдийн засаг нь сулхан, хөгжил дорой Монгол улсын хувьд хатуухан сорилт юм. Монгол улсын хүн амын дийлэнх нь тархай бутархай нүүдэллэн, алслагдмал суурьшин амьдардаг учир эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, хямд төсөр барааг ядуу хүн амд хүргэхэд бэрхшээлтэй. Монголын хүн амыг өөр хооронд нь алслаж буй уудам орон зайн учруулж байгаа бэрхшээлийг “нутаг холын зовлон” гэж нэрлэх нь түгээмэл. Мал аж ахуй, газар тариаланг түшиглэн амьжиргаагаа залгуулж буй хөдөөгийн хүн амын эмзэг байдалд цас зудтай урт өвөл, ахар богино зун, шороон шуурга, ган гачиг зэрэг эрс тэс цаг агаарын нөхцөл байдал улам нэрмээс болж байна. Хөдөө орон нутагт хүн амын нягтрал бага, хоорондоо алслагдмал амьдардаг тул нийгмийн суурь үйлчилгээний зардал өндөр байна. Тухайлбал, хөдөө орон нутагт хотынхтой харьцуулахад бензиний үнэ 10.0-20.0 хувиар өндөр байна.

Бүх салбарыг хамарсан эдийн засгийн өөрчлөлтийн хариуд монголчуудын нэлээд нь шинэ боломж, бололцоо хайн өөр газар руу шилжин суурьших цар хүрээ улам бүр тэлсээр байгаа ба албан бус секторт ажиллах, төрөлтөө цөөлөх, мал маллаж амьжиргаагаа залгуулах зэргээр дасан зохицохыг чармайж байна. Сүүлийн 10 жилд монголчууд цөөн хүүхэд төрүүлэх, төрөлт хоорондын зайгаа уртасгах болсноор төрөлтийн түвшин огцом буурчээ. Малчид орлогын олон эх үүсвэртэй болох, өмч хөрөнгөө зарах, төрөл садангийн харилцаа холбоогоо зузаатгах, мөнгө хүүлэгчээс зээл авах зэргээр өөрчлөгдөн буй нөхцөл, хямралт байдалд хариу барьсаар иржээ. Албан бус сектор шинээр үүсэн бий болж, цар хүрээгээ тэлэн улмаар олон хүнийг тэр дундаа өндөр ур чадвар, боловсролтой эмэгтэйчүүдийг ажлын байраар хангах нэг эх сурвалж болох боллоо. Гэсэн хэдий ч урсгалаараа

хөгжиж буй энэ сектор хүмүүсийн эдийн засгийн аюулгүй байдлыг тэр бүр хангаж чадахгүй байна. Монголчууд хотоос хөдөө рүү олноороо нүүн суурьшиж байсан бол сүүлийн 10 жилийн эцсээр хөдөөнөөс хот руу чиглэх болжээ. Түүнээс гадна зах хязгаараас төв рүү, хотоос гадаад руу шилжин нүүх боллоо. Энэхүү нүүдэл суудлын дүнд хүн амын нэлээд хэсэг улам эмзэг байдалд орж, эдийн засгийн баталгаа нь алдагдаж байна.

Өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал, ядууралтай тэмцэхэд чиглэсэн хэд хэдэн бодлогын арга хэмжээг Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлжээ. Гэвч хот, хөдөөгийн тэгш бус байдлыг багасгахдаа ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлтийг дэмжих, тэнцвэртэй хөгжлийг хангах, төвлөрлийг сааруулах болон хүний хөгжлийг санхүүжүүлэх гэсэн дөрвөн чиглэлд онцгой анхаарал тавих шаардлагатай байна.

Ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлтийг дэмжих

Монгол улс макро эдийн засгийн удирдлагад хамаарах бүтэц, зохион байгуулалтын зарим өөрчлөлтийг хийх шаардлагатай байна. Ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлтийг дэмжихэд дараах тодорхой алхмуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүнд:

- Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын дүрэм, журмын хүрээнд тарифыг оновчтой тогтоох, үндэсний валютын ханшийг бууруулах зэргээр өрсөлдөх чадварыг дэмжих;
- Төрөөс хөдөө орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээний дэд бүтцийг барьж байгуулах явдлыг нэмэгдүүлэх, тухайлбал, малчдын хоршоолсон үйлдвэрлэлийг дэмжих (худаг, мал эмнэлгийн үйлчилгээ гэх мэт);
- Хүн амыг ажлын байр, орлогоор хангаж буй хувийн хэвшил, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, тухайлбал, бизнесийн зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;
- Аж үйлдвэрийг дэмжихэд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах зорилгоор зохистой бодлого, урамшууллын механизмыг хэрэгжүүлэх;
- Эдийн засгийн үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Хүний хөгжилд сөргөөр нөлөөлж буй тэгш бус байдлыг багасгах зорилгоор нийгмийн салбарын зардлын зориулалт, бүтцийг оновчтой тогтоох.

Тэнцвэртэй хөгжлийг дэмжих

Монгол улсын хувьд бус нутгуудыг тэнцвэртэй хөгжүүлэх нь хүн амын шилжих хөдөлгөөнийг зохицуулах хамгийн үр дүнтэй арга байж болох юм.

Энэ чиглэлд дараах тодорхой арга хэмжээг авах хэрэгтэй байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн маркетинг, агро бизнес болон боловсруулах үйлдвэрлэлийг бэхжүүлэх замаар хөдөөгийн хөгжлийг хурдасгах;
- Бэлчээрийн талхагдлаас сэргийлэх зорилгоор газрын шинэчлэлийн арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор худаг барих, мал аж ахуйн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулах;
- Малчдын хоршооллыг байгуулах, хөгжүүлэх замаар үр ашигтай бизнес эрхлэх бололцоог бий болгон баталгаажуулах;
- Хөдөөгийн аж ахуйн нэгжүүдийг санхүү, тээвэр, дэд бүтцийн бусад үйлчилгээгээр хангах;
- Зээл олгох, шинэ технологи, түүхий эд материал, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах зэргээр албан бус секторын өргөжилтийг дэмжих;
- Гэр хорооллын хүн амын хэт бөөгнөрөлийг багасгах, ахуйн нөхцлийг сайжруулах зорилгоор хотын орон сууц, дэд бүтцэд хөрөнгө оруулах.

Төвлөрлийг сааруулах үйл явцыг бэхжүүлэх

Энэ талаар дараах арга хэмжээг авах нь чухал юм. Үүнд:

- Аймаг, орон нутгийн захиргааны албан хаагчдын ажлын болон удирдан зохион байгуулах чадавхийг нэмэгдүүлэх;
- Орон нутаг төсвөө бүрдүүлэх, захиран зарцуулах, нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, хөгжлөө төлөвлөх, бодлого боловсруулах үүрэг хариуцлага, эрх мэдлийг нэмэгдүүлэх;
- Засаглал, хөгжлийн чиг үүрэг, хариуцлагыг аль болохоор удирдлагын доод түвшинд шилжүүлэх;
- Төсвийн орлого бүрдүүлэх, хуваарилах үүрэг, хариуцлагыг төв, орон нутгийн хооронд оновчтой болгох;
- Орон нутгийн удирдлагад олон нийтийн идэвхитэй, бодитой оролцоог нэмэгдүүлэх явдлыг дэмжих;
- Ардчилалд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг улам гүнзгийрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авах.

Хөгжлийг санхүүжүүлэх нь

Хот, хөдөөгийн ялгаатай байдлыг багасгахдаа хөдөөд дэд бүтэц, нийгмийн суурь үйлчилгээний зардал илүү өндөр байдгийг харгалзан улсын төсвийг оновчтой хуваарилах шаардлагатай байна. Төр, засаг төсөвлөсөн хөрөнгийн ихээхэн хувийг энэ чиглэлийн хөрөнгө оруулалтад дайчлан хуваарилах хэрэгтэй. Ялангуяа,

- Төсвийн зарцуулалтыг аймгийн бус, бүс нутгийн хэмжээнд төлөвлөж, хурдацтай тэгш хөгжлийг хангахуйц байдлаар тодорхойлох;
- Иргэдийн төлөөлөгчдийн хурал, гүйцэтгэх болон шүүх засаглалын байгууллагуудыг ажиллуулахад шаардлагатай зардлыг бодитойгоор тооцох;
- Нийгмийн суурь үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжин, эрчимжүүлэх;
- Тэгш бус байдлыг багасгах зорилгоор хөрөнгө нөөцийг хуваарилах нарийвчилсан бодлоготой болох;
- Гадаадын зээл тусламжаас хараат байдлыг багасгаж, түүний зориулалтыг оновчтой болгох;
- Гадаад өрийн байдалд хяналт тавьж, дарамтыг нь аль болох багасгах;
- Зээл тусламжийн үр ашгийг дээшлүүлж, менежментийг нь сайжруулахад төрөөс анхаарах.

Орон зайн ялгаанаас үүдэлтэй асуудлуудыг шийдвэрлэх нь улс орны хүний хөгжлийн талаарх олон санаачлагыг цаашид тууштай хэрэгжүүлэх суурь нь болж өгнө. Иймд манай улсын өмнө олон сорилт тулгарч байгаа нь эргэлзээгүй. Гагцхүү хөгжлийн үр шимийг хот суурин газрын давуу эрхтэй бүлгүүд бус нийт хүн ам адил тэгш хүртэхэд төр, засаг анхаарлаа хандуулах ёстой. Ингэснээр монголчууд бид цэцэглэн хөгжих ирээдүйгээ цогцлон баталгаажуулах болно.



БҮЛЭГ 1

ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БАЙДАЛ



Хүний хөгжлийн байдал

“Ард түмэн бол аливаа үндэстний жинхэнэ баялаг мөн. Тийм ч учраас хөгжлийн зорилго нь хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино.” Анх удаа 1990 онд хэвлэгдэн гарсан дэлхийн Хүний хөгжлийн илтгэл ингэж эхэлдэг. Удаа дараагийн хүний хөгжлийн илтгэлүүд хөгжил дэвшлийг үнэлж цэгнэхдээ зөвхөн эдийн засгийн өсөлтийн хандлагыг харах биш сонголтын хүрээг өргөжүүлэх, хүний чадавхийг нэмэгдүүлэх, хүний эрхийг хангах, эрх чөлөөг нь өргөжүүлэх зэрэг цогц асуудлыг түлхүү анхаарч ирсэн билээ.

Шилжилтийн эхэн үе болох 1990-1994 онд бий болсон бодит орлогын бууралт, ажилгүйдлийн өсөлт, амьжиргааны доройтол зэрэг хүнд бэрхийг Монгол улс даван туулаад байна. 1995 оноос ДНБ алгуур өсч, инфляци хяналтанд орж хувийн хэвшил бэхжлээ. Нийгмийн салбарт ч иймэрхүү эерэг хандлагууд илэрхий байна. Анхан шатны сургуульд хамрагдалтын түвшин 1990 оноос огцом буурч байснаа аажмаар өсч, сургууль завсардалт буурах хандлагатай боллоо. Дархлаажуулалтын хамрах хүрээ өндөр түвшинд хадгалагдаж, хүүхдийн амьдрах магадлал нэмэгдэв.

1990-1994 онд Монгол улс шилжилтийн эхэн үеийн хамаг хүнд бэрхийг даван туулсан юм.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг сэргэснээр 2002 онд ДНБ 4.0 хувиар өсчээ. Гэвч Монгол улсын эдийн засгийн үндэс суурь нь сул дорой хэвээр байна. Ядуурлыг бууруулах талаар ялимгүй ахиц гарсан боловч тэгш бус байдал газар авсаар байна.

Хүний хөгжлийн хандлага

1990 оноос өмнөх үеийн хүний хөгжил

Монгол улс 1921-1990 он хүртэлх олон арван жилийн туршид улс төрийн нэг намын тогтолцоо ноёрхсон, Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) болон Эдийн Засгийн Харилцан Тусалцах Зөвлөл (ЭЗХТЗ)-тэй нягт харилцаа бүхий орон байв. 1990 он хүртэлх социализмын жилүүдэд эрүүл мэнд, боловсрол, жендэрийн тэгш байдал, нийгмийн хамгаалал, хүний аюулгүй байдал зэрэг салбарт бахдам амжилтыг олсон билээ. Хүний хөгжлийн үүднээс авч үзвэл, социализмын үеийн гол ололтууд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт гарчээ. 1960 онд дундаж наслалт 46.7 байснаа 1990 онд 63.7 болжээ. Мөн хугацаанд насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин 97.8 хувь болж өссөн байна. Хүн ам бараг бүхэлдээ эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэж, жирэмсэн эмэгтэйчүүдийн 98.0 хувь нь төрөхийн өмнөх үйлчилгээг авч, нэг хүртэлх насны хүүхдийн 87.0 хувь халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдан, хоол тэжээлийн хомсдол ховор тохиолдож байв. Тухайн үеийн бодлогын дагуу монголчууд найман жилийн албан боловсролыг эзэмшиж байжээ. Ажилгүйдэл, орлогын ядуурал бүртгэгдэж байсангүй.

1990 он хүртэлх социализмын жилүүдэд эрүүл мэнд, боловсрол, жендэрийн тэгш байдал, нийгмийн хамгаалал, хүний аюулгүй байдал зэрэг салбарт бахдам амжилтыг олсон билээ.

Нүүдлийн амьдралын хэв шинж зонхилсон, хүн амынх нь нягтрал туйлын бага, газар зүй болон байр зүйн нөхцөл байдлын улмаас нийгмийн суурь үйлчилгээг хүн амд хүргэхэд нэн бэрхшээлтэй манай орны хувьд боловсрол, эрүүл мэндийн суурь үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгож чадсан нь чамлахааргүй ололт юм. Өнөөгийн байдлаар нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 1.6 хүн ногдож, хүн амынхаа нягтралаар дэлхийд хамгийн доогуур орнуудын тоонд багтаж байна.

Социализмын үед жендэрийн тэгш байдлын талаар бас гайхамшигтай амжилт олсон юм. Энэ үед квотын системийг хэрэгжүүлэх замаар шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангаж байв. 1989 онд эмэгтэйчүүдийн 95.0 хувь бичиг үсгийн мэдлэгтэй, 86.0 хувь нь хөдөлмөр эрхэлж байжээ. Их, дээд сургууль төгсөгчдийн 43.0 хувь эмэгтэйчүүд байсан бөгөөд боловсрол, эрүүл мэндийн мэргэжлүүдэд тооны хувьд зонхилж байв.

Аж үйлдвэржилтийн хурдцаар нь хэмжвэл эдийн засгийн салбар дахь засаг төрийн үйл ажиллагаа нэлээд амжилттай байсан боловч хүн амын хэрэглээг хангахын тулд их хэмжээний шууд татаасыг хуучин ЗХУ-аас авахаас өөр аргагүй байлаа. Монополь шинжтэй улсын үйлдвэрийн газрууд зонхилж, жижиг аж ахуй, албан бус сектор гэж байсангүй. Үндэсний цэвэр бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин 1940 онд 7.0 хувь байснаа 1985 онд 35.0 хувь болж өсчээ. Харин хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт ихээхэн дутмаг байлаа. Хөдөө аж ахуйн салбарын өсөлтийн хурд хүн амын өсөлтийн хурдаас хоцорч байв. Улсын өмчид тулгуурласан, өндөр механикжуулалт бүхий цөөн тооны сангийн аж ахуйнууд хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж чадаагүй юм. Дотоодын худалдааны нөхцлүүд хөдөөгийн эдийн засаг, мал аж ахуйн салбарт тааламжгүй байлаа. 1991 он хүртэлх гучаад жилийн турш хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэгчдээс бүтээгдэхүүнийг нь худалдан авах үнэд онцын өөрчлөлт гараагүй байна. Хөдөөгийн эдийн засаг улс ардын аж ахуйн бусад салбараас ихээхэн тусгаарлагдмал шинжтэй байсан нь одоо ч хэвээрээ байна. Хэдий тийм боловч төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооны үед мал аж ахуйг дэмжих хүрээнд худаг ус, мал эмнэлэг, малын гэжээл зэрэг суурь үйлчилгээг хангаж байв. Хязгаарлагдмал шинжтэй байсан энэ үйлчилгээ шилжилтийн жилүүдэд бүрмөсөн устаж үгүй болсон нь 1990-ээд оны сүүлээр тохиолдсон зудын гамшгийн нөлөөг гааруулсан гэвэл хилсдэхгүй биз ээ.

Хүний хөгжлийн үүднээс, социалист тогтолцооны хамгийн учир дутагдалтай тал нь хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж байсан явдал юм. Нэг

намын үзэл суртлын тогтолцоо хувь хүний үг хэлэх эрх, улс төрийн оролцоог хязгаарлаж байв. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө ч хориг хязгаартай байлаа. Иргэн хүний хувийн санаачилга гаргах, аж ахуй эрхлэх явдлыг ч боогдуулж байв. Үүнээс гадна иргэдийн зүгээс засаг төрдөө хандаж шаардлага тавих боломж ч хомс байсан юм.

1990 оноос хойшхи үеийн хүний хөгжил

Хүний хөгжлийн үүднээс авч үзвэл, социалист тогтолцооны хамгийн дутагдалтай тал нь хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж байсанд оршино.

1990 онд ЗХУ болон ЭЗХТЗ задран унасны дараа, ардчиллын давалгаанд автан, төрийн хатуу чанд хяналтыг устгахыг эрмэлзэн, зах зээл хэрэглээний сонголтыг нэмэгдүүлж хүний хөгжлийг хурдасгана гэсэн найдлагадаа хөтлөгдөн Монгол улс бусад улс орнуудын нэгэн адилаар шилжилтийн огцом өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн юм. 1990-ээд оны эхэн үеийн ардчилсан хөдөлгөөний үр дүнд олон нам оролцсон анхны сонгууль болж, шинэ “Үндсэн хууль” батлагдаж, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц өрнөв.

“Цочроох эмчилгээ”-ний аргаар хийсэн эдийн засгийн шилжилт Монгол улсад аж үйлдвэрийн уналт, нийгмийн үйлчилгээний хомсдол, ажилгүйдлийн огцом өсөлт зэргийг араасаа дагуулав. Өөрчлөн байгуулалт, шилжилтийн эхний жилүүд болох 1990-1994 онд хүний хөгжлийн үзүүлэлтүүд эрс муудлаа. Бодит орлого буурч, хүний баталгаагүй байдал нэмэгдэж, хөдөлмөр эрхлэх боломж хумигдахын хэрээр хүмүүсийн амьдрал улам бүр эрсдэлтэй болжээ. Социализмын үеийн ололт амжилт нь 1990-ээд оноос өмнө гаднаас үзүүлж байсан ихээхэн хэмжээний дэмжлэг туслалцаа, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын зах зээлд баталгаатай борлодог экспорт зэрэгтэй шууд холбоотой байлаа. 1990 онд дээрх гадны тусламж гэнэт зогссоноор улс орныг бүхэлд нь хамарсан социалист хэв загварын нийгэм хангамжийн далайцтай сүлжээг өөрийн хязгаарлагдмал нөөцөд тулгуурлан хадгалж үлдэх боломжгүй болсон юм. Цаашилбал, үндэсний үйлдвэрлэлийн олон салбар өрсөлдөөн бүхий гадаад зах зээлд гарах чадваргүй буюу тоног төхөөрөмжийн хувьд хоцрогдсон байв. Ийнхүү нийгмийн үйлчилгээний түвшин доройтсон, улсын үйлдвэрийн газрууд хаагдснаас хөдөлмөр эрхлэлт буурсан зэрэг үйл явдлууд давхцсан нь Монгол улсад ядуурал, хүний баталгаагүй байдал зэрэг өнөөгийн хүндрэлтэй асуудлуудыг бий болгожээ.

Улс орны нөхцөл байдал 1995 оноос тодорхой хэмжээгээр сэргэж, Монгол улс шилжилтийн эхэн үеийн хүнд бэрхийг юутай ч даван туулж чадлаа. Сайжруулж хараахан чадаагүй боловч, хүмүүсийн амьжиргааны түвшин нэлэнхүйдээ доройтож байсан явдлыг зогсоолоо. Улсын сектороос чөлөөлөгдсөн ажиллах хүчний зарим хэсгийг хөдөө аж ахуйн салбар, хувийн болон албан бус секторууд шингээх

болов. 1995 оноос инфляцийн түвшин буурч, ДНБ-ий өсөлт бий болж, хувийн хэвшил хөгжиж эхэллээ. Иймэрхүү ахиц байгаа боловч Монгол улсад хүний чадамжийг нэмэгдүүлэх, амьжиргааных нь чанарыг дээшлүүлэх талаар хийх ажил их байна.

Хүний хөгжлийг хэмжихүй

Хүний хөгжлийн илтгэлүүд 1990 онд хэвлэгдэж эхэлсэн цагаас хүний хөгжлийн индекс (ХХИ)-ийг хүний хөгжлийн ерөнхий шалгуур үзүүлэлт болгон ашиглах болсон юм. ХХИ нь улс орнуудын хүний хөгжлийн түвшинг урт наслалт, боловсролын түвшин (насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлагдалт ба анхан, дунд, дээд шатны сургуульд хамрагдалтын түвшин) болон нэг хүнд ногдох ДНБ гэсэн гурван үндсэн үзүүлэлтээр хэмждэг.

1999 он хүртэл Монгол улсын ХХИ 1990 оны түвшингээс ахиж чадсангүй.

2003 оны дэлхийн “Хүний хөгжлийн илтгэл”-д ХХИ-ээрээ Монгол улс нийт 175 улсаас 117 дугаар байрт оржээ. Шилжилтийн эдийн засагтай улс орнуудын ХХИ-ийн мэдээллийг илтгэлд хавсралтаар харуулав.

1999 он хүртэл Монгол улсын ХХИ 1990 оны түвшингээс ахиж чадсангүй. Харин сүүлийн жилүүдэд түүний хандлага сайжирсаар байна. Үндэсний статистикийн газар (ҮСГ)-ын тооцооноос үзвэл Монгол улсын ХХИ 2002 онд 0.679-д хүрчээ. Эдгээр үзүүлэлтийг доорх хүснэгтэд үзүүлээ.

Хүний хөгжлийн хэмжигдэхүүнүүд

1990 оноос хойш Монгол улсад хүн ам зүйн ихээхэн өөрчлөлт гарав. Тус улсын эдийн засгийн идэвхитэй хүн ам харьцангуй залуу юм. 2002 оны эцэст бүртгэгдсэн 2.5 сая орчим хүн амын 38.0 хувь нь 16-аас доош насныхан, 55.0 хувь нь хөдөлмөрийн насныхан байлаа. Төрөлтийн нийлбэр коэффициент 1989 онд 4.6 хувь байснаа 2002 онд 2.1 хувь болж огцом буурав. 1989 онд 1000 хүн ам тутамд ногдох төрөлт 36.5 хүрч байсан бол одоо 20.6 хүртэл буурчээ.



Хүснэгт 1.1 Монгол улсын хүний хөгжлийн индекс

Он	Дундаж наслалт (жилээр)	Насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлагдалт (15- аас дээш насныхан, %)	Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин	Нэг хүнд ногдох ДНБ (PPP, ам. доллар)	Дундаж наслалтын индекс	Боловсролын индекс	ДНБ-ий индекс	ХХИ
1990	63.7	96.5	60.4	1640	0.645	0.845	0.467	0.652
1992	62.8	97.7	54.3	1266	0.638	0.824	0.424	0.626
1995	63.8	98.9	57.0	1267	0.647	0.849	0.424	0.635
1998	65.1	96.5	62.0	1356	0.669	0.850	0.435	0.651
1999	63.2	97.8	66.0	1707	0.636	0.872	0.472	0.661
2000	63.2	97.8	69.6	1838	0.636	0.884	0.486	0.669
2001	63.4	97.8	69.6	1968	0.639	0.884	0.497	0.674
2002	63.5	97.8	69.7	2125	0.642	0.884	0.510	0.679

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, YCG.

Шинээр мэндэлж буй хүүхдийн тоо 1990-2002 онд 73209-аас 46922 болтлоо буурав. Мөн хугацаанд нас барсан хүн амын тоо 17559-ээс 15857 болж, 1000 хүн тутамд ногдох нас баралтын түвшин 8.5-аас 6.4 болж буурсан юм.

Хүний хөгжлийн зарим гол үзүүлэлтүүдэд гарсан ололт амжилтуудын талаар илтгэлийн дараагийн хэсгүүдэд авч үзэх болно.

Эсэн мэнд торнихуй

Монгол хүний дундаж наслалт 1990 онд 63.7 жил байснаа 1992 онд 62.8 хүртэл буурсан ч, 2002 онд 63.5 болж нэмэгдлээ.

YCG-ын мэдээллээс үзэхэд, нялхсын эндэгдэл тогтвортой буурч байгаа бөгөөд 1990 онд 1000 амьд төрөлт тутамд 64.4 нялхас эндэж байсан бол 1994 онд 48.0, 2002 онд 29.6 болов.

Хүүхдийн эндэгдэл буурсан боловч эхийн эндэгдэл буурсангүй.

Эдгээр үзүүлэлтийг иргэний бүртгэл мэдээлэлд тулгуурлан тооцож гаргасан болно.

Эхийн эндэгдэл Монгол улсад нэлээд өндөр хэлбэлзэлтэй байна. 1985-1990 онуудад эхийн эндэгдлийн түвшин (ЭЭТ) 1000 амьд төрөлтөд 1.5-1.2-ын хооронд байжээ. Энэ үзүүлэлт 1993 онд 2.4 хүртэл огцом нэмэгдсэн нь шилжилтийн эхэн үеийн эмгэнэлт байдлын тусгал юм. Үүнээс хойш энэ үзүүлэлт аажмаар буурч, 1000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 1997 онд 1.4, 2002 онд 1.2¹-д хүрчээ. Хэдийгээр ийм ололттой, мэргэжлийн тусалцааг бараг бүх төрөлтөд үзүүлж байгаа боловч төрж буй эхийн аюулгүй байдлын талаар санаа зовоох асуудлууд байсаар байна. Эхийн эндэгдлийн бараг тэн хагас нь малчин эмэгтэйчүүдэд ногдож байгаа юм². Эрүүл мэндийн статистикийн 2002 оны мэдээллээс үзэхэд, эндсэн эхчүүдийн 40.0 хувь

жирэмсний хүндрэлийн улмаас, 28.0 хувь нь төрөхийн хүндрэлээс, 7.0 хувь нь төрсний дараах хүндрэлээс, 25.0 хувь нь бусад эмгэгээс шалтгаалан нас баржээ.

Эрүүл мэнд

Социализмын жилүүдэд бий болсон эрүүл мэндийн дэд бүтэц өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн боловч түүнийг шинэчлэн өөрчлөх шаардлагатай байна.

1990 оноос эрүүлийг хамгаалах тогтолцоо нийт хүн амд үнэ төлбөргүй эмнэлэгийн үйлчилгээг үзүүлэх боломжтой байв.

Социализмын жилүүдэд бий болсон эрүүл мэндийн дэд бүтэц өнөөг хүртэл хадгалагдан үлдсэн боловч, түүнийг шинэчлэн өөрчлөх шаардлагатай байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж жигд бус бөгөөд эмнэлгийн байгууллагууд гол төлөв нийслэл Улаанбаатар болон бусад томоохон хот, аймгийн төвд төвлөрчээ. Улсын хэмжээнд 2002 оны байдлаар нийтдээ 18616 ор бүхий 754 эмнэлэг, 6823 эмч ажиллаж байсан бөгөөд дунджаар 360 хүнд нэг эмч ногдож байгаа нь нэлээд сайн үзүүлэлт юм. Гэтэл нэг эмчид ногдох хүний тоо Улаанбаатарт 209, Орхон аймагт 314 байхад Архангай, Баянхонгор, Завхан, Хөвсгөл, Увс, Төв аймгуудад энэ үзүүлэлт 700-гаас давж гарчээ.

¹ Монголын эрүүл мэндийн алба 80 жил, 2001, ЭМЯ; Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2002, ЭМЯ.

² Эхийн эндэгдлийг бууруулах стратеги, 2001-2004, ЭМЯ.

Өнөө үед зүрх судасны болон хорт хавдрын өвчлөлүүд нас баралтын зонхилох шалтгаан болж, 2002 оны байдлаар нас барагсдын 58.0 хувь нь эдгээр өвчнөөр энджээ. Харин амьсгалын замын цочмог халдвар, суулгалт өвчин нялхсын эндэгдэлд зонхилсон хэвээр байна. 1998 онд хийсэн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа” (НҮЭМС)-ны дүнгээс үзэхэд, хот суурин газарт жирэмсэн эхчүүдийн бараг 98.0 хувь, хөдөө орон нутагт эхчүүдийн 92.0 хувь эмнэлэгт төржээ. Шинэ төрсөн нярайн 98.0 хувийг эх барих эмэгтэйчүүдийн болон бусад мэргэжлийн эмч, сувилагч эх барьсан байна.

Төрөхийн өмнөх хүндрэлийн голлох шалтгаанд шээс, бэлгийн замын халдвар, цус багадагт зэрэг өвчин багтаж байна. 1998 оны НҮЭМС-аас үзэхэд аймаг, сумын эмнэлэгт өвчний оношийг үнэн зөв тогтооход шаардлагатай наад захын лабораторийн тоног төхөөрөмж дутагдалтай байжээ. Эмийн хүрэлцээ, хангамж тааруухан, төмрийн болон фолийн хүчлийн бэлдмэл жирэмсэн эхчүүдэд хүрэлцээгүй байв.

Дээрх судалгаанд дурдсанаар бэлгийн замын халдвар (БЗХ), нэн ялангуяа, заг хүйтэн, тэмбүүгийн халдварын тархалт улсын хэмжээнд нэмэгдэв. 1991-2002 оны хооронд тэмбүүгээр өвчилсөн тохиолдол 10000 хүн тутамд 3.7-оос 6.7, заг хүйтнээр өвчилсөн тохиолдол 10000 хүн тутамд 9.4-өөс 19.6 болж өсчээ. Манайд ажилгүйдэл, ядуурал өндөр хэмжээнд байгаа нь БЗХ-ын тархалтанд нөлөөлж байна (нийт өвчлөгсдийн бараг тал нь ажилгүйчүүд, орон гэргүй хүмүүс юм).

Хүний дархлалын олдмол хомсдолын вирус (ХДХВ)-ын халдвар тархах эрсдэл өндөр байх угтвар нөхцөл бүрдчихээд байгаа өнөө үед энэхүү халдвараар өвчилсөн тохиолдол цөөн байгаад сэтгэл тайвшран суух боломжгүй юм. Ийм нөхцлүүдэд:

- Хүн амын талаас илүү хувийг 23-аас доош насныхан эзэлж байна;

- Биеэ үнэлэгчдийн тоо нэмэгдэж, насны хувьд залуужих болсон;
- Ажил хийх, худалдаа эрхлэх, сурч боловсрох зорилгоор хот, хөдөө, улс орнуудын хооронд зорчих хүн амын шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдсэн;
- Хар тамхийг судсаар хэрэглэх явдал түгээмэл болоогүй ч нэмэгдэх төлөвтэй;
- Сүүлийн жилүүдэд ХДХВ-ын халдварын тархац ОХУ, Казахстан, Хятад зэрэг хөрш орнуудад эрс хурдацтайгаар нэмэгдсэн зэргийг дурдаж болох юм.

Сүрьеэгээр өвчлөгсдийн тоо 10000 хүн тутамд 7.4 ногдож байснаа 14.9 хүрч 1991-2002 онд бараг хоёр дахин нэмэгдэн ноцтой асуудал болжээ. Өнөөдөр, Монгол улс сүрьеэгийн өвчлөлөөрөө Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын гишүүн орнуудаас Ази-Номхон далайн бүс нутагтаа тэргүүлж буй долоон орны нэгд тооцогдох боллоо³. Сүрьеэгээр өвчлөгсдийн дийлэнхи нь мөн л ажилгүй, ядуу хүмүүс байна. Хэдийгээр сүрьеэгийн эмчилгээ нэлээд үр дүнтэй байгаа боловч тохиолдлын тоо буурахгүй байна.

³ Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги, 2003. Монгол улсын Засгийн газар.

Хүснэгт 1.2 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хувиар

	Эмнэлгийн үйлчилгээ авч буй жирэмсэн эхчүүдийн эзлэх хувь			Төрсөн газар		Төрөх үед үзүүлсэн үйлчилгээ		
	Эмэгтэйчүү- дийн эмчээс	Бусад эмчээс	Нарийн мэргэжлийн эмчээс	Эмнэлэгт	Гэрт	Эмэгтэйчүү- дийн эмчээс	Бусад эмчээс	Нарийн мэргэжлийн эмчээс
Бүс нутаг								
Төв	45.6	16.9	26.5	93.3	5.1	39.4	11.9	41.4
Зүүн	39.2	13.3	42.3	94.8	5.0	30.7	18.0	44.5
Баруун	32.7	19.6	33.0	91.9	7.6	29.3	16.5	45.4
Өмнөд	50.5	8.6	27.2	95.3	4.7	40.1	6.5	48.7
Улаанбаатар	79.7	14.1	2.7	97.9	1.6	63.6	8.2	26.3
Байршил								
Хот	71.7	19.9	3.5	97.7	1.9	59.1	9.3	29.3
Хөдөө	33.7	13.9	38.9	91.8	7.0	28.8	14.8	47.4
Бүгд	48.4	16.2	25.2	94.1	5.1	40.5	12.7	40.4

Эх сурвалж: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, 1998, ҮСГ.

Хүүхдийн хоол тэжээлийн хангамж ерөнхийдөө харьцангуй сайн байгааг тоо баримтаас харж болно. Таваас доош насны хүүхдийн дотор жин багатай хүүхдийн тоо гурван хувиас бага байна. Энэ үзүүлэлт нь эхчүүд хоол тэжээлээр төдийлөн дутагдахгүй байгаагийн нэг илрэл. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн дунд цус багадаа өвчин түгээмэл шинжтэй байна. 2000 онд явуулсан “Хүүхэд ба хөгжил” судалгааны дүнгээс үзэхэд жирэмсэн эхчүүдийн 16 орчим хувьд цус багадалт илэрч, шинээр мэндэлсэн жин багатай эрэгтэй нярайн 23.0 хувь, эмэгтэй нярайн 18.0 хувь нь 2.5 кг хүрэхгүй жинтэй төржээ. Ажилгүйдэл өсч, үүнийг дагалдан орлого буурч, улмаар эмэгтэйчүүдийн нуруун дээрх ачааллыг нэмэгдүүлсэн нь хүүхдээ асарч бойжуулах боломжид сөргөөр нөлөөлж, хүүхдийн хооллолтын байдалд аюул учруулах боллоо гэж зарим судлаачид дүгнэж байна.

Хүн амын нэлээд хэсэг ундны цэвэр усаар гачигдах явдал манай орны аль ч бүс нутагт байна. 1998 оны “Амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа” (АТТС)-ны тайланд дурдсанаар нийт хүн амын бараг тэн хагас нь задгай худаг, гол мөрөн, бороо, цас зэрэг найдваргүй эх үүсвэрээс ундны усаа авдаг ажээ. Төвлөрсөн сүлжээ, дамжуулах хоолойноос усаа авч хэрэглэх боломж хот суурингийн ядуу иргэдийн зөвхөн дөрөвний нэгд, ядуу бусчуудын тэн хагаст байна. Ундны цэвэр усны хэрэглээний асуудал хот суурингийн гэр хорооллынхны хувьд нэн түвэгтэй байгаа юм.

1990 онд эрүүл мэндийн салбарын санхүүжилтын 70.0 хувь улсын төвлөрсөн төсвөөс санхүүжигдэж байсан бол 2002 онд 54.0 хувь хүртэл буурчээ.

Эрхэлдэг үйлдвэрлэл, үйлчилгээ нь байгаль цаг уураас хараат бус хэдий ч хүн ам, үйлдвэрлэл хэт төвлөрсний улмаас хотын оршин суугчид агаарын бохирдолд нэрвэгдэх боллоо. Агаарын бохирдол хотын хүн амын эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна. Нийслэл Улаанбаатар хотод жилдээ 5 сая гаруй тонн нүүрс хэрэглэдэг гурван цахилгаан станц, 80 гаруй мянган гэр, 250 гаруй уурын зуух 200 гаруй төрлийн хорт бодис, утаа ялгаруулж байна гэсэн тооцоо гарчээ. Үүний зэрэгцээ 40 мянга орчим автомашинаас ялгарах утаанд нүүрсхүчлийн дутуу исэл, хүнд металл агуулагдаж байдаг ажээ. Нийслэлийн агаарын бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс 5-10 дахин ихсэх тохиолдлын давтамж нэмэгдэв. Энэ бүхнээс шалтгаалж өвлийн улиралд нийслэл хотод амьсгалын замын өвчин, ханиад томуу, уушиг, зүрхний өвчний тархалт эрс ихсэх боллоо.

Эрүүл мэндийн салбарын зардал 1995 онд ДНБ-ий 3.1 хувьтай тэнцэж байсан бол 2002 оны байдлаар 4.7 хувьд хүрч өсчээ. 2001 онд эрүүл мэндийн салбарын зардал улсын төвлөрсөн төсвийн зарлагын 12.0 хувьтай тэнцэж байв. Эдүгээ эрүүл мэндийн салбарын зардлыг улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын хураамж, эрүүл мэндийн үйлчилгээний

төлбөр гэсэн гурван үндсэн эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа бөгөөд 1990 оноос хойш улсын төсвөөс эрүүл мэндийн салбарт зарцуулах зардлын хэмжээ нэлээд буурлаа. 2002 онд улсын нэгдсэн төсвийн зарлагын 10.6 хувь эрүүл мэндийн салбарт ногдож байв. Доорх дүрслэлд эрүүл мэндийн салбарын зардлын задаргааг харуулав.

Дүрслэл 1.1 Эрүүл мэндийн салбарын зардал, 2002



Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2002, Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар, ЭМЯ.

Боловсрол

Хүн амын бичиг үсэгт тайлагдалт Монгол оронд хот хөдөөгүй бараг адил, нэлээд өндөр түвшинд байгаа боловч шилжилтийн жилүүдэд сургууль завсардалт нэмэгдэв. 2000 оны байдлаар нийт хүн амын 98.0 хувь (эрэгтэйчүүдийн 98.5 хувь, эмэгтэйчүүдийн 97.5 хувь) бичиг үсгийн мэдлэгтэй байсан нь социализмын үеийн боловсролын тогтолцооны үр нөлөө юм. Дундговь аймагт энэ үзүүлэлт хамгийн бага 96.5 хувьтай, Дархан, Эрдэнэт хотуудад хамгийн өндөр 99.0 хувьтай байгаа нь хамгийн бага ба өндөр үзүүлэлтүүд бөгөөд аймаг, хотуудад зөрүү нь ийнхүү маш бага байна. Хөдөө талдаа нүүдлийн амьдралтай, хүн ам нь туйлын сийрэг суурьшсан манай орны хувьд энэ нь үнэхээр том ололт юм. Ерөнхийдөө, суурь боловсролыг бүх нийтэд үнэ төлбөргүй олгосон хэвээр байгаа билээ.

Шилжилтийн эхний жилүүдэд ЗХУ-ын дэмжлэг, туслалцаа гэнэт зогссоны улмаас боловсролын салбар ихээхэн бэрхшээлтэй тулгарч, сургуулиудыг дулаанаар хангах, ашиглалтын зардлыг нь санхүүжүүлэх эх үүсвэр хомс болсон юм. Цаашилбал, малыг хувьчилснаар малаа маллуулах зорилгоор хөвгүүдээ сургуулиас гаргах нь олширч, сургууль завсардалт нэмэгдэв. Нэгээс гуравдугаар ангийн сурагчдын тоо 1990-1995 онд 233000-аас 187900 болж буурчээ. 1990 онд 8-15 насны хүүхдүүдийн 98.6 хувь сургуульд хамрагдаж байсан бол энэ үзүүлэлт 1995 онд 84.3 хувь хүртэл буурав. 1990-1995 онд сургууль завсардалт нэмэгдсний өөр нэгэн шалтгаан нь хөдөөгийн сургуулиуд дотуур байрныхаа зардлыг нөхөх зорилгоор үйлчилгээгээ төлбөртэй болгосон

явдал юм. Хэдийгээр дээрх төлбөрийг маш доогуур хэмжээнд тогтоосон боловч бодит орлого буурч, ажилгүйдэлд нэрвэгдсэн ядуу өрхүүдийн хувьд энэ нь амаргүй ачаа болсон билээ.

Улс орон даяар охидын сургуульд хамрагдсан байдал хөвгүүдийнхээс илт давамгайлж байгаа бөгөөд хүйсийн тэнцвэргүй байдал үүссэн нь Монголын нэгэн өвөрмөц онцлог юм.

2002 оны байдлаар улсын хэмжээний нийт 668 цэцэрлэг, яслид сургуулийн өмнөх насны 88711 хүүхэд хүмүүжиж байв. Улсын хэмжээгээр жигд байдлаар тархан байршсан ерөнхий боловсролын 688 сургуульд 527931 гаруй хүүхэд суралцаж байлаа. Түүнчлэн, 2003 онд мэргэжлийн анхан, дунд шатны сургуулиудад 19493 оюутан залуус суралцаж байна. 2002 оны байдлаар нэг багшид ногдох сурагчийн тоо бага сургуулиудад 32, дунд сургуулиудад 23 байсан нь зохистой, хэвийн хэмжээний үзүүлэлт юм. Энэ харьцаа аймгуудад бараг ялгаагүй шахам байна.

Манай орны аймаг бүрт сургуульд суралцагсдын дунд охидын тоо хөвгүүдийнхээс илт давамгайлсан жендэрийн өвөрмөц харьцаа бий болжээ. Боловсролын шат ахих тусам энэ байдал улам бүр нэмэгдэж, охидын тоо хөвгүүдийнхээс хол давах нь ердийн үзэгдэл болсон байна.

Боловсролын салбарын нийт зардал 1995 онд ДНБ-ий 4.6 хувийг эзэлж байснаа 2001 онд 8.8 хувьд хүрч өсчээ. “Боловсролын тухай хууль”-д заасны дагуу улсын төсвийн зарлагын 20-иос доошгүй хувийг энэ салбарт зарцуулах ёстой. Гэтэл 2002 оны байдлаар боловсролын салбарт улсын төсвийн зарлагын 18.9 хувь ногдож байлаа. Салбарын зардлын задаргааг доорх дүрслэлд үзүүлэв.

Дүрслэл 1.2 Боловсролын салбарын зардал, 2002



Эх сурвалж: 2003, Макро эдийн засаг, бизнес статистикийн газар, ҮСГ.

Эдийн засаг

Шилжилтийн эхний жилүүдэд Монгол улсын ДНБ-ий хэмжээ огцом буурч, 1991 онд 9.2 хувиар,


1992 онд 9.5 хувиар багассан юм. Түүнээс хойш сэргэх төлөв ажиглагдаж байгаа боловч сүүлийн жилүүдийн өсөлтийн хурд удаан байна. ДНБ-ий бодит хэмжээ 2001 онд 1.0 хувиар, 2002 онд 4.0 хувиар өсөв. Хүн амын өсөлтөөс шалтгаалан нэг хүнд ногдох ДНБ-ий бодит өсөлт харьцангуй доогуур хэмжээнд байсан төдийгүй зарим жилүүдэд бууралттай байсныг тэмдэглэх нь зүйтэй юм.

2002 онд ДНБ 4.0 хувиар өссөн нь өмнөх онуудынхаас өндөр үзүүлэлт юм.

“Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги”-д тусгасны дагуу ДНБ-ий өсөлт 2003 онд 5.5 хувьд хүрэх ажээ. Энэ нь хүрвэл зохих түвшингийн доод хязгаар бөгөөд сүүлийн жилүүдийн өсөлт үүнээс доогуур байгаа юм.

1995-2002 онд ДНБ-ий бүтцэд нэлээд томоохон өөрчлөлтүүд гарав. 1995 оны байдлаар ХАА-н салбар ДНБ-ий 37.1 хувийг үйлдвэрлэж байсан бол 2002 онд 20.0 хувийг үйлдвэрлэжээ. 1995-1999 онд мал аж ахуйн салбар дангаараа ДНБ-ий 37.0-38.0 хувийг үйлдвэрлэж байв. Гэвч сүүлийн жилүүдэд тохиосон байгаль, цаг уурын хүндрэл бэрхшээлийн улмаас энэ үзүүлэлт огцом буурчээ. Мөн хугацааны эхэнд үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь 34.5 байснаа 2002 онд 56.8 хувь хүрч өслөө. Сүүлийн жилүүдийн өсөлт нь уул уурхайн салбарын өсөлттэй нягт уялдаатай. Татварын орлогыг нэмэгдүүлж, үйлчилгээний салбарын үйл ажиллагааг идэвхижүүлж байгаа энэ салбар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд төдийлөн чухал үүрэг гүйцэтгэж чадаагүй байна.


Дүрслэл 1.3 ДНБ-ий өсөлт, 1989-2002



Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл, 1989-2002, ҮСГ.

2000, 2001 онд 8.0 орчим хувьд хэлбэлзэж байсан инфляцийн түвшин 2002 онд 1.6 хувь хүртэл буурсан нь 1991 оноос хойшхи хугацааны хамгийн хамгийн бага үзүүлэлт юм. Гэтэл инфляцийн түвшин 2003 оны 7-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар, 2002 оны эцэстэй харьцуулахад 5.2 хувиар өсчээ⁴. Монголд зээлийн хүүгийн түвшин гайхмаар өндөр, зээлийн нийлүүлэлт хязгаарлагдмал байна. Мөнгөний нийлүүлэлт нэлээд нэмэгдсэн боловч түүнийг дагалдсан инфляци ажиглагдсангүй. Энэ нь мөнгөний бодлого хэт хатуу байгааг нотлон харуулж байна.

Дүрслэл 1.4 Инфляцийн түвшин, 1991-2002



Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл 1997, 1999, 2000, 2002, УСГ.

Тус улсын экспортод 90 гаруй хувийг эзэлдэг мал аж ахуйн гаралтай түүхий эд, материал, нэхмэл сүлжмэлийн бүтээгдэхүүн, эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнээс манай улсын эдийн засаг, иргэдийнх нь амьжиргаа шууд хамаардаг. Экспортод цөөн нэрийн түүхий эд зонхилдог тул тэдгээр бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн уналт Монгол улсад нэлээд хүндээр тусдаг. Малчин нэг өрх дунджаар орлогынхоо 62.0 хувийг ноос, ноолуураас, 29.0 хувийг малаа зарж олж байна⁵. Зэсийн баяжмалын жилийн дундаж үнэ 1995-2001 оны хооронд 54.3 хувиар, ноолуурынх 4.4 хувиар буурсан нь орлогод үлэмж хэмжээгээр нөлөөлсөн билээ⁶.

Өнөөгийн нөхцөлд Монгол улс аж үйлдвэрийн хэрэглээгээ дотоодын үйлдвэрлэлээр хангах чадваргүй, цөөн нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдгийн улмаас импортоос хамаарал ихтэй байгаа тул гадаад худалдаа улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Импортын хэрэглээ экспортын нийлүүлэлтээс хол давж, гадаад худалдааны алдагдлыг гол төлөв гадаад зээл, тусламжаар нөхөж байна.

Гадаад худалдааны нийт эргэлт 2002 оны байдлаар барагцаалбал 1.21 тэрбум ам.долларт хүрчээ⁷. Өнгөрсөн жил зэс, нэхмэл, сүлжмэлийн бүтээгдэхүүний үнэ унасны улмаас экспорт 4.0 хувиар буурсан бол импорт 3.3 хувиар нэмэгджээ. Төгрөгийн ханшийг нэлээд бууруулсан боловч энэ нь байдлыг төдийлөн дээрдүүлсэнгүй, гадаад худалдааны алдагдал өндөр хэвээр байна. Нийт экспортын гуравны нэг орчим хувийг эрдэс бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр 28.0 хувийг нь дангаараа бүрдүүлж байна. Нэхмэл сүлжмэлийн бүтээгдэхүүн нийт экспортод 27.3 хувийг эзэлж байна. Харин импортын 19.5 хувийг машин техник, электрон бараа, 19.0 хувийг хүнс, 16.6 хувийг нефтийн бүтээгдэхүүн тус тус эзэлж байгаа юм.

Гадаад худалдааны алдагдалтай зэрэгцэн гадаад өрийн хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдсэн нь хот, хөдөөгийн хүн амын татварын ачааллыг нэмэгдүүлэхэд хүргэж байна. Хувийн (64.4 сая ам.доллартай тэнцэх хэмжээний) болон хөрөнгийн шилжүүлэг гадаад худалдааны алдагдлыг тодорхой хэмжээгээр нөхөж байгаа тул 2002 онд төлбөрийн тэнцэл 72.4 сая ам. долларын ашигтай гарчээ⁸.

Дэлхийн эдийн засагт гарсан өөрчлөлтүүдээс Монгол улс хэр зэрэг мэдрэмтгий болохыг гадаад худалдааны дээрх тоо баримтууд харуулж байна. Зарим шинжээчийн үзэж байгаагаар, дэлхийн зах зээл үнэ 1.0 хувиар өсөхөд Монгол улсын ДНБ-ий хэмжээ 0.15 хувь буурдаг.

1999 онд ДНБ-ий 13.0 хувьтай тэнцэж байсан улсын төсвийн алдагдлын хэмжээ 2001 онд 4.5 хувь хүртэл буурсан боловч 2002 онд дахин өсч 5.7 хувьд хүрчээ. Төсвийн алдагдлыг бууруулах зорилгоор төсвийн зардлыг хорогдуулж байгаа нь нийгмийн салбарын хөгжлийг удаашруулж, Монгол улсад нэн шаардлагатай байгаа үндэсний чадавхийг бэхжүүлэх үйлсийг хойш нь чангаах болов.

Орлогын ядуурал

1990 оноос өмнө байгаагүй орлогын ядуурал нь Монголын хувьд шинэ үзэгдэл юм. Шилжилтийн хүрээнд маш ихээхэн өөрчлөлтүүд явагдсан боловч цалингийн түвшин ерөнхийдөө доогуур түвшинд хадгалагдан үлджээ. 1998 онд хийгдсэн “Амьжиргааны түвшний судалгаа”-гаар орлогын ядуурлын талаархи хамгийн сүүлийн үеийн албан ёсны мэдээллийг бий болгосон. Уг судалгаагаар нийт хүн амын 35.6 хувь ядуурлын шугамаас доогуур түвшинд амьдарч байсан нь 1995 онд тогтоогдсон 36.2 хувиас ялимгүй буурчээ.

⁴ Статистикийн бюллетень, 2003 оны 7 сар, УСГ.

⁵ Хөдөөгийн бизнес мэдээ, дугаар 9, 2002.

⁶ Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл, 1995-2001, Монгол улсын Гаалийн ерөнхий газар.

⁷ Монгол улсын Статистикийн эмхтгэл, 2002, УСГ.

⁸ 2002 оны жилийн тайлан, Монгол банк.

Шигтгээ 1.1

Монголын ядуурлыг хэмжих нь: Арга зүйд гарч буй өөрчлөлтүүд

Монгол улсын Засгийн газар 1990-ээд оноос хойш ядуурлын талаарх тоо, мэдээллийн чанар, холбогдох тоо мэдээллийг цуглуулж боловсруулах арга зүйн чадавхийг тус тус сайжруулж чадсан билээ. Энэхүү хүчин чармайлтыг 1995 онд Дэлхийн банк, 1998 онд НҮБХХ тус тус санхүүжүүлж хэрэгжүүлсэн “Амьжиргааны түвшний судалгаа”-ны хоёр төслөөр дэмжсэн юм.

Монгол улсын ядуурлын түвшинг өдөрт 2100 килокалори хүнсний бүтээгдэхүүн, бусад зайлшгүй хэрэгцээт хүнсний бус бүтээгдэхүүнийг худалдан авахад зарцуулах зардлын хэмжээнд үндэслэн тогтоож байна. Ядуурлын түвшинг хэмжих тогтолцоонд 1998 онд хоёр томоохон өөрчлөлт орсон. Нэгдүгээрт, Монгол Улсын Их Хурлаас “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хуулийг батлан гаргаж, үндэсний хэмжээнд ядуурлын түвшинг тодорхойлох эрх үүргийг Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газраас ҮСГ-т шилжүүлжээ. Хоёрдугаарт, ҮСГ 1999 оноос эхлэн 1998 оны АТТС-ны үр дүнд тулгуурлан амьжиргааны доод түвшинг тухайн үеийн инфляцийн түвшинтэй уялдуулан засварлаж, жил бүр шинэчлэн тогтоох боллоо.

Дээрх өрхийн орлого, зарлагын үндэсний хэмжээний судалгаанууд, тэдгээрт үндэслэн боловсруулсан ядуурлын хэмжүүрүүд нь ҮСГ-аас сар бүр гаргадаг “Өрхийн орлого, зарлагын судалгаа” болон холбогдох хэмжүүрүүдээс хэд хэдэн талаар ялгаатай юм.

Хоёр удаагийн АТТС-ны гол ололт нь амьжиргааны өргийн ялгааг тодорхойлоход бүсийн үнийн индексийг ашигладаг болсон явдал юм. Өмнө нь Засгийн газар зөвхөн хот, хөдөө дэх хүнсний бүтээгдэхүүний үнийн ялгааг ашиглан тооцдог байв. Дээрх хоёр судалгааны бүтэц, ядуурлын шугамыг тодорхойлох арга зүйд бага зэргийн өөрчлөлтүүд орсон. Тухайлбал, 1998 онд шинээр Хөвсгөл, Говь-Алтай аймгуудын өрхүүдийг түүвэрлэлтэнд хамруулсан. Мөн онд ҮСГ ядуурлын шугамыг бүсээр тооцсон бөгөөд энэ тооцоог 1995 оны судалгаанд хийгээгүй юм.

Эх сурвалж: Кийт Гриффин, Монгол улсад ядуурлыг бууруулах нь, 2003.

Хүснэгт 1.3 Дундаас дээш боловсролтой өрхийн тэргүүний хувийн жин, орлогын түвшингээр, 1998

Байршил	Нэн ядуу	Ядуу	Ядуу бус (доод)	Ядуу бус (дунд)	Ядуу бус (дээд)
Хот	31.0	47.3	57.1	66.3	73.1
Хөдөө	21.0	18.8	19.8	28.1	31.5

Эх сурвалж: Амьжиргааны түвшний судалгаа, 1998, ҮСГ.

Хүн амын өсөлттэй зэрэгцэн 1995-1998 онд ядуучууд ч тооны хувьд багагүй өсчээ. 1995 онд 828700 хүн ядуурлын шугамаас доогуур амьдарч байсан бол 1998 он гэхэд ядуучуудын эгнээ 21100 хүнээр өргөжиж, 849800 хүнд хүрсэн байна. Шинээр ядуурсан иргэдийн 54.0 хувь нь хотын оршин суугчид байв.

1995-1998 онд Монголд ядуурал гүнзгийрч, тэгш бус байдал даамжирчээ. Жини коэффициент 1995-1998 онд 0.31-ээс 0.35 хүртэл өссөн нь орлогын тэгш бус байдал улам нэмэгдсэнийг харуулж байна. Үүний зэрэгцээ томоохон хотуудын хооронд, мөн хотууд болон алслагдсан аймгийн төвүүдийн хооронд орлогын тэгш бус байдал ихээхэн газар авчээ. Сумын төвийн иргэд болон багт амьдардаг малчдын хооронд, мөн сумын төвүүдийн хооронд орлогын ялгаа улам бүр гүнзгийрэв. Ядуурлын шугам, ядуу иргэдийн орлогын түвшний хоорондын ялгааг тодорхойлдог ядуурлын гүнзгийрэлтийн индекс 1995 онд 10.9 хувь байсан бол 1998 онд 11.7 хувь болж өсөв. Энэ хугацаанд ядуусын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлогч ядуурлын ялгааны индекс 17.0 хувиар нэмэгджээ. Ядуурлын талаарх тоо баримтууд нийгэмд баян, хоосны зааг бий болж, тэдгээрийн хоорондох орлогын ялгаа улам гүнзгийрч буйг харуулж байна.

1995-1998 онд Монголд ядуучуудын тоо нэмэгдэж, ядуурлын гүнзгийрэлт, тэгш бус байдал даамжирчээ.

Боловсролын түвшин, ядуурал нь нягт уялдаатай үзүүлэлтүүд юм. Иймээс ч боловсролтой иргэдийн маш бага хэсэг ядуу байна. Хүснэгт 1.3-т ядуурлыг боловсролын түвшнээр харуулав.

Судалгаагаар хүн амыг нэн ядуу, ядуу болон ядуу бус доод, дунд, дээд гэсэн таван ангилалд хуваажээ. Нэн ядуу гэсэн ангилалд оруулсан хөдөөгийн өрхийн тэргүүний дөнгөж 21.0 хувь нь дундаас дээш боловсролтой байв. Гэтэл хотын ядуу бус дээд ангиллын өрхийн тэргүүний 73.1 хувь нь дундаас дээш боловсролтой байжээ.

Хөдөөгийн эдийн засаг мал аж ахуйгаас ихээхэн хамааралтай. Гэвч мал аж ахуйн дүр төрхийг амин зуулгаа залгуулах төдий байдалд аж төрдөг олон өрх бүхий бараа солилцооны эдийн засаг тодорхойлж байгаа юм. Малчид орлогынхоо 98.0 орчим хувийг малаасаа олдог бөгөөд олон малтай байж гэмээ нь наад захын хэрэгцээнээсээ ахиухан орлого олох боломжтой. Тухайлбал, 4-5 ам бүлтэй дундаж өрх 200-300 толгой малтай байж л сая нөхөн үйлдвэрлэл явуулж наад захын хэрэгцээгээ ханган, амьжиргаагаа залгуулдаг⁹.

⁹ Малжуулалтаар малчин өрхүүдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг баталгаажуулах стратегийн үр дүнг үнэлэх нь, 2003, СЭЗЯ, ЯСН.

Гэтэл малчин өрхүүдийн дийлэнхи нь үүнээс цөөхөн малтай байна. Тэдний 85.0 орчим хувь нь 200 хүрэхгүй, 63.0 хувь нь 100 хүрэхгүй толгой малтай байгаа юм. Хөдөөд зах зээл хөгжөөгүйгээс түүхий эдээ явуулын наймаачдад бага үнээр худалдах буюу бараагаар солилцож, эсвэл хот руу тээвэрлэхийн тулд ихээхэн зардал гаргадаг нь малчдыг эдийн засгийн хувьд улам бүр тусгаарлагдмал, эмзэг байдалд оруулж байна. Дэд бүтцийн хөгжил сул дорой байгаагаас зах зээлийн харилцаанд оролцоход бэрхшээлтэй бөгөөд зардал ихтэй байдаг.

Усаар гачигдах явдал мал сүрэг, малчдын орлогод сөргөөр нөлөөлж байна. 1990-2000 онд уст цэгийн тоо 41600-аас 30900 хүртэл буурсны дотор инженерийн худгийн тоо 24600-аас 8200 болтол цөөрч, нийт багтаамж нь бараг 3 дахин багасчээ. Усны гачаал бэлчээр нутгийг ч хумих боллоо.

Ажилгүйдэл

Албан ёсны статистик мэдээгээр 1997-2002 онд Монголд ажилгүйдлийн түвшин 7.8-аас 3.4 хувь хүртэл тогтвортой буурчээ. Гэхдээ ажилгүй эмэгтэйчүүдийн тоо ажилгүй эрэгтэйчүүдийн тооноос илүү хэвээр байна. Ажилгүйдлийн талаарх албан ёсны тоо баримт зөвхөн ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүний тоонд үндэслэдэг тул эдийн засаг дахь нийт ажилгүйдлийн хэмжээг бүрэн харуулж чаддаггүйг анхаарууштай.

Эдийн засгийн үйл ажиллагаанд тулгуурлан ажилгүйдлийн түвшинг өөр аргаар тодорхойлохыг зорьсон 1998 оны АТТС-наас үзэхэд, ажилгүйдлийн ерөнхий түвшин 15.0 хувьтай байсан бөгөөд хот суурин газарт 30.0 хувь, хөдөөд 11.7 хувь байжээ. 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогоор улсын хэмжээнд ажилгүйдлийн ерөнхий түвшин 17.5 хувь, хотод 24.4 хувь, хөдөөд 10.2 хувь байлаа.

Үүнийг эс тооцсон ч, албан ёсны тоо баримтууд ажилгүйдлийн чиг хандлага, өөрчлөлтийн талаар тодорхой хэмжээний баримжаа өгч байгаа юм. Эдгээр баримтаас үзэхэд 1991-1994 онд ажилгүйдэл огцом нэмэгдэж, ажилгүйдлийн тоо 55407-оос 74881-д хүрч, 35.0 хувиар өсчээ. Үүнээс хойш энэ үзүүлэлт 1995 онд 45107 хүртэл буурсан бол 1997 онд 63690 болон өсч, нэлээд хэлбэлзжээ. 2002 онд 30900 ажилгүйдчүүд бүртгэгдсэний 16800 (54.3 хувь) нь эмэгтэйчүүд байлаа. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 3.8 хувь байгаа нь улсын дунджаас даруй 12.0 хувиар, эрэгтэйчүүдийнхээс 22.0 хувиар өндөр байна¹⁰.

Жендерийн тэгш бус байдал

Хууль тогтоомжид хийсэн үнэлгээ, Жендерийн Хөгжлийн Индекс (ЖХИ) хэмээх нийгмийн үзүүлэлтэд гарсан ялимгүй зөрүүний алинаас нь ч харсан Монголд жендерийн тэгш бус байдал ноцтой асуудал болоогүй ажээ. 2002 оны байдлаар хүн амын 50.4 хувийг эзэлж байсан эмэгтэйчүүд нийт ажиллах хүчний 51.3 хувийг бүрдүүлж байх жишээтэй. Ажил олгогч эздийн холбооноос 1-21 ажиллагсадтай 482 жижиг, дунд үйлдвэрийн

газруудын дунд явуулсан судалгаагаар тэдгээр үйлдвэрийн газрын эздийн дөнгөж гуравны нэг нь эмэгтэйчүүд байсныг тодорхойлжээ. Мөн судалгаанд хамрагдсан үйлдвэрийн газруудын хувьд эмэгтэйчүүдийн оролцооны бодит түвшин 38.0 хувь, 1-5 хүнтэй жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр түвшинд, харин аж ахуйн хэмжээ томрохын хэрээр буурч байв¹¹.

Монгол улс эмэгтэйчүүдийн боловсролын хувьд гайхамшигтай амжилт олжээ. Бага, дунд, дээд боловсролын сургуулиудад охид тооны хувьд давамгайлах хандлага социализмын үеэс бий болсон юм. Шилжилтийн жилүүдэд дунд, дээд боловсролын сургуульд хамрагдсан охид, хөвгүүдийн тоо нэлэнхүйдээ буурсан боловч хүйсийн тэнцвэрт бус харьцаа улам бүр нэмэгдсээр байна. Дунд сургуульд хамрагдсан охидын тоо хөвгүүдийнхээс 20.0 хувиар илүү байхад эмэгтэйчүүд их, дээд сургуулиудын нийт оюутны 70.0 хувийг эзэлж байна. Боловсролын салбарт хүйсийн тэнцвэргүй байдал нэмэгдсэн нь малчин өрхүүд орлогоо бодож хөвгүүдээ сургуулиас гаргах болсон, нөгөө талаас эрэгтэйчүүд ямагт давамгайлж ирсэн мэргэжлийн анхан, дунд шатны боловсрол олгох тогтолцоо нуран унасан зэргээс үндсэндээ хамаарчээ¹².

Хэдийгээр иймэрхүү эерэг дүр зураг ажиглагдаж байгаа боловч өрнөн гарсан өөрчлөлтүүд, тэдгээрийн үр дүн эмэгтэйчүүдийн хувьд тэр бүр нааштай байсангүй. Олон эмэгтэй ажил эрхлэлттэй холбоотой хөнгөлөлтүүд, улсын байгууллагуудаас олгож байсан нийгмийн халамжийг хүртэхээ больжээ. Эмэгтэйчүүд боловсрол эзэмших нь давуутай байгаа ч эзэмшсэн боловсролынхоо хэрээр албан тушаал ахих, шинэ боломжуудаа ашиглах тал дээр дутмаг байна. Ажил эрхлэлтийн байдлаас үзэхэд эмэгтэйчүүд гүйцэтгэх ажил үүрэг, нэн ялангуяа удирдах албан тушаалын хувьд ялгаварлагдаж байна. Хүүхэд төрүүлж асарсны төлөө тэтгэмж олгож, дэмжлэг үзүүлдэг улсын сектор хумигдсаны улмаас эмэгтэйчүүд эрсдэл бүхий хувийн болон албан бус секторт шилжихээс өөр аргагүй болов. Хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээ буурсны зэрэгцээ улсын ясли, цэцэрлэг олноороо хаагдсан, хувийнх нь үнэтэй байгаагаас эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэхэд бэрхшээлтэй болжээ. Эмэгтэйчүүд гэр орны болон асран халамжлах үүргээ биелүүлж, харин эрэгтэйчүүд уламжлалт ёсоор өрхөө тэргүүлэх нь зүйтэй гэсэн үзэл шилжилтийн жилүүдэд газар авсан байх юм. Гэтэл өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо 1999 онтой харьцуулбал 2002 онд 11.8 хувиар өссөн байна.

¹⁰ УСГ, Монгол улсын Статистикийн эмхтгэл, 2002.

¹¹ НҮБЭХС, Монголын эмэгтэйчүүд: шилжилтийн үеийн дэвшлийг зураглахуй, 2001.

¹² Мянганы хөгжлийн зорилтуудын илтгэлд зориулан бэлтгэсэн эх материал (хэвлэгдээгүй), 2003, Монгол улсын Засгийн газар.

1990 оноос хойш сонгуульт алба хашдаг эмэгтэйчүүдийн тоо эрс цөөрч, улс төрийн удирдлагад эрчүүд зонхилсоор байна. Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1990-2000 онд 23.0-10.0 хувь хүртэл буурав. Дээд Шүүхийн шүүгчдийн дөнгөж 12.0 хувь, дипломат албаны ажилтнуудын 11.0 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд яамдын сайд болон аймгийн Засаг дарга нарын дунд нэг ч эмэгтэй байхгүй юм.

1990 оноос хойш хууль тогтоох байгууллагад сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо мэдэгдэхүйц буурлаа.

Эмэгтэйчүүдийн ажлын байрны аюулгүй байдал төдийлөн хангагдаагүй байна. Хувийн болон албан бус секторт эмэгтэйчүүдийн ажлын байрыг хамгаалах механизм төдийлөн үйлчлэхгүй байгаа бөгөөд хөдөлмөрийн гэрээ нь баталгаа муутай, хөдөлмөр хамгааллын болон эрүүл ахуйн тааламжтай нөхцөлд ажиллаж чадахгүй байгаа юм. Эмэгтэйчүүд хувийн бизнес эрхлэхэд шаардлагатай хөрөнгө нөөц, зах зээлийн мэдээллээр дутагдаж, шинэ хууль тогтоомж, нийгмийн хамгааллын арга хэмжээнүүдийн талаар ч мэдээлэл муутай байна.

Эмэгтэйчүүдийн ядуурал нийслэл хот төдийгүй сум багийн түвшинд ч илүү түгээмэл шинжтэй байна. Тухайлбал, 1998 оны статистик мэдээнээс үзвэл, Улаанбаатар хотын нийт эмэгтэйчүүдэд ядуу эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин (44.0 хувь) нийт эрэгтэйчүүдэд ядуу эрчүүдийн эзлэх хувийн жингээс (21.0 хувь) хоёр дахин өндөр байв. Сумдад ч иймэрхүү ялгаатай байдал ажиглагдаж байгаа юм. Сумын нийт эмэгтэйчүүдийн 52.0 хувь нь ядуу зүдүү байдалд аж төрж байхад, эрэгтэйчүүдийн 28.0 хувь нь ядуу байна. Гэтэл хөдөөгийн алслагдмал багуудад ядуу эрчүүдийн эзлэх хувийн жин (25.2 хувь) эмэгтэйчүүдийнхээс (23.6 хувь) арай илүү байна.

Хүснэгт 1.4 Ядуурлын түвшин, өрхийн тэргүүн хүйс, байршлаар, хувиар

	Нийслэл	Аймаг	Сум	Хөдөө
Эрэгтэй	21.4	39.1	28.5	25.2
Эмэгтэй	43.8	53.2	51.7	23.6

Эх сурвалж: Амьжиргааны түвшний судалгаа, 1998, УСГ.

Жендэрийн хөгжлийн индекс

Жендэрийн хөгжлийн индекс (ЖХИ)-ийг тооцоход ХХИ-ийн нэгэн ижил үзүүлэлтүүдийг ашигладаг бөгөөд тухайн улсын хүн амын дундаж наслалт, боловсрол, орлогын үзүүлэлтүүдийг хүйсийн ялгавартайгаар оруулж тооцдог ороо ялгаатай. Монгол улсын 2002 оны ЖХИ (0.679)-ийг ХХИ-тэй харьцуулж үзэхэд ижил түвшинд байна. Энэ нь макро түвшинд жендэрийн харьцаанд тийм ч их зөрүү байхгүйг харуулсан нааштай үзүүлэлт

хэмээн ойлгогдох боловч энэхүү нийлмэл үзүүлэлтийн цаана учир дутагдалтай зүйлс олон байгааг дээр өгүүлсэн баримтуудаас харж болно.

Жендэрийн эрх мэдлийн хэмжүүр (ЖЭМХ) нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засгийн амьдрал дахь оролцооны тэгш байдлыг үнэлдэг үзүүлэлт юм. Монгол улсад ЖЭМХ ихээхэн доогуур түвшинд, тухайлбал, 2002 онд 0.458 байгаа нь улс төр, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн оролцоо сул, эрх мэдэл нь боогдмол байгааг харуулж байна.

Хүснэгт 1.5 Жендэрийн хөгжлийн үзүүлэлтүүд, 2002

Үзүүлэлтүүд	
Төрөлтөөс тооцсон дундаж наслалт (жилээр)	
Эрэгтэй	60.8
Эмэгтэй	66.5
Насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлагдалт (15 ба түүнээс дээш насныхан, %)	
Эрэгтэй	98.0
Эмэгтэй	97.5
Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин (%)	
Эрэгтэй	66.3
Эмэгтэй	73.0
Нэг хүнд ногдох ДНБ (PPP, ам.доллар)	
Эмэгтэй	1950.7
Эрэгтэй	2303.2
Дундаж наслалтын тэгшитгэсэн индекс	
	0.643
Боловсролын тэгшитгэсэн индекс	
	0.884
Орлогын тэгшитгэсэн индекс	
	0.509
Жендэрийн хөгжлийн индекс (ЖХИ)	
	0.679

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, УСГ.

Дэд бүтэц

Монгол улсын дэд бүтцийн хөгжилд 1992 оноос хойш дорвитой ахиц гарсангүй. Сүүлийн 10 жилийн албан ёсны статистик мэдээнээс үзвэл хатуу хучилттай зам таван зуугаадхан километрээр уртасч, эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ бараг өөрчлөгдөөгүй ажээ.

Хүснэгт 1.6 Дэд бүтцийн хөгжил, 1992-2002

Үзүүлэлт	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Сайжруулсан зам (км)	3076	3101	3163	3223	3325	3350	3351	5451	5516	5582	5547
Хатуу хучилттай зам (км)	1303	1308	1359	1413	1471	1519	1532	1712	1715	1715	1802
Телевизийн дамжуулах, дахин дамжуулах станц	491	599	700	674	664	633	639	645	625	619	647
Телефон цэгийн тоо (мян.ш)	69.2	66.4	69.3	75.5	82.1	86.8	93.8	104.1	112.2	119.7	126.7
Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо (мян.хүн)	-	-	-	-	1.5	3.6	5.3	48.2	75.1	91.2	256.8
Интернет хэрэглэгчдийн тоо (мян.хүн)	-	-	-	-	-	-	-	4.2	5.2	10.3	8.0
Үйлдвэрлэсэн шилгээн эрчим хүч (сая квт цаг)	2929	2582	2715	2628	2614	2720	2675	2842	2946	3017	3112

Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл, 1997, 1998, 2002, УСГ.

Оролцоо

Шийдвэр гаргах, төлөвлөлт хийх түвшинд идэвхтэй үүрэг гүйцэтгэхийг оролцоо гэж ойлгоно. Ядуурлын улмаас иргэн хүн өөрийнх нь амьдралыг хөндсөн бодлого боловсруулахад оролцож чадахгүйд хүрдэг. Ардчилал гүнзгийрч, иргэний нийгэм

Мэргэжлийн нийгэмлэг холбоо, сонирхогчдын клубуудыг оролцуулбал 1997-2001 онд төрийн бус байгуулага (ТББ)-уудын тоо тав дахин өсөв.

хөгжиж, зах зээл, харилцаа холбоо өргөжихийн хэрээр Монголчууд бидэнд оролцооны олон шинэ боломж нээгдлээ. Гэвч иргэдийн зүгээс хувийн болон нийгмийн үүрэг хүлээх эрмэлзлийг нь бууруулж байдаг төвлөрсөн удирдлагын тогтолцооны үеэс улбаатай инерци хадгалагдах, санаачлага дутагдах явдал, зэргээс шалтгаалан иргэдийн оролцооны түвшин муу байна.

Нөгөөтэйгүүр, өргөн уудам нутаг дэвсгэрт хүн ам сийрэг тархан суурьшсан явдал, харилцаа холбооны хөгжлийн сул дорой байдал зэрэг объектив шинжтэй шалтгаанууд иргэдийн оролцоонд саад тотгор учруулж байгаа бөгөөд ардчилал, хүний эрхийн талаарх ойлголт сулхан байна.

1992 онд батлагдсан шинэ “Үндсэн хууль” олон намын тогтолцоо, төлөөлөн удирдах сонгуулийн ардчилсан зарчмын эрх зүйн үндсийг тогтоосны

зэрэгцээ ард иргэдийн зүгээс орон нутгийг удирдахад оролцдог уламжлалыг хэвээр хадгалж, орон нутагт багийн, нийслэлд хорооны Иргэдийн нийтийн хурал ажиллаж байна. 1990 оноос хойш орон нутгийн сонгууль нийтдээ гурван удаа явагдлаа.

	2000
Төсвийн нийт зардал (сая.төг)	429 653.1
Нийгмийн салбарын нийт зардал (%)	52.3
Боловсролын үйлчилгээ (%)	19.1
Эрүүл мэндийн үйлчилгээ (%)	10.7
Нийгмийн даатгал ба нийгмийн халамж (%)	17.2
Орон сууц, төрийн үйлчилгээ (%)	1.6

Гэвч манай иргэд хуулиар олгогдсон оролцооны боломжуудаа тэр бүр ашиглаж чадахгүй байна. 1990-ээд оны эхэн үеэс хойш улс төрийн үйл ажиллагаанд оролцох иргэдийн идэвхи оролцоо буурсныг хүснэгт 1.7-д үзүүлэв. Орон нутгийн болон үндэсний хэмжээний сонгуулиудад оролцсон хөдөөгийн иргэдийн оролцоо ерөнхийдөө хотынхоос хавьгүй илүү байна.

Хүснэгт 1.7 Монгол Улсын Ерөнхийлөгчийн ба УИХ-ын сонгууль

	Сонгуулийн оролцооны хувь			Сонгуулийн идэвхи буурсан байдал
	1993	1997	2001	
Ерөнхийлөгчийн сонгууль				
Хот	90.2	80.5	79.1	-11.1
Хөдөө	94.1	86.6	84.3	-9.8
УИХ-ын сонгууль				
Хот	93.2	88.3	76.2	-17.0
Хөдөө	96.9	94.4	86.0	-10.9

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, Сонгуулийн ерөнхий хороо.

Мэргэжлийн нийгэмлэг, холбоод, сонирхогчдын клубуудыг оролцуулбал 1997-2001 онд ТББ-ын тоо 410-аас 2214 хүртэл тав дахин өссөн боловч шийдвэр гаргах түвшинд иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлсэн эдгээр байгууллагын дуу хоолой төдийлөн сонсогдохгүй байна.

Төвлөлийг сааруулах бодлого, орон нутгийн засаглал

Монгол улс сийрэг тархан суурьшсан хүн амдаа төрийн үйлчилгээг хүргэх хамгийн оновчтой арга нь засаглалын төвлөрсөн бус тогтолцоо мөн гэж олон хүн боддог. Удирдлагын төвлөрсөн бус хэлбэрт тулгуурлан хэрэгжсэн “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр” (ЯБҮХ) нийслэлийн 9 дүүрэг, бүх сумдын 30 гаруй мянган ядуу өрхөд орлогын ядуурлаас гарахад нь дэмжлэг үзүүлжээ. Монгол улс шинэ Үндсэн хуулиараа орон нутгийн бие даасан байдлыг хуульчлан баталгаажуулж, ардчилсан хэв маягийн засаг захиргааны бүтцийг тодорхойлсон билээ. Гэсэн ч хуулийн заалт бодит амьдралд тэр бүр хэрэгжихгүй байна. Үүнд нэг талаас, төвлөрсөн удирдлагын тогтолцооны үеэс уламжлалтай сэтгэлгээний инерци, нөгөө талаас орон нутгийн засаг захиргаага хянаж чиглүүлэх үүргээ иргэд өөрсдөө төдийлөн ухамсарлаагүй байдал зэрэг нь саад болж байна. Үүнээс гадна, томоохон хотуудаас бусад засаг захиргааны нэгжүүд санхүүгийн бие даасан байдлаа дээшлүүлэхэд шаардагдах хэмжээний төсвийн орлого бүрдүүлж чадахгүй байгаа юм. Орон нутгийн төсвийн орлого нь автомашины татвар, байгалийн баялаг ашигласны хураамж гэх мэтийн цөөн тооны эх үүсвэрүүдээр хязгаарлагддаг бөгөөд эдгээр нь төвлөрсөн төсвийн орлоготой харьцуулахад өчүүхэн бага хэмжээтэй. Үүнээс гадна, байнга дутагдалтай байдаг чадваржсан төрийн албан хаагчдын дийлэнх нь төрийн төв байгууллагуудад алба хашдаг явдал төвлөрөлд түлхэц өгч байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдэлт, зарцуулалтын байдлаас үзэхэд хотуудын төсөв нь өөрийгөө санхүүжүүлэх зарчимд илүү ойрхон бол төсөв нь байнга алдагдалтай байдаг аймгууд төвлөрсөн төсвийн татаасаар амьдрах явдал үргэлжилсээр байна. Орон нутаг засаг захиргааны хувьд бие даасан байдалтай боловч санхүүгийн эрх мэдэл нь хязгаарлагдмал шинжтэй. Хэдий

хэмжээний татаас олгохыг төвөөс, харин төсвөө хэрхэн бүрдүүлж хуваарилахыг аймгууд өөрсдөө шийдвэрлэж байна. Орон нутгийн засаг захиргаа эрүүл мэндийн болон бага, дунд боловсролын сургалт зэрэг үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй. Эдгээр үйлчилгээний норм, стандартыг дээрээс тодорхойлдог боловч түүнийгээ бодит амьдралд хэр зэрэг хэрэгжиж буйг хянах механизм үгүйлэгдсээр байна.

Улсын төсвийг бүрдүүлж, хуваарилахад олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж, төсвийг төвлөрүүлэн зарцуулах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлоход хот, хөдөөгийн иргэдийн оролцоог бий болгох нэн чухал шаардлага тулгараад байна.

2000 онд “Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа” (АТОАҮС)-г явуулсан долоон аймагт орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаа тааруухан үнэлэгджээ. Үүний шалтгаан нь аймаг, сумын түвшин дэх хариуцлагагүй болоод ил тод бус байдал гэж тогтоожээ. Мөн ядуу хүмүүсийг ялгаварлан гадуурхаж, тэгш бус байдлыг нэмэгдүүлэхэд авилгал нөлөөлж байна гэж үзжээ. Сумын засаг дарга нарын ажлыг муу гэж, багийн засаг дарга нар иргэддээ харьцангуй ойр байдаг гэж дүгнэсэн байна. Гэхдээ багийн засаг дарга нар эрх мэдлээр хязгаарлагдмал, төсөв захиран зарцуулах ямар ч эрх мэдэлгүй байгааг бас дурджээ. Аймаг, сум, багийн аль ч түвшинд засаг дарга нар холбогдох эрх мэдэл бүхий Иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр төрийн албан хаагчдыг томилдог. Харин сум, аймгийн түвшинд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг шууд сонгуулиар сонгож байна.

Олон нийтийн дуу хоолой бодлого боловсруулагчдад хүрч байвал нөөц баялгийг хот, хөдөөд илүү тэгш байдлаар хуваарилах нөхцөл бүрдэнэ гэдэгт олон хүн итгэдэг. Үүний тулд, иргэдийн аж амьдралд шууд нөлөөтэй бүх зүйлс, түүний дотор хууль тогтоомж, бодлогын шийдвэр, үнэ ханш, эдийн засгийн талаарх мэдээллийн хүртээмж зэргийг сайжруулах шаардлагатай. Улсын төсвийг бүрдүүлж хуваарилахад олон нийтийн хараа хяналтыг нэмэгдүүлж, төсвийн зардлыг хот, хөдөөгийн амьдралын гүнээс урган гарч буй асуудлуудаар баримжаалан төлөвлөх явдал нэн чухал юм.

Хувь хүний баталгаагүй байдал

Гэмт хэрэг бол нийгэм дэх бухимдлын шалтгаан, үр дагавар мөн бөгөөд эдийн засгийн хямралтай үед улам бүр даамжирдаг үзэгдэл юм. Ажилгүйдэл, ядуурал нь нийгэм, гэр бүлийн түвшинд бухимдал үүсгэж, архидалтад турхирдаг. Үүнийг дагалдаад Монголд анхаарал татахуйц хэмжээнд хүрсэн асуудал буюу хүүхэд, эмэгтэйчүүдийг золиослодог гэр бүлийн хүчирхийлэл үүсч байна. Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдүүдийг гэрээс нь дайжуулж, гудамжинд тэнүүчлэн амьдрахаас өөр аргагүй болгож байна. Ядуурал ч олон хүүхдийг тэнэмэл амьдралаар амьдарч, хууль бусаар хөдөлмөр эрхлэхэд нэгэн адил хүргэж байна. НҮБ-ын Хүүхдийн сан (НҮБХС)-гаас 2002 онд явуулсан “Монгол улсын насанд хүрээгүй иргэдийн гэмт хэргийн байдал”-ын талаарх судалгаанаас үзэхэд хот, суурин газруудад 3700 орчим хараа хяналтгүй хүүхэд байна. Тэдгээр хүүхдийн 80.0 хувь нь хагас өнчин эсвэл эцэг, эх нь салсан айлын, 50.0 хувь нь хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд байжээ.

1990 оноос хойш гэмт хэргийн тоо тасралтгүй өслөө. Ажилгүйдэл нэмэгдэж, орлого буурч, тэгш бус байдал гүнзгийрч, боловсрол, эрүүл мэндийн

үйлчилгээний хүртээмж муудсан зэрэг нь үүнд нөлөөлжээ. Аюулгүй байдлын баталгаа ийнхүү алдагдаж байгааг гэмт хэргийн талаарх статистикийн мэдээ тодорхой харуулж байна.

Шилжилтийн үед гэмт хэргийн тоо бараг хоёр дахин өссөн нь ядуурал, маргаашдаа үл итгэх явдал нэмэгдсэнтэй холбоотой.

Гэмт хэргийн тоо 1990-2001 онд 160.0 хувиар өссөн бөгөөд 2002 онд бага зэрэг буурчээ. Хүчирхийллийн гэмт хэрэг тасралтгүй өсч, 1990 онтой харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн

байна. Хөдөөд бас ийм хандлага ажиглагдаж байгаа нь сэтгэл түгшээх боллоо. Хувийн өмч бий болсон шилжилтийн үеийн эхний жилүүдээс эхлэн өмч хөрөнгөтэй холбоотой шинэ төрлийн гэмт хэргийн тоо огцом өслөө. Сүүлийн үед энэ хандлага хөдөөд буурч, хотод нэмэгдсээр байна. Доорх хүснэгтэнд гэмт хэргийн тоог гэмт хэргийн төрлөөр харуулав.

Хуулиар хамгаалуулах боломж

Иргэдэд гэмт үйлдлийн улмаас учирсан хохирлыг барагдуулж, гэмт этгээдэд зохих ял шийтгэл оногдуулах нь төрийн нэг чухал үүрэг юм.

Эрх чөлөөт шинэ эринд хууль сахиулах байгууллагууд мэдээллийг албадан гаргуулдаг, хүчээр тулган хүлээлгэдэг социализмын үеийн арга барилдаа найдан гэмт хэрэгтэй тэмцэх бололцоо хязгаарлагдмал байна. Жишээлбэл, гэмт хэрэгтэй тэмцэх шинэ техник технологи, цагдан сэргийлэх орчин үеийн арга барилыг эзэмших явдал удаашралтай байна. Үүнээс үүдэн хууль сахиулах шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын чадавхи дорой байна.

Хүснэгт 1.8 Гэмт хэргийн тоо, төрлөөр, 1990-2002

Он	Бүгд	Эд хөрөнгийн	
		Хүч хэрэглэсэн гэмт хэрэг	Эсрэг ба бусад гэмт хэрэг
1990	9060	3265	5795
1991	9825	3038	6787
1992	12467	3057	9410
1993	17354	3318	14036
1994	18563	3941	14622
1995	20496	3964	16532
1996	22368	4552	17816
1997	24653	5586	19067
1998	22737	5571	17166
1999	23352	5748	17604
2000	23463	5873	17590
2001	23670	5883	17787
2002	22555	6518	16037

Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл, 1997, 2002, УСГ.

Уг тогтолцоонд оршиж буй дутагдлуудын улмаас гэмт хэрэгт сэжиглэгдсэн иргэд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа бүрэн авч чадахгүй байна. Үүнийг мэргэшсэн хуульчид дутмаг байгаатай холбон үзэж болох юм. 2002 оны 10 сар гэхэд Монгол улсын хэмжээнд ажиллаж байсан 390 итгэмжлэгдсэн өмгөөлөгчийн ердөө 21.0 хувь нь хөдөө орон нутагт ногдож байв. Ихэнх аймгуудад өмгөөлөгчдийн тоо таваас хэтэрдэггүй. Баян-Өлгий, Говь-Алтай аймгууд тус бүр нэг өмгөөлөгчтэй байх жишээтэй. 2002 оноос сонгон шалгаруулалтын журмаар ажиллуулах болсноор хуульчдын тоо өссөн боловч Улаанбаатар хотод улам бүр төвлөрсөөр байна.

Шүүх засаглалын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний эрхийг хүндэтгэж, шударга ёсыг баталгаажуулахын тулд Монгол улсын шүүх эрх мэдлийнхээ тогтолцоонд шинэчлэлт хийх шаардлагатай байна.

Хөрөнгө мөнгө, унааны гачигдлаас шалтгаалан хөдөөгийн шүүх, цагдаагийн байгууллагууд гэмт хэргийг хугацаанд нь багтаан илрүүлж, хуулийн дагуу хөтлөн явуулж чадахгүй байна. Тухайлбал, 2002 онд батлагдсан “Эрүүгийн байцаан

шийтгэх хууль”-д орсон нэг томоохон дэвшилтэт өөрчлөлт нь сэжигтнийг баривчлахын тулд цагдаагийн байгууллага прокуророор уламжлан шүүгчээс холбогдох зөвшөөрлийг авдаг болсон явдал юм. Хэрэв баривчлах ажиллагааг хийх хойшлуулушгүй нөхцөл байдал үүссэн бол баривчлах зөвшөөрлийг шүүгчээс 48 цагийн дотор багтаан авах шаардлагатай байдаг.

Гэтэл хөдөө орон нутагт байршлын ялгаанаас үүдэн хуулийн дээрх заалтыг тэр бүр биелүүлж чадахгүй байна. Ихэнхи сумдын цагдаагийн газар өдөрт 10-15 литр бензин хэрэглэх нормтой ганцхан машинтай байдгаас ойр хавийн айлаас морь гүйх, эсвэл сэжигтний гэр бүлээс унаа гаргуулах зэргээр албаа залгуулдаг. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээгээр дунд зэрэгт тооцогддог Баян-Өлгий гэх мэт аймгийн хөдөөгийн сумын төвд ажилладаг цагдаа аймгийн төвөөс баривчлах зөвшөөрөл авахын тулд 200 км замыг туулахад хүрдэг.

Иргэд хуулийн хамгааллыг тэгш хүртэх явдал зөвхөн хууль сахиулах байгуулагуудаас хамаарахгүй. Тухайлбал, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгуулагуудын чадавхи хотод илүү өндөр түвшинд байна. Ядуу иргэдэд эрх зүйн үнэгүй үйлчилгээ үзүүлдэг хоёр их сургуулийн хууль зүйн зөвлөгөө өгөх төв, эмэгтэйчүүдийн болон ажиллагсдын эрх ашиг, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод Улаанбаатар хотод байршжээ. Зарим төрийн бус байгууллагын салбарууд аймгуудад үйл ажиллагаагаа явуулдаг боловч тэдгээр нь үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлэх чадвараар хотынхоос эрс доогуур байна. Иргэдэд үнэ төлбөргүй эрх зүйн туслалцаа үзүүлдэг

хууль зүйн сургуулийн зөвлөгөө өгөх төв одоогоор Улаанбаатараас өөр газар байхгүй юм.

Бусад салбарын нэгэн адил хууль, эрх зүйн салбар үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай мэдээллээр цаг тухай бүр хангагдах ёстой. Хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, шүүх хурлын цагийн хуваарь зэрэг эрх зүйн мэдээллийг компьютерт оруулж, хуульчдад төдийгүй нэхэмжлэгч, шүүгдэгч болон бусад сонирхсон хүмүүст хүргэх оролдлого хийсээр байна. Үүгээр ч зогсохгүй олон нийтэд зориулсан мэдээллийг интернетэд байршуулахыг зорьж байна. Энэ нь тун чухал зүйл мөн бөгөөд интернет хэрэглэгчдийн 95.0 хувийг бүрдүүлдэг нийслэл хотынхонд л давуу боломжийг олгож байгаа юм.

Шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх зардал нэн ялангуяа хөдөөгийн бага орлоготой нэхэмжлэгчдийн хэр чинээнээс давж байгаа нь хууль сахиулах байгууллагад сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг боллоо. Шүүгдэгч хуулиар олгогдсон эрхээ эдлэхийн тулд өмгөөлөгчийнхөө зардлаас гадна хууль сахиулах байгууллагын унааны болон бусад зардлыг төлөхөд хүрдэг. Санхүүгийн иймэрхүү бэрхшээлтэй байдал нь хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн албан хаагчид авилгалд автагдсан гэдэг ойлголтыг лавшруулж байна¹³. Энэ нь эдүгээ хүртэл бодитой оршсоор байгаа хяналтын хуучин сэтгэлгээний үлдэцийг сэргээж болзошгүй.

Хүрээлэн буй орчны тогтвортой байдал

Манай орон байгалийн онгон төрх байдлаараа алдартай, түүнийгээ өнөөг хүртэл хадгалан үлдэж чадсан боловч өсөн нэмэгдэж буй агаарын бохирдол, бэлчээрийн талхагдал, ойн нөөцийн хомсдол, биологийн төрөл зүйлийн сүйрлийн улмаас түүнд аюул учраад байна. Хүрээлэн буй байгаль орчны доройтол нэг талаас эдийн засаг, нийгмийн огцом өөрчлөлтүүдээс тодорхой хэмжээгээр хамааралтай боловч, нөгөө талаас дэлхийн цаг уурын хэт дулааралт нөлөөлж байна. Амьдрах орчны хийгээд амьдралын чанар хоёрын хооронд чухал харилцан хамаарал оршин байдгийг ухаарах нь зүйтэй. Хүрээлэн буй орчны доройтол орон даяар харилцан адилгүй түвшинд байгаа бөгөөд энэ нь хүний хөгжлийн амин чухал асуудлууд болох эрүүл мэнд, өрхийн амьжиргаанд нөлөөлж байдаг билээ.

¹³ Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн үзэл бодлын судалгаа, 2002, Мөнголын нээлттэй нийгэм хүрээлэн.

Дүгнэлт

Зах зээлийн баримжаатай эдийн засгийн тогтолцоонд шилжих хүнд бэрх замыг туулах явцад Монгол улсын хүний хөгжлийн олон үзүүлэлтэд ухралт гарсан юм. Орлого буурч, нас баралт нэмэгдэж, ажилгүйдэл газар авсан төдийгүй өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд ядуурал тасралтгүй өсч байв. Цаашилбал, урьд өмнө цөөн гардаг байсан гэмт хэрэг нэмэгджээ.

Гэсэн хэдий ч Монгол улс шилжилтийн жилүүдэд социализмын үеэс өвлөн авсан эрүүл мэндийн ч амлахааргүй дэд бүтэц, бичиг үсэгт тайлагдалтын өндөр түвшин гэх мэт зарим давуу талаа хадгалан үлдэж чадсан юм.

Хүмүүсийн амьдралд ч томоохон өөрчлөлтүүд гарлаа. Гэвч ардчилал, зах зээлийн тогтолцооны үр шимийг хүмүүс тэгш бус байдлаар хүртэж байна. Сүүлийн жилүүдэд байдал төдийлөн дордоогүй, зарим үзүүлэлтүүд сайжрах эерэг хандлага ажиглагдаж байгаа боловч хаа сайгүй өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал Монгол улсын хувьд шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудал болоод байна.

Өргөн удам нутаг дэвсгэр, байгаль цаг уурын тааламжгүй бүс нутагт тархан суурьшсан ийм нөхцөлд дэд бүтцийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээ шаардагдаж буй түвшинд хүрэхгүй байгаагаар үл барам хуваарилалт нь тэгш бус байдалтай байгаа юм. Алслагдсан бүс нутгийн хүн амд үйлчилгээг хүргэж үзүүлэхэд зардал их шаардагддаг. Тиймээс сурч боловсрох, орлого олох, жижиг бизнес эрхлэх, мэдээлэл, эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх боломжоороо иргэд ялгаатай байна гэж хэлэх үндэслэлтэй. Хот суурин газрын иргэд хүний хөгжлийнхөө боломжоор хөдөөгийнхөөс хавьгүй илүү байгаа боловч тэдний дунд нийгмийн ялгаатай байдал мэдэгдэхүйц өндөр хэмжээнд хүрчээ. Хүн хаана оршин амьдарч байгаагаас нь хамаарч тэгш бус байдал улам бүр нэмэгдэх хандлагатай боллоо. Тиймээс ялгаатай байдлыг нэмэгдүүлж буй шалтгаан, нөхцлийг гүнзгий танин мэдэх нь юу юунаас илүү чухал асуудал болоод байна.



БҮЛЭГ 2

МОНГОЛ ДАХЬ ОРОН ЗАЙН ТЭГШ БУС БАЙДАЛ



Монгол дахь орон зайн тэгш бус байдал

Монголын хүний хөгжилд газар зүй, байр зүй, хүн ам зүйн хүчин зүйлс нэн чухал үүрэгтэй. Уудам нутаг дэвсгэр, эрс тэс цаг агаар, сийрэг тархан суурьшсан хүн ам зэрэг нь Монгол улсад орон зайн асар их ялгааг үүсгэдэг. Иймээс хүн амд, ялангуяа ядуу хүн амд боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн суурь үйлчилгээг үзүүлэхэд бэрхшээлтэй. Монголын хүн амыг өөр хооронд нь тусгаарлан хүндрэл учруулж буй өргөн уудам орон зайг “нутаг холын зовлон” хэмээн үзэх нь олонтаа. Алслагдсан зах хязгаар нутаг зам харгуй муутай, хотоос алслагдах тусам түлш шатахууны үнэ өндөр байдаг зэргийг тооцож үзвэл, газар зүйн байршил нь Монголчуудын хувьд аливаа боломж болон амьжиргааны өртгийг тодорхойлогч гол хүчин зүйл болж байна.

Монгол орны говь цөл, шороон шуурга болон байгаль, цаг уурын бусад үзэгдлүүд газрын шимийг хүртэн амьжиргаагаа залгуулж байдаг хүмүүст бэрхшээл учруулж, эмзэг байдлыг нь нэмэгдүүлж байна. Манай улсын нутаг дэвсгэр нь өндөр уул, тайга, ойт хээр (үржил шимтэй газар нутаг), тал хээр, говь, цөлийн бүс гэсэн үндсэн зургаан бүс, бүслүүрт хуваагддаг. Эдгээр нь хөрсөн бүрхэвч, амьтан, ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн, цаг уурын нөхцөл байдлаараа өөр хоорондоо харилцан адилгүй юм. Газар зүйн бүсийн эрс тэс харилцан адилгүй байдлыг дагаад хүний хөгжил ч ихээхэн ялгаатай. Тухайлбал, нутгийн хойд болон төв хэсэгт цаг агаар эрс тэс, өөрчлөгдөмтгий, цасан бүрхүүл удаан тогтож, ургамал ургах хугацаа богино байхад

Монгол орны говь цөл, мөнх цэвдгийн бүс, шороон шуурга болон байгаль, цаг агаарын бусад үзэгдэл газрын шимийг хүртэн амьжиргаагаа залгуулж байдаг хүмүүст хүндрэл учруулж, эмзэг байдалд оруулж байна.

говь, хээр, талын бүсэд хур тунадасны хэмжээ бага байх жишээтэй. Мөн эдгээр бүсүүдэд ургамлын гарц, малын ашиг шим, өрхийн орлого ч тааруу байдаг. Жилдээ 20-30 удаа байгаль цаг уурын аюултай үзэгдлүүд

тохиолддогийн гуравны нэг орчим нь байгалийн гамшгийн хэмжээнд хүрч байна. Үүнээс болж жил бүр 5-7 тэрбум төгрөгөөр хэмжигдэх өмч, хөрөнгийн хохирол учрах боллоо. Байгаль цаг уурын гамшигт үзэгдлүүдээс цасан шуурга, ган гачиг, ширүүн бороо, хүчтэй салхи, үер, шороон шуурга хамгийн хөнөөлтөйд тооцогдож байна. Мал маллагаа, гадаа ажиллах нөхцлийг хүндрүүлдэг цасан шуурга зарим газар хагас сараар ч илүү хугацаагаар үргэлжилдэг. Хээр тал, говийн бүсэд 4-6 сар үргэлжилдэг урт өвөл нь бас л бэрхшээл үүсгэнэ. Жилдээ 30-100 хоног шуурдаг шороон шуурга гадаа ажиллах нөхцлийг хүндрүүлэн, хоол хүнсний хомсдлыг бий болгож, үзэгдэх орчинг хязгаарладаг. Говьд ган гачиг 2-3 жил дараалан тохиолдох нь элбэг. Ургамлын гарц үндсэндээ хур борооноос хамаардаг. Сүүлийн жилүүдэд тохиолдсон ган, дэлхийн цаг уурын өөрчлөлт зэрэг нь газар тариалангийн салбарын үр

ашгийг дээшлүүлэхэд томоохон усжуулалтын систем хэрэгтэй болохыг харуулж байна.

Өргөн уудам нутаг дэвсгэрт тархан суурьшсан нүүдлийн хэв маягийн амьдралтай ядуу хүмүүст эрүүл мэндийн болон бусад үйлчилгээг хүргэхэд өртөг зардал ихтэй, бэрхшээлтэй байдаг. 1564 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр бүхий Монгол улс газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд 17-д ордог. 2002 оны байдлаар тус улсад 2.4 сая гаруй хүн ам оршин сууж байгаагийн 34.2 хувь нь Улаанбаатар хотод, 18.2 хувь нь нийслэл хот оршин байдаг төвийн бүсэд тус тус амьдарч байна. Гэтэл

Өргөн уудам нутаг дэвсгэрт тархан суурьшсан нүүдлийн хэв маягийн амьдрал бүхий Монгол орны хувьд ядуу хүмүүст эрүүл мэндийн болон бусад үйлчилгээг хүргэхэд өртөг зардал ихтэй, бэрхшээлтэй байдаг.

нийслэлээс бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн томоохон нэгжүүд болох 21 аймгийн алинд нь ч оршин сууж буй хүн ам улсын нийт хүн амын 5.0 хувиас хэтрэхгүй байна. 2001 оны статис-

тикийн мэдээллээс үзэхэд хотын ДНБ-ий үйлдвэрлэл хөдөөгийнхээс 1.6 дахин илүү байна. Ерөнхийдөө төвийн бүсийн хот суурин газрууд, аймгийн төвүүдэд дэд бүтэц, үйлчилгээ алслагдсан зүүн болон өмнө зүгийн бүс нутгуудтай харьцуулахад илүү сайн хөгжжээ.

Сийрэг тархан суурьшсан хүн амд нийгмийн үйлчилгээг хүргэж, дэд бүтцээр хангах нь өндөр өртөг шаардах бөгөөд хөдөөгийн эдийн засаг сул хөгжсөн жижиг орны хувьд ихээхэн хүндрэлтэй асуудал юм. Иймээс дээр дурдсан 21 аймгийн төвүүдийн олонхи нь нийслэл хоттой хатуу хучилттай замаар холбогдож чадаагүй төдийгүй хөдөө орон нутаг харилцаа холбооны хувьд хоцрогдсон хэвээр байна.

2001 онд явуулсан судалгаагаар төрөхийн улмаас эндсэн эхчүүдийн 36.0 хувь нь эмнэлгийн үйлчилгээний чанар, түвшин муугаас, 28.0 хувь нь эмнэлгийн тусламж оройтсон, эмнэлгийн байгууллагаас алс хол амьдардаг зэргээс шалтгаалан яаралтай тусламж авч чадалгүй нас баржээ. 2000 онд эндсэн нийт эхийн бараг тэн хагас нь хөдөөгийн


Хөдөөгийн оршин суугчид зам тээврийн нөхцөл муугаас хотоос тусгаарлагдан, түлш шатахуун, тээвэр, өргөн хэрэглээний барааны үнэ өндөр гэх мэт бэрхшээлтэй тулгарч байна.

малчин эмэгтэйчүүд байсан бөгөөд магадгүй энэ нь хамгийн ойрын эмнэлгийн тусламжийг авахын тулд морь, мотоциклээр багагүй замыг туулахад хүрдэгтэй холбоотой байж болох юм. Хөдөө-

гийн иргэд зам тээврийн нөхцөл муугаас хотоос тусгаарлагдан, түлш шатахуун, тээвэр, өргөн хэрэглээний барааны үнэ өндөр гэх мэт бэрхшээлтэй тулгарч байна.

1990 оноос өмнө улсын хэмжээнд өргөн хэрэглээний барааг бөөний худалдааны нэгдсэн сүлжээгээр дамжуулан борлуулж байсан тул хот, хөдөөд барааны үнэ ижил түвшинд байсан юм. Харин шилжилтийн жилүүдэд хоттой харьцуулахад хөдөөд амьжиргааны өртөг илүү ихээр нэмэгдсэн бөгөөд өнөөдөр түлш шатахууны үнэ хөдөөд 10.0-20.0 хувиар өндөр байна. Энэ нь хотоос алслагдахын хэрээр зөвхөн өргөн хэрэглээний барааны үнэ өсөөд зогсохгүй, бараа, бүтээгдэхүүн тээвэрлэх зардал ч нэмэгддэг болохыг харуулж байна. Үүнээс гадна манай улс далайд гарцгүйн улмаас дэлхийн зах зээлээс алслагдсан орон юм. Хөдөөгийн хүн ам, жижиг хот суурингийн алслагдмал байдал нь тэдэнд нийгмийн болон бусад үйлчилгээг хүргэх явдлыг ихээхэн хүндрэлтэй болгодог бөгөөд хөдөөгийнхний аж амьдралыг илүү баталгаатай, тогтвортой болгох явдал туйлаас чухал болж байна. Сайтар хөгжсөн зам тээврийн сүлжээ, цахилгаан эрчим хүч, цэвэр усны найдвартай хангамж зэрэг нь “Нутаг холын зовлон”-г даван туулахад нэн чухал шаардлагатай.

Дүрслэл 2.1 Монгол улсын засаг захиргааны бүтэц



Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл, 2002, УСГ.

Монгол улс нийслэл Улаанбаатар хот, 21 аймгаас бүрдсэн засаг захиргааны 22 томоохон нэгжтэй. Эдгээрийг орон нутгаас сонгогдсон Иргэдийн төлөөлөгчдийн хурал удирддаг. Аймгууд нь хүн амын тоо, газар нутгийн хэмжээгээрээ харилцан адилгүй. Хүн ам нь 12500-122000-ын хооронд хэлбэлздэг. Хамгийн том аймаг гэхэд л 165.4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй. Аймаг нь аймгийн төвийг оролцуулан 27 хүртэл сумдаас бүрдэх бөгөөд сум нь багуудад хуваагдана. Нийслэл Улаанбаатар хотод 9 томоохон дүүрэг, засаг захиргааны анхан шатны нэгж болох 121 хороо бий.

Улаанбаатар хотод нийт хүн амын гуравны нэг нь оршин суудаг боловч улсын хэмжээний нийт баялгийн талаас илүү хувийг үйлдвэрлэж байна. Улаанбаатар зөвхөн нийслэл хот төдийгүй, Монгол улсын эдийн засаг, бизнес, соёлын төв билээ. Мөн 1960, 70-аад оны үед байгуулагдсан Дархан, Эрдэнэт

гэсэн томоохон хотууд ч аж үйлдвэр, бизнесийн төвүүд болж чадлаа. Уул уурхай, эрдэс баялгийн томоохон үйлдвэр Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн төвүүдэд орон нутгийн удирдлагын засаг захиргаа, аймгийн хуулийн байгууллагууд, театр, сургууль, эмнэлэг, үйлдвэр аж ахуйн газрууд байршин үйл ажиллагаагаа явуулдаг. Аймгийн төвийн хүн амын ихэнхи нь хөнгөн үйлдвэр, үйлчилгээ, жижиг аж ахуйн нэгжүүдэд ажиллаж байхад багийн иргэд хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарт ажиллаж байна.

Багийн иргэд гол төлөв нүүдлийн хэв маягаар амьдарч цаг агаарын нөхцөл, улирлын өөрчлөлтөөс хамааран малаа даган нутаг бэлчээрээ сэлгэн отор, нүүдэл хийдэг. Малчид улирлын байдлаас хамааран өөрийн сум, багийнхаа нутаг дэвсгэрт амьдран суудаг ч ган, зуд болон байгалийн бусад гамшиг тохиолдсон үед өөр нутагт нүүдэллэх нь бий. Ийнхүү нутаг сэлгэн нүүдэллэх нь малчид эрүүл мэндийн болон бусад үйлчилгээнээс хүртэх байдлыг илүү бэрхшээлтэй болгодог.

Хот, хөдөөгийн ялгаатай байдлыг судлахад тулгарч буй бэрхшээл

Хот, хөдөөгийн ялгаатай байдлыг зохих хэмжээнд судлан шинжилсэн ажил өнөөг хүртэл хараахан хийгдээгүй байна. Үүнээс өмнө хийгдсэн судалгаанууд гэр хороолол, албан бус сектор зэрэг ихэвчлэн хот суурин газарт хамаарах асуудлуудад анхаарал хандуулж байв. Судалгааны төвүүд болон иймэрхүү судалгааг санхүүжүүлэгчид, хандивлагчид Улаанбаатар хотод төвлөрчээ. Хот, хөдөөгийн ялгаатай байдлыг судлахын ач холбогдлыг Засгийн газар, хандивлагчид, судалгааны байгууллагууд ойлгон, хүлээн зөвшөөрч буй боловч тус орны бусад хэсэгт төдийлөн анхаарал хандуулахгүй байна. Энэ удаагийн Үндэсний хүний хөгжлийн илтгэл нь энэ чиглэлийн өмнөх судалгаануудын дутагдалтай талуудыг бүхэлд нь нөхөж чадахгүй ч цаашдын судалгааны чиглэл болгон авч үзэж болох зарим асуудлуудыг гаргаж ирэхийг зорьсон юм.

Уг асуудлыг судлахад тулгарч буй дараагийн нэг бэрхшээл нь “хот, хөдөө” гэсэн нэр томъёоны талаар олон янзын тодорхойлолт байгаа явдал юм. Судлаачид илтгэлийг бичихдээ хүн амын нягтрал ихтэй, дэд бүтэц өндөр хөгжсөн, үйлдвэрлэл, худалдаа арилжаа гэх мэт байнгын тогтвортой үйл ажиллагаа явуулдаг салбартай суурин газрыг хот гэсэн ангилалд хамааруулан үздэг олон улсын тодорхойлолтыг ашиглав. Хотжилтыг илэрхийлсэн энэ тодорхойлолтын дагуу гурван хотыг хот гэсэн ангилалд, бусдыг нь хөдөөд тус тус хамаарууллаа. Тодруулбал, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй, үйлдвэрлэлийн болон дэд бүтцийн хөгжлөөр сул дорой, судалгааны зорилгоор ашиглах тоон үзүүлэлтүүд, тухайлбал нэг хүнд ногдох ДНБ-ий тооцоог хийх боломжгүй аймгийн төвүүдийг хот гэсэн ангилалд оруулаагүй болно.

Илтгэлд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гэсэн гурван хотыг хот гэсэн ангилалд багтаан авч үзэв. Гэхдээ, энэхүү ангиллын сул тал нь аймгийн төвүүдийг бусад жижиг тосгон, сууринтай ижил түвшинд авч үзсэн явдал юм. Ингэснээрээ хот, хөдөөгийн хүн амын орлогын эрс ялгааг тодорхой хэмжээгээр бүдгэрүүлсэн байж болохыг үгүйсгэхгүй.

Бодлогын үүднээс авч үзвэл, ялгаатай байдлыг танин мэдэж, нийгмийн үйлчилгээг зохих түвшинд хүргэхэд хот, хөдөөг үндэслэлтэй тодорхойлох нь маш чухал. Өнөөг хүртэл ийм тодорхойлолт байхгүй байгаа нь нийслэлээс бусад жижиг хот, суурингийн хөгжлийн асуудалд дутуу анхаарч байсны нотолгоо ч болж мэдэх юм.

Шигтгээ 2.1

Монгол улсад хот, хөдөөг тодорхойлж байгаа нь МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Дөрөвдүгээр бүлэг. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага

Тавин долдугаар зүйл.

- Монгол улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

Арван гуравдугаар зүйл.

- Монгол улсын төрийн дээд байгууллагууд байнга оршдог хотыг Улсын нийслэл гэнэ. Монгол улсын нийслэл Улаанбаатар хот мөн.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХАВСРАЛТ ХУУЛЬ

Дөрөвдүгээр зүйл.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай Монгол улсын Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх

- Хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтоож, түүний дагуу тэдгээрийн өөрийн удирдлагыг зохион байгуулах хүртэл Дархан, Чойр, Эрдэнэт хот одоогийн нутаг дэвсгэртээ аймагтай адилсах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай байна.

ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Гуравдугаар зүйл. Хот, тосгон

- Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнхи хувь нь голлон үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газар мөн.

Дөрөвдүгээр зүйл. Хотын зэрэглэл

- Хот нь оршин суугчдын тоо, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшин, улсын болон тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн

засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэх үүргээс хамааран улсын буюу аймгийн зэрэглэлтэй байна.

- 50000-аас дээш (шаардлагатай гэж үзвэл 50000 хүртэл) оршин суугчтай хотод улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд гүйцэтгэж байгаа үүрэг, хотжилт, хот бүрдүүлэгч дэд бүтцийн хөгжлийн түвшинг харгалзан улсын зэрэглэл тогтоож болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Гуравдугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж

- Монгол улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

- Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

- Баг нь сумын, хороо нь дүүргийн засаг захиргааны нэгж мөн.

Хот, хөдөө дэх хүний хөгжил

Монгол орны хот, хөдөөд хүний хөгжлийн түвшин харилцан адилгүй байна. Хүснэгт 2.1-д 1999-2002 оны Монгол улсын хот, хөдөөгийн ХХИ-ийн тооцоог харуулав.

2002 оны байдлаар хотын ХХИ (0.723) хөдөөгийнхөөс (0.636) 14.0 хувиар өндөр байна. Харин дундаж наслалт хот, хөдөөд бараг ялгаагүй байв. Боловсролын болон нэг хүнд ногдох ДНБ-ий индексүүд хот, хөдөөд ялгаатай байгаа нь ХХИ-ийн дээрх ялгаатай байдалд нөлөөлжээ. Бичиг үсэгт тайлагдалтын түвшин хотод 99.2, хөдөөд 96.7 хувь байна. Сургуульд

2002 оны байдлаар хотын ХХИ (0.723) хөдөөгийнхөөс (0.636) 14.0 хувиар өндөр байна.

хамрагдалтын түвшин хотынхтой (82.5 хувь) харьцуулахад хөдөөд нэлээд доогуур (61.2 хувь) байгаа юм. Үүний зэрэгцээ хотынхны

орлого хөдөөгийнхнөөс мэдэгдэхүйц өндөр байна. Хотын өрхийн мөнгөн орлогын гол эх үүсвэрийг цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж (36.8 хувь) бүрдүүлж байхад хөдөөд өрхийн аж ахуйн орлого (малын мах, сүү, цэцгийн тос, өөх тос, хүнсний ногоо гэх мэт) гол хэсгийг буюу 33.0 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 2.1 Монгол улсын ХХИ, хот, хөдөөгөөр, 1999-2002

		Насанд хүрсгэлийн бичиг үзэгт		Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин (%)	Нэг хүнд ногдох ДНБ (РРР, ам доллар)	Дундаж насалалтын индекс	Боловсролын индекс	ДНБ-ий индекс	Хүний Хөгжлийн Индекс (ХХИ)
		Төрөлтоос тооцсон дундаж нас (жил)	тайлагдалтын түвшин (15 ба түүнээс дээш насныхан, %)						
1999	Хот	63.04	99.2	82.5	2468.19	0.634	0.936	0.535	0.702
	Хөдөө	63.21	96.7	61.2	1244.15	0.637	0.849	0.421	0.635
	Бүгд	63.18	97.8	66.0	1706.78	0.636	0.872	0.474	0.661
2000	Хот	63.04	99.2	82.5	2895.53	0.634	0.936	0.562	0.711
	Хөдөө	63.21	96.7	61.2	1163.54	0.637	0.849	0.410	0.632
	Бүгд	63.18	97.8	69.6	1838.12	0.636	0.884	0.486	0.669
2001	Хот	63.39	99.2	82.5	3057.64	0.640	0.936	0.571	0.716
	Хөдөө	63.21	96.7	61.2	1253.22	0.637	0.849	0.422	0.636
	Бүгд	63.36	97.8	69.6	1968.29	0.639	0.884	0.497	0.674
2002	Хот	63.54	99.2	82.5	3423.37	0.642	0.936	0.590	0.723
	Хөдөө	63.37	96.7	61.2	1245.54	0.640	0.849	0.421	0.636
	Бүгд	63.51	97.8	69.7	2125.35	0.642	0.884	0.510	0.679

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, УСГ.

УСГ-аас ХХИ, ЖХИ-ийг аймаг, хотоор тооцож гаргасныг хавсралтад үзүүлэв.

ХХИ-ийн тооцооноос үзэхэд:

- Нийт аймаг, хотуудаас зөвхөн нийслэл Улаанбаатар хот болон Орхон аймаг хүний хөгжлийн үзүүлэлтээрээ дээд бүлэгт орж байна.

- 15 аймаг, мөн Дархан хот дунд зэргийн хүний хөгжилтэй бүлэгт багтаж байна.
- 5 аймаг доогуур хүний хөгжилтэй бүлэгт орж байна.

Хүснэгт 2.2 Хүний хөгжлийн түвшин, аймаг, хотоор, 2002

Ангилал	Монгол улсын ХХИ-ийн түвшин	Аймаг, хот
Хүний хөгжлийн доод бүлэг	0.630 хүртэл	Баянхонгор, Дорнод, Өвөрхангай, Увс, Хөвсгөл,
Хүний хөгжлийн дунд бүлэг	0.631-0.700	Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий, Дархан-Уул, Говьсүмбэр
Хүний хөгжлийн дээд бүлэг	0.701, түүнээс дээш	Улаанбаатар, Орхон

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, УСГ.

Хүснэгт 2.3 ЖХИ, түүний үзүүлэлтүүд, хот, хөдөөгөөр, 2000-2002

		Насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлагдалт (15 ба түүнээс дээш насныхан, %)		Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин			Нэг хүнд ногдох ДНБ			Дундаж наслалтын тэгшитгэсэн индекс	Боловсролд хамрагдалтын тэгшитгэсэн индекс	Орлогын тэгшитгэсэн индекс	ЖХИ
		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Бүтэц	Эмэгтэй	Эрэгтэй					
2000	Хот	99.4	99.1	78.3	86.5	2896	2738	3064	0.639	0.937	0.561	0.712	
	Хөдөө	97.1	96.4	58.6	63.7	1164	1054	1272	0.636	0.849	0.408	0.631	
	Бүтэц	98.0	97.5	63.7	75.5	1838	1702	1977	0.638	0.883	0.485	0.669	
2001	Хот	99.4	99.1	78.3	86.5	3058	2593	3550	0.642	0.937	0.568	0.715	
	Хөдөө	97.1	96.4	58.6	63.7	1253	1159	1346	0.639	0.849	0.421	0.636	
	Бүтэц	98.0	97.5	63.7	75.5	1968	1747	2194	0.641	0.883	0.496	0.673	
2002	Хот	99.4	99.1	78.3	86.5	3423	3072	3793	0.644	0.936	0.588	0.723	
	Хөдөө	97.1	96.4	58.6	63.7	1246	1177	1314	0.641	0.849	0.421	0.637	
	Бүтэц	98.0	97.5	66.3	73.0	2125	1951	2303	0.643	0.884	0.509	0.679	

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, УСГ.

Цаашилбал, ЖХИ нь хотод хөдөөтэй харьцуулахад бас л мэдэгдэхүйц өндөр байна.

ЖХИ болон түүний орлогын индексээс бусад бүрэлдэхүүн үзүүлэлтүүд хот, хөдөөгийн аль алинд нь нэлээд өндөр түвшинд байгаа төдийгүй улам сайжрах хандлагатай болох нь дээрх хүснэгтээс тодорхой харагдаж байна. ЖХИ, боловсролын индексүүдийн хүрсэн түвшингээрээ Монгол улс бахархах хэрэгтэй. Харин эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хот, хөдөөгийн хооронд үүссэн орлогын тэгш бус байдалд анхаарал хандуулах цаг болжээ.

Ястан, үндэстний асуудал Монгол дахь ядуурал, хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдалд ямар ч нөлөө үзүүлэхгүй байгаа нь үнэхээр сайшаалтай хэрэг мөн.

Шигтгээ 2.2

Ястан үндэстэн: Хүртээмжийн тэгш байдал

Хууль тогтоомжийн хүрээнд манай орны 30 гаруй ястан үндэстний байгалийн нөөц баялгаас хүртэх эрхийг ялгаварласан зүйл огтхон ч үгүй бөгөөд бодит амьдралд ч ийм ялгаа байхгүй байна. Хүмүүсийн хэл яриа, гарал үүслийн ялгаатай байдал нь нийгэм, улс төрийн хуваагдмал байдлын шалтгаан болж байсан удаагүй. Төвийн бүсийн аймгууд руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөний дүнд ястан үндэстнүүд өөр хоорондоо холилдон амьдрах болсон бөгөөд тэдний эдийн засгийн нийтлэг зорилго ястан үндэстний ялгаанаас дээгүүрт тавигдсан ажээ. Монголын ястан үндэстнүүд Монголын нүүдэлчин овог, аймгуудын удам угсааныхан мөн билээ. 2000 оны байдлаар нийт хүн амын 81.5 хувийг халх, 4.3 хувийг казак, 2.8 хувийг дөрвөд, 2.1 хувийг баяд, 1.7 хувийг буриад, 7.6 хувийг бусад ястангууд эзэлж байв.

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны тооллого, Үндсэн үр дүн, 2000, УСГ.

Хот, хөдөөгийн зааг ялгаа

Хүний хөгжлийн боломж ихэвчлэн газар зүйн байршлаас хамаарч тэгш бус байна. Хөдөөгийнхөн боловсрол, эрүүл мэнд, мэдээлэл, ажлын байрны хүртээмж болон хүний хөгжлийн бусад боломжоор хотынхоос дутмаг байна. Хот, хөдөөгийн ялгааны асуудлаас гадна хөдөөд сонголт муу байгаагаас хотод шилжин ирж, хотын борчуудын давхаргыг тэлэхэд нөлөөлж байна. Монголд үүсэн бүрэлдэж буй хот, хөдөөгийн ялгааг харуулах тоо, мэдээллийг албан ёсоор цуглуулан, дүн шинжилгээ хийдэг уламжлалт тогтолцоо хараахан байхгүй байгаа тул боломжит бүхий л мэдээлэлд тулгуурлан хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдлыг боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэл, дэд бүтэц, эдийн засгийн боломж гэсэн таван үндсэн чиглэлээр харуулахыг зорилоо.

2000 онд долоон аймгийг хамруулан хийсэн “Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх” судалгаа (АТОАҮС) уудам нутагт сийрэг суурьшсан хот, хөдөөгийн хүн амд чухам ямар үйлчилгээ хамгийн чухал хэрэгцээтэй байгаа талаар ойлголт өгсөн юм. Судалгаанд хамрагдсан хүмүүс боловсрол,

Хөдөөгийнхөн боловсрол, эрүүл мэнд, мэдээлэл, ажлын байрны хүртээмж болон хүний хөгжлийн бусад боломжоор хотынхоос дутмаг байна.

эрүүл мэндийн үйлчилгээ хамгийн чухал гэж ямар ч эргэлзээгүйгээр хариулжээ. Гэвч эдгээр үйлчилгээний чанар муу, нөөц хомс, зардал өндөр, үйлчилгээ-

нээс алслагдсан зэрэг олон бэрхшээл тулгарч байгаа тухай судалгаанд оролцогчид өгүүлсэн байна. Алслагдмал хөдөө орон нутгийнханд харилцаа холбооны үйлчилгээг чухал гэж нийтээрээ үздэг ч түүний хүртээмж хангалтгүй, зохих түвшинд байж чадахгүй байна гэж дүгнэжээ.

Шигтгээ 2.3

Үнэн мэдээллийг олж авах

Манайх 1992 оноос мал маллан амьдарч байна. Өвөлжөө маань сумын төвөөс 18 км-ийн алсад оршдог. Өнгөрсөн хугацаанд сумын захиргаанаас олон удаа соёлын арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд бид үе үе үдэшлэг, хурал цуглаанд оролцдог. Заримдаа хотоос ирсэн дуу бүжгийн чуулгуудын тоглолтыг ч үзэх боломжтой байсан.

Манайх хэвлэл захиалдаггүй. Багийн дарга заримдаа “Хөдөөгийн мэдээ” сонин тараадаг. Би ном уншдаггүй. Манайх мотоцикл, радиотай учир хэрэгтэй мэдээллээ радиогоор дамжуулан хүлээж авдаг.

С.Б. 43 настай, Төв аймгийн Лүн суманд эхнэр, хоёр хүүхдийн хамт амьдардаг.

Эдийн засгийн боломж

Эдийн засгийн боломжоос хүртэх бололцоотой байх нь хүний хөгжлийн хамгийн чухал хүчин зүйл билээ. Энэ нь зөвхөн орлогод нөлөөлөөд зогсохгүй, хамгийн гол нь хувь хүн өөрийн нөөц бололцоогоо ашиглах, мөн өөрийгөө танин мэдэх боломжийг олгодог. 1990-ээд онд Монгол орон даяар эдийн засгийн боломж ихээхэн хумигдсан билээ. Хотуудад олон салбар бүхий хүчирхэг эдийн засаг бий болсон хэдий ч хөдөөгийнхөнд ач тусаа үзүүлэхгүй байна.

Үндсэндээ нийслэл Улаанбаатар хотод төвлөрч буй хотын эдийн засаг нь уул уурхай (Багануур, Налайх дүүргүүд дэх), үйлдвэрлэл, нийтийн ахуйн үйлчилгээ, барилга байгууламж, худалдаа, тээвэр, харилцаа холбоо зэргээс бүрддэг. Хүнс, нэхмэл, сүлжмэл, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулалт, мод боловсруулалт, барилга, хими, металл боловсруулалт, цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл зэрэг нь мөн л хотод төвлөрчээ. Хотын иргэд ажлын байраар дутагдаж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний өртөг өссөөр байна.

Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйнууд таран бутарсан нь бэлэн мөнгө, зээлийн эх үүсвэрийн аль алинаар нь гачигдсан аж ахуйнууд зонхилсон, сул дорой хөдөөгийн эдийн засгийг бий болгосон юм.

1990-ээд оны туршид хот, суурин газарт хувийн хэвшил, албан бус сектор хөгжин дэвшиж байхад хөдөөгийн эдийн засгийн үндэс суурь явцууран суларч, хумигдаж байжээ. Хөдөө

аж ахуйн салбар хөдөөгийн төдийгүй улс орны эдийн засагт тэргүүлэх байр суурийг эзэлж байсан боловч 1996 оноос тус салбарын хөдөлмөрийн бүтээмж, нэг малчинд ногдох бүтээгдэхүүний үйлдвэрлэл амиа аргацаах түвшинд хүртэл ихээхэн хэмжээгээр буурсан байна.

Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйнууд таран бутарсан нь бэлэн мөнгө, зээлийн эх

үүсвэрийн аль алинаар нь гачигдсан аж ахуйнууд зонхилсон, сул дорой хөдөөгийн эдийн засгийг бий болгосон юм. Үйлдвэрлэл уналтад орсноор хөдөөд ажил эрхлэх боломж хумигдаж, төрийн алба, худалдаа наймаанаас өөр эрхлэх ажил бараг үгүй болов. Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байсан хүнсний үйлдвэрүүд хаагдаж, барилгын материалын үйлдвэрүүд бүрэн зогсов.


Монголын махны импортод тавьсан мал эмнэлгийн хориг нь хөрш орнууд руу экспорт хийж байсан махны үйлдвэрүүдэд томоохон цохилт өгсөн юм. Малчдын амьжиргааны гол эх үүсвэр болох түүхий эдийн гадаад зах зээлийн үнэ сүүлийн жилүүдэд огцом уналаа. Өнөөдөр аймаг, сумын төвүүдэд үйлчилгээ, худалдаа, хөнгөн үйлдвэрийн жижиг аж ахуйн нэгжүүдтэй зэрэгцэн хэдхэн тооны жижиг, дунд оврын үйлдвэрүүд ажиллаж байна. Гадаад зах зээл дээрх түүхий эдийн эрэлт өсөхгүй байгаагаас малчид түүхий эдээ хямд үнээр худалдах боллоо. Малчид бүтээгдэхүүнээ өргөн хэрэглээний бараа, таваараар арилжиж буй энэ байдал нь хот, хөдөөгийн хооронд худалдааны тэнцвэргүй нөхцлийг бий болгов. Энэ нь хөдөөгийнхний орлогыг бууруулж, амьдралынх нь чанарт муугаар нөлөөлж байна.

Малчдад ихээхэн дэмжлэг болж байсан нэгдэл, сангийн аж ахуйнууд тарсан нь хөдөөгийн байдлыг улам хүндрүүлэв. Сангийн аж ахуйнууд тарж үгүй болсноор тариалангийн талбай дөрөв дахин багасч, ургацын хэмжээ тав дахин буурчээ. Тэдгээр аж ахуйнуудад ажиллаж амьжиргаагаа залгуулж байсан хүмүүс газар, хөрөнгө, мал, ажил ч үгүй хоцорсон юм. Ерөнхийдөө мал аж ахуй, газар тариалангийн дэд бүтцэд оруулж байсан хөрөнгө оруулалтын хэмжээ үлэмж буурсан юм. 1990 онд ДНБ-ий 32.0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байсны гуравны нэг нь хөдөө аж ахуйн салбарт зориулагдаж байв. Харин 2001 онд ДНБ-ий 24.8 хувьтай тэнцэх хөрөнгө оруулалт хийгдсэний 5.0 хүрэхгүй хувийг хөдөө аж ахуйн салбарт зарцуулжээ.

Монгол улсад зээлийн хүү хаа сайгүй өндөр, зээлийг эргүүлэн төлөх хугацаа нь богино, хүү нь хүний сонирхол татахуйц хэмжээнээс давж гарсны улмаас бүтээлч сектор дэх хөрөнгө оруулалт буурч байгаа зэргээс шалтгаалан хөрөнгийн зах зээлүүд үр ашигтай ажиллаж чадахгүй байгаа юм. Зээл олж авах боломж, нэн ялангуяа хөдөөгийн иргэдийн хувьд илүү бага байна. Хөдөөгийн малчид, ядуучууд өвчин эмгэгт өртөмтгий, малаас өөр хөрөнгөгүй, орлого нь улирлын чанартай, байгаль, цаг уураас хараат, учраас зээлийг эргүүлэн төлөх баталгаагүй байдаг. Тиймээс тэд гол төлөв орон нутгийн худалдаачид, дэлгүүр, мухлагаас зээл авдаг. Малчид байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан сум, багийнхаа дотор төдийгүй нутаг орноосоо гадагш нүүдэллэж байгаагаас хөдөөд мал аж ахуйн жижиг бизнесийг үүсгэж, хөгжүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг. Орон нутгийн зах зээл хөгжөөгүй, алслагдсан нутгуудад шатахууны үнэ өндөр байдаг зэрэг нь энэ асуудлыг бүр ч бэрхшээлтэй болгож байна.

Алс хязгаарын малчдын хувьд түүхий эдээ зах зээлд хүргэж борлуулах, хэрэгцээт бараа таваараа худалдан авах боломж нь ихээхэн хязгаарлагдмал байна. Тиймээс хязгаар нутгийн малчид өөрсөдөө ашиггүй нөхцөлд ч жижиг худалдаачдаас хэрэгцээт бараа таваараа түүхий эдээр сольж авдаг бартерийн худалдааг хийсээр байгаа билээ. Зах зээлд ойрхон байх, мэдээлэл, үйлчилгээний хүртээмж зэрэг нь амин чухал бөгөөд хотын ойр орчмын оршин суугчид энэ талаараа үлэмж давуу байдалтай байна. Шилжилтийн эхний жилүүдэд малчид дор бүрдээ малаа хувьчлан авсан бөгөөд тэр нь гараас гар дамжсаар малчдын тоог ихээхэн нэмэгдүүлэв. Ингэснээр тэдгээр хүмүүсийн амьжиргааны түвшин ч сүрхий дээшилсэн юм. Гэвч энэ байдал төдийлөн удаан үргэлжилсэнгүй. Сүүлийн жилүүдэд малын гаралтай түүхий эдийн үнэ огцом уналаа. Малаа хувьчилж, нэгдлээ тарааснаас малчдад үзүүлдэг дэмжлэг туслалцаа үгүй болж, мал аж ахуйн дэд бүтэц, үйлчилгээний чанар муудаж малчдын эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлсэн билээ.

Дүрслэл 2.2 Малчин өрх, малын тоо толгойгоор, хувиар, 2002



Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл, 2002, УСГ.

Сүүлийн хэдэн жилд ган гачиг, зуд зэрэг байгалийн гамшиг удаа дараалан тохиож, бэлчээрийн талхагдалт нэмэгдсэн нь малчдад тулгарсан бэрхшээлийг улам даамжруулав. Энэ нь 2002 он гэхэд ДНБ-д хөдөөгийн эдийн засгийн эзлэх хувь 38.4 хүртэл буурч, хотууд 61.6 хувийг үйлдвэрлэх болсонд зарим талаар нөлөөлжээ.

Шигтгээ 2.4

Цаг ашиглалт: Хот, хөдөөгийн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амьдрал

2000 оны хавар явуулсан “Цаг ашиглалт”-ын судалгааны дүнгээс үзвэл хөдөөгийн эмэгтэйчүүдийг хотын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд төдийгүй хөдөөгийн эрэгтэйчүүдтэй харьцуулахад амрах, сурах, нийгэм, соёлын арга хэмжээнд оролцох, сонин сэтгүүл

унших, өөртөө анхаарал тавих зэрэгт харьцангуй бага хугацаа зарцуулж байна. Гэр орны ажил хийх, хүүхэд хөгшид гэх мэт гэр бүлийн бусад гишүүдээ асарч тойлох зэрэг үнэлгээгүй хөдөлмөрт хөдөөгийн эмэгтэйчүүдийн зарцуулж буй цаг хотын эрэгтэй, эмэгтэй хүмүүс болон хөдөөгийн эрэгтэйчүүдийнхээс их, харин хөлстэй ажил хийхэд зориулсан цаг бага байжээ. Хотын эрэгтэйчүүд хөдөлмөрлөсөн ихэнхи цагаа төлбөртэй ажил хийхэд зарцуулж байсан бөгөөд хөдөөгийнхөн хотын насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй харьцуулахад өөрсдийн хэрэглээнд зориулж мал маллах, ногоо тарих, гахай гэжээх зэрэг үнэлгээгүй хөдөлмөрт илүү их цаг зарцуулдаг байна.

Эх сурвалж: Цаг ашиглалтын судалгаа, 2000, УСГ.

Ядуурал, амьжиргааны түвшин

УСГ-аас явуулсан “Амьжиргааны Түвшний Судалгаа” (АТС)-ны дүнгээс үзэхэд 1995-1998 онд Монгол улсын хот суурин газруудад (хэдийгээр Улаанбаатар хотод бага зэрэг буурсан ч) хөдөөтэй харьцуулахад ядуурал бага зэрэг нэмэгджээ. Үүнээс үзвэл, шилжилтийн эдийн засагтай орнуудад хот, хөдөөгийн ядуурлын байдал хөдөө талдаа давамгайлсан байхад манайд эсрэгээр хот, суурин газрын ядуурал давамгайлж байгаа нь нэлээд ялгаатай, өвөрмөц байна. 1998 онд аймгийн төвийг оролцуулж үзвэл хот суурин газрын ядуурал (39.4 хувь) хөдөөгийн ядуурлаас (32.6 хувь) өндөр байв. Гэхдээ дээр дурдсан амьжиргааны түвшний судалгаанд хот, хөдөөг тодорхойлохдоо аймгийн төвүүдийг хот гэсэн ангилалд хамааруулсан гэдгийг анхаарах хэрэгтэй.

Ядуурал ийнхүү илт хотжихын хамт 4500 орчим орон гэргүй насанд хүрэгсэд, хүүхдүүдийг оролцуулсан хотын ядуус, борчуудын хорооллууд бий боллоо. Хөдөөгийн эдийн засаг бараг сонголтгүй болсны улмаас сүүлийн 10 гаруй жилд цэвэр шилжих хөдөлгөөнд хөдөөнөөс хот руу шилжсэн хүмүүсийн тоо, хотоос хөдөө рүү шилжсэн хүмүүсийн тооноос хавьгүй их байгаа дүр зураг ажиглагдаж байна. 1998 оны байдлаар Монгол улсын ядуу хүн амын 57.0 хувь нь хот суурингуудад, түүнээс 26.0 хувь нь нийслэлд оршин сууж байсан бол 43.0 хувь нь хөдөөд аж төрж байжээ.

Хүснэгт 2.4 Ядуу хүн амын шинж байдал, хувиар, 1995, 1998

Шинж байдал	1995		1998	
	Ядуу хүн ам	Улсын дундаж	Ядуу хүн ам	Улсын дундаж
Байршил				
Хот (аймгийн төвийг оруулаад)	57.0	54.0	57.2	52.5
Улаанбаатар	25.9	27.0	25.7	27.2
Хөдөө	43.0	46.0	42.8	47.5
Боловсрол				
Бага боловсрол эзэмшсэн	66.7	56.4	51.3	42.7
Дээд боловсрол эзэмшсэн	13.2	26.3	4.2	11.4
Ажил эрхлэлт				
Ажилгүй	36.0	19.3	32.8	19.2
Өрхийн тэргүүн				
Эрэгтэй	70.4	81.8	78.2	84.7
Эмэгтэй	29.6	18.4	21.8	15.3

Эх сурвалж: Кийт Гриффин, Монгол улсад ядуурлыг бууруулах нь, 2003.

Хүснэгт 2.4-өөс харахад томоохон хотууд болон аймгийн төвүүдийн аль алинд нь орлого, хэрэглээний тэгш бус байдал үүсч, нэмэгдсээр байна. Тэрчлэн сумын төв, хөдөөгийн багуудын хооронд ч ялгаатай байдал үүсчээ. Хөдөө орон нутагт хөдөлмөрийн бүтээмж хотуудынхаас үлэмж доогуур түвшинд байна.

Орлогын тэгш бус байдлыг хэмждэг Жини коэффициент 1995 онд 0.31 байснаа 2002 онд 0.44 хувь болж 42.0 хувиар өсчээ. Энэ нь Монгол улсад орлого хуваарилалтын тэгш бус байдал улам бүр нэмэгдэж буйг харуулж байна.

Дүрслэл 2.3 Жини коэффициент, 1995, 1998, 2002



Эх сурвалж: “Өрхийн орлого, зарлагын судалгаа”, 2002, УСГ;

“Амьжиргааны түвшний судалгаа” (АТС), 1995, 1998, УСГ;

2003 оны АТС-нд үндэслэн хийсэн Жини коэффициентийн урьдчилсан тооцоо, 2003, УСГ.

Хот, хөдөөгийн ядуурлын төлөв байдлын ялгааны талаар нэлээд их мэтгэлцдэг. Тухайлбал, зарим хүмүүс хөдөөгийн иргэд малаа түшин амьдарч, хоол хүнсгүй залгаж чаддаг байхад хот суурин газруудад орон сууцны өртөг өндөр байдаг тул хотын ядуучууд илүү эмзэг гэж үздэг. Энэ нь хөдөөгийн олон өрх цөөн тооны малтай, тэр нь амьжиргааг нь залгуулж хүрэлцдэггүй, хөдөөгийн хүн ам хотынхтой харьцуулахад нийгмийн халамжийн сүлжээнд хамрагдах боломжоор тааруухан байдаг зэргийг орхигдуулж байгаа юм. Хөдөлмөрийн бүтээмжээ дээшлүүлж, өөдлөн дэвжихэд чухал үүрэг бүхий шинэ технологи олж авах, мэдлэг боловсрол эзэмших боломж ч хөдөөгийнхний хувьд тааруухан байна. Баталгаагүй байдал, ядуурлын түвшний хэв шинж ч хот, хөдөөд харилцан адилгүй байна. Хөдөөгийн ядуу иргэдийн үндсэн хөрөнгө болох мал сүрэг нь ган гачиг, өвчин зэрэг гадны нөлөөнд ихээхэн өртөмтгий байх жишээтэй. 1990-ээд оноос харьцангуй чинээлэг өрхүүд ядуу өрхүүдээр түлшээ бэлтгүүлэх, малын хашаа хороо, гэр орноо цэвэрлүүлэх, малаа маллуулах зэрэг ажил хийлгэж хөлсөнд нь дэмжлэг туслалцаа үзүүлдэг үйлчилгээний хэлбэр бий боллоо. Зарим тохиолдолд ядуу өрх хүүхдүүдээ чинээлэг хамаатныдаа эсвэл саахалт айлдаа байлган ажил хийлгэж, ар гэрийнхээ амьжиргааг залгуулж байна. Амьжиргааны баталгаатай байдлыг тодорхойлогч гол хүчин зүйлсийн нэг нь зах зээлд ойрхон байх явдал бөгөөд үүнээс шалтгаалан олон иргэд хөдөө нутгаа орхин хот, аймаг, сумын төвийг бараадан шилжин суурьшиж байна. Харин чинээлэг хэсэг нь арилжаа наймаанаас олох ашгаа нэмэгдүүлэхийн тулд мотоцикл, УАЗ-469, ачааны машин худалдан авцгаажээ.

Хот, хөдөөгийн дундаж орлоготой, ядуу, нэн ядуу амьдралтай өрхүүд ажлын байргүй болох, эмчилгээний үнэ, хүүхдийн сургуулийн зардал, өвчлөл, байгалийн гамшгаас болж малаа алдах зэргийг ядуурлын үндсэн шалтгаанд оруулан тодорхойлжээ. Хөдөөгийн өрхүүд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг өөрсдийн хэрэглээнд зарцуулдаг учир хөдөөгийн ядуурлыг орлогын түвшингээр тодорхойлоход нэн бэрхшээлтэй юм. Бодит байдалд аймаг бүр орлого, ядуурлын үзүүлэлтүүдээ өөр өөр аргаар тооцож байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж

Эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, хангамж хот, хөдөөд харилцан адилгүй байна. Энэхүү тэгш бус байдлын улмаас хотод дундаж наслалт өндөр, нас



баралт, өвчлөл харьцангуй бага байгаа юм. Түүнчлэн ажиллаж, амьдрах нөхцөл, хүрээлэн буй орчин, орлогын түвшин, хоол тэжээлийн байдал харилцан адилгүйгээс хот, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн байдалд ялгаа үүсэн бий болов.

Хот, хөдөөд өвчлөл, нас баралтын түвшин ялгаатай байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээний тэгш бус байдлыг илэрхийлж байна. Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ хотод төвлөрсөн байхад хөдөөгийн эмнэлгүүд эмч, эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр дутагдалтай байна. Эрүүл мэндийн салбарын нөөцийн хуваарилалт эрүүл мэндийн

үйлчилгээнд үүссэн гол ялгааг илэрхийлж байна. Оношлогоо, эмчилгээний улсын болон хувийн байгууллагууд хотод төвлөрчээ.

Ерөнхийдөө хот, хөдөөгийн аль алинд эрүүл мэндийн үйлчилгээний чанар муу, мэргэжлийн эмчийн орон тоо ихээхэн дутагдалтай байгаа нь сум, багуудын хувьд хамгийн бэрхшээлтэй асуудлуудын нэг юм. 2000 онд явуулсан АТОАҮС-нд Улаанбаатар

Эрүүл мэндийн үйлчилгээ хотод төвлөрч, хөдөөгийн эмнэлгүүд эмч, эмнэлгийн тусламж үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр дутмаг, хот, хөдөөд эрүүл мэндийн үйлчилгээний тэгш бус байдал үүссэний улмаас өвчлөл, нас баралтын түвшин ялгаатай байна.

хот, аймгийн төвүүдээс хамрагдагсад эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг хангалттай гэж үнэлжээ. Судалгаанд хамрагдсан долоон аймгийн иргэдийн дийлэнхи нь эрүүл мэндийн үйлчилгээг тэдний хамгийн чухал хэрэгцээтэй зүйл гэж үзжээ. Харин сумын төв, багийн иргэд

орон нутаг дахь эрүүл мэндийн үйлчилгээний талаар сэтгэл дундуур байдгаа илэрхийлсэн байна. Мөн багийн эмчийн үйл ажиллагаа хангалтгүй, үйлчилгээг зохих түвшинд явуулахад шаардлагатай эм, хэрэгслээр дутмаг байдгийг дурджээ. Бас хөдөөгийн эмч нарын мэргэжил, боловсролын түвшинг ахиулах, дээшлүүлэх, дадлагажуулах ажил хийгддэггүй, цалин хөлс хангалтгүй, амьдралын түвшин дорой байдаг зэрэг бэрхшээлүүдийг мөн дурдсан байна.

Хөдөөгийн зарим эмнэлэгт цахилгаан, цэвэр усны шугам сүлжээ байдаггүй. Үүний уршгаар хоттой харьцуулахад хөдөөд эх, хүүхдийн эндэгдлийн түвшин өндөр байгаа юм. Үүнээс үзвэл, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулсны үр дүнг хөдөөгийн хүн ам жигд хүртэхгүй байна. Хөрөнгө, санхүүгийн нөөцийн хомсдолын улмаас хөдөөгийн олон эмнэлэгт гэрэл цахилгаан, ундны ус, хэрэгцээт багаж хэрэгсэл, эм тариа дутагдаж байна. Сүүлийн арван жилд сумдын эмнэлгийг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр зохих түвшинд хангаагүй, тоног төхөөрөмж нь элэгдэж хоцрогдон хэрэгцээнээс гарч,

сумдын олон эмнэлэг тоног төхөөрөмжөөр байнга дутагдах болжээ. Түүнчлэн хөдөөгийн иргэд чанартай, хямд эм тариагаар дутагдаж, өвчтнүүд хувь хүмүүсээс хугацаа нь дууссан, чанаргүй эм тариа, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч байна. Сумын эмнэлгийн төсөв хүрэлцээгүй, эмчилгээний төлбөрийг дараа нь

Хүснэгт 2.5 10000 хүн амд ногдох өвчлөлийн үндсэн таван шалтгаан, хот, хөдөөгөөр, 2002

Байршил	Амьстгалын замын өвчин	Хоол боловсруулах системийн өвчин	Шээс бэлгийн замын өвчин	Цусны эргэлтийн системийн өвчин	Гэмтэл, хордлого
Хөдөө*	970.6	672.6	685.9	471.1	122.0
Хот	615.0	561.8	448.6	407.2	681.0
Бүгд	850.6	635.2	605.8	449.5	310.6

Эх сурвалж: Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2002, ЭМЯ.
Тэмдэглэгээ: * Дархан-Уул, Орхон аймгийг оруулаад

хийдэг тул бэлэн мөнгөний тогтвортой эх үүсвэргүй байна. Үүнээс гадна эмнэлгүүд түргэн тусламжийн унааны шатахууны зардлыг өвчтөнөөс гаргуулахад хүрч байна.

Урьдчилан сэргийлэхэд хялбар амьсгалын замын өвчин, суулгалт зэрэг халдварт өвчинд ядуу өрхийн хүүхдүүд нэрвэгдэн эндэж байна. Зарим мэдээллээс үзэхэд ядуу өрхийн хүүхдүүд эндэх эрсдэл ядуу бус өрхийн хүүхдүүдийнхээс өндөр байгаа юм. Үүнд, хөдөө орон нутагт эмнэлгийн үйлчилгээний чанар муу, эрүүл мэндийн төв, түргэн тусламжийн үйлчилгээнээс хол байдаг зэрэг нь зарим талаар нөлөөлдөг байна. Түүнчлэн амин дэм, эрдэс бодисын дутагдал хөдөөд илүү түгээмэл байна.

Хөдөөгийн эмэгтэйчүүд жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үедээ эмнэлгийн тусламж, үйлчилгээнд зохих түвшинд хамрагдаж чаддаггүй учраас эндэгдэлд өртөх эрсдэл өндөртэй байдаг. 2002 онд нийт 57 эх эндсэний 23 (40.0 хувь) нь Улаанбаатарт, 34 (60.0 хувь) нь аймгуудад ногдож байв. Аймагт 34 эндэгдэл гарсны 15 нь аймгийн нэгдсэн эмнэлэгт, 19 нь сумын эмнэлэгт ногдож байна. Мөн онд алс баруун хязгаарын уулархаг аймгуудад эхийн эндэгдэл харьцангуй өндөр байлаа. Эмнэлгийн үйлчилгээний түвшин, чанар сул, түргэн тусламжийн үйлчилгээ хожигдож очих, эмнэлгээс алс зайдуу байрлах зэрэг шалтгааны улмаас эхийн эндэгдэл гарч байв. Гэртээ төрсөн эмэгтэйчүүдийн дийлэнх хувийг алслагдмал аймгийн малчин эмэгтэйчүүд эзэлж байна. Хэцүү нөхцөлд амьдарч, хүнд хүчир ажил хийж буй хөдөөгийн эмэгтэйчүүд дутуу жинтэй хүүхэд төрүүлэх магадлал өндөр байгаа юм. Нөгөө талаар, хотын эмэгтэйчүүд үр хөндөлт илүү их хийлгэж байна.

Хотод амьдарч буй хүмүүстэй харьцуулахад хөдөөгийн иргэд эмнэлэгт хандаж үйлчлүүлэх нь бараг хоёр дахин бага байна. Хөдөөнөөс хотод шилжин ирсэн боловч оршин суух эрхийн бичиг авч чадаагүй хүмүүс эрүүл мэндийн даатгалд хамрагдан, эмнэлгийн үйлчилгээ, дархлаажуулалтад хамрагдаж чадахгүй байна.

Хот, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн байдалд ундны усны чанар ихээхэн нөлөөтэй. Хөдөөгийн



оршин суугчдын гуравны хоёр нь хамгаалалтгүй худаг, гол мөрөн, цас, борооны усыг ундандаа хэрэглэж байхад хотод энэ үзүүлэлт 10.0 хувьд ч хүрэхгүй байна.

Шигтгээ 2.5

Ус-Хот, хөдөөгийн ялгааг үүсгэгч хүчин зүйл

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон ундны хэрэгцээнд ашиглах усан хангамж монгол орны хот, хөдөөгийн аюулгүй байдлын асуудлын нэг юм. Эдүгээ монголчуудын нэлээд хувь нь найдваргүй эх үүсвэрээс усны хэрэгцээгээ хангаж байна. Ундны усны хангамж нь газар зүйн байршил, орлоготой нягт уялдаатай. Тухайлбал, 2000 онд хөдөөгийн хүн амын 66.0 хувь, хотын иргэдийн 9.0 хувь хамгаалалтгүй эх үүсвэрээс ундны ус хэрэглэж байжээ. Хотод ядуу хүн амын зөвхөн дөрөвний нэг нь, харин ядуу бус иргэдийн тэн хагас нь усан хангамжийн төвлөрсөн системд холбогдсон байв. Хотын гэр хороололд оршин суугчдыг цэвэр усаар хангах нь бэрхшээлтэй асуудлуудын нэг юм. Гэр хорооллын оршин суугчид гол төлөв ойролцоох эх үүсвэрүүдээс усаа зөөж хэрэглэдэг бөгөөд үүний тулд нийслэлийн зарим хорооны иргэд ихээхэн хол замыг туулахад хүрч байна.

Гэр хорооллын оршин суугчид орон сууцанд оршин суугчдаас илүү их мөнгийг усны хэрэглээндээ зарцуулж, тэднээс бага ус хэрэглэж байна. Хотын оршин суугчдын усны хэрэглээ нь хөдөөгийн иргэдийнхээс бараг гурав дахин их бөгөөд 100 гаруй сум мөнх цэвдгийн бүсэд байрлаж, говийн аймгуудад хэрэглэж буй ундны ус нь эрдэсжилт ихтэй, флуорид багатай байдгийн улмаас бөөр, шээсний замын өвчин, бамбайн бахлуур, шүд цоорох өвчнөөр өвдөж байна.

Монгол оронд газар тариалангийн ургацын хэмжээ зун бороо хэр орсноос их шалтгаалдаг. Сүүлийн жилүүдэд ган болж, цаг агаар өөрчлөгдөж байгаа тул хэрвээ усжуулалтын барилга байгууламжинд хөрөнгө оруулалт хийхгүй бол хөдөө аж ахуйн салбарт ажиллан амьжиргаагаа залгуулдаг хөдөөгийн иргэд эдийн засгийн хувьд улам эмзэг байдалд орох нь гарцаагүй юм. Социализмын үед барьж байгуулсан 35000 механикжуулсан болон гүний худгийн 60.0 хувь нь шилжилтийн жилүүдэд ашиглах боломжгүй болжээ. Үүний улмаас хур тунадас ороогүй эсвэл бага үед малын тоо толгой хорогдох магадлал ихээр нэмэгдэж, усны эх үүсвэрт ойрхон бэлчээр нутаг талхлагдах боллоо. Сүүлийн жилүүдийн цаг агаарын өөрчлөлтөөс шалтгаалан гүний усны түвшин доошилж, усны зарим хуучин эх үүсвэрүүд ширгэх болжээ.

Эх сурвалж: Хүүхэд ба хөгжил судалгаа, 2000, УСГ.

Хүснэгт 2.6 Ундны усны хүртээмж, хувиар, 1998-2000

Усны баталгаат эх үүсвэр ашиглаж буй хүн ам	1998	1999	2000
Хот	89.9	89.9	90.8
Хөдөө	46.1	46.1	34.4
Усны баталгаат эх үүсвэргүй хүн ам			
Хот	10.1	10.1	9.2
Хөдөө	53.9	53.9	65.6
Бүгд	32.0	32.0	37.4

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, ҮСГ.

Боловсролын хүртээмж

Боловсрол нь хүмүүст өөрсдийн нөөц бололцоог бүрэн дайчлах боломжийг олгодог тул хүний хөгжилд хамгийн чухал үүрэг гүйцэтгэдэг хүчин зүйл ч байж болох юм. Социализмын үед Монгол улсад боловсролын систем харьцангуй сайн хөгжиж, хүйс, нийгмийн гарал үүслээр ялгаварлан гадуурхахгүйгээр, тэгш зарчмын үндсэн дээр хүн амд боловсролын үнэ төлбөргүй үйлчилгээг чанартай, жигд хүргэж байв. Хөдөөгийн сургуулиудын дэргэд дотуур байр байгуулж, малчдын хүүхдийг сургуульд суралцуулах арга хэмжээг өргөн хүрээнд дэмжин хэрэгжүүлж байлаа. Шилжилтийн үед боловсролд зарцуулах улсын төсвийн зардал бодит утгаараа буурч, ДНБ-д эзлэх хувь нь багасч, харин хүмүүсийн хувиасаа гаргах зардал нэмэгдсэн байна. Зарим үзүүлэлтээс үзвэл, шилжилтийн жилүүдэд хүний чадавхи боловсрол мэдлэгийн тал дээрээ буурчээ. Орлогын янз бүрийн бүлгүүд, хот, хөдөөгийн хооронд ч энэ ялгаа бий болов.

Сургуулиудын үйл ажиллагааны чанарт Гэгээрлийн яамнаас (хуучнаар) хийсэн үзлэгийн дүнгээс харахад 1990-2000 онд сумдын сургуульд сурч буй хүүхдүүдийн сурлагын үзүүлэлт аймаг, хотынхтой харьцуулахад 10.0 хувиар доогуур гарчээ. Энэ нь хөдөөгийн сургуулиудад багшийн хүрэлцээ муу байдагтай зарим талаар холбоотой. 2000 оны АТОАҮС-гаар хөдөөгийн багш нарын дийлэнхи нь 10 жилийн боловсролтой, эсвэл тэтгэврийн хүмүүс байдаг талаар судалгаанд хамрагдагсад шүүмжлэн ярьцгаасан байна. Сүүлийн үед мэргэжлийн сургууль төгссөн багш нар амьдралын нөхцөл илүү сайн хот суурин газарт ажиллах сонирхолтой болжээ.

Өнөөдөр хөдөөтэй харьцуулахад хотод сургуульд хамрагдалт, бичиг үсэгт тайлагдалт, боловсролын түвшин өндөр байна. Хөдөө орон нутгаас бусад газарт бага шатны боловсролыг үндсэндээ бүгд эзэмшсэн байхад 2001 онд ойролцоогоор нийт сумдын гуравны хоёрт бага боловсролын сургуульд хамрагдалтын түвшин 80.0 хувьд ч хүрээгүй байжээ. Сургууль завсардсан хүүхдүүдийн 70.0 хувь нь хөдөөд байна. Тэдний дийлэнхи нь гэр орныхоо ажилд туслалцаж мал маллах, орлого олох зорилгоор

хамаатан садангүй бол дотуур байранд амьдардаг. Гэтэл дотуур байрны ачаалал хэтэрснээс хүүхдүүдэд ор хүрэлцэхгүй болжээ.

Хөдөөд сургуулийн байрны ашиглалтын зардал хүрэлцээгүй байгаа тул зарим нэг нь халаалтын систем ажиллахгүйн улмаас өвлийн саруудад үйл ажиллагаагаа түр зогсооход хүрч байв. Хөрөнгө нөөц

Өнөөдөр хөдөөтэй харьцуулахад хотод сургуульд хамрагдалт, бичиг үсэгт тайлагдалт, боловсролын түвшин өндөр байна.



хангалтгүй тул хүүхдэд үнэгүй олгож буй сурах бичгүүд хүрэлцдэггүй.

Боловсролын нөөц, боловсролын түвшний ялгаатай байдал насанд хүрэгсдийн дунд ч ажиглагдаж байна. Тухайлбал, хотод насанд хүрэгсдийн бичиг үсэгт тайлагдалтын түвшин өндөр байгаа бөгөөд хот, хөдөөгийн ялгаатай байдал 1995-2000 онд нэмэгджээ. Дунджаар хөдөөгийн хүн амын 33.0 хувь бүрэн дунд боловсрол эзэмшиж чадаагүй байхад энэ үзүүлэлт хотод 21.0 хувьтай байна. Ийм ялгаатай байдал ядуу болон чинээлэг хүмүүсийн дунд ч ажиглагдаж байна. Нэн ядуу өрхийн хүүхэдтэй харьцуулахад чинээлэг өрхийн хүүхэд дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах магадлал бараг

найм дахин их байна. Хотын хүн амын 20.0 орчим хувь нь дээд сургуульд суралцаж байгаа бол хөдөөд энэ үзүүлэлт 5.0 хувьд ч хүрэхгүй байна.

Боловсролын зардал ядуучуудад бодитой саад тотгор учруулж байна. 2000 оны АТОАҮС-д хамрагдсан долоон аймгийн дундаж орлоготой болон ядуу, нэн ядуу өрхүүд ядууралд хүргэж буй гол гурван шалтгааны нэгэнд боловсролын зардлыг оруулжээ. Харин хот, хөдөөгийн иргэд хувцас, сурах бичиг, сургуулиудад өгдөг хандивын зардлыг ядуурлын гурван үндсэн шалтгаан гэж тодорхойлсон байна. Сургуульд суралцахад хувцас хунар, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, баяр ёслол, амралтын үеийн элдэв тэмдэглэлт арга хэмжээний зардлыг төлөхөөс гадна хэрэв дотуур байранд сууж байгаа бол хүүхэд бүр хүнсэндээ 45-60 кг махыг ар гэрээсээ нийлүүлэх хэрэгтэй болдог.

Хот, хөдөөгийн иргэд хувцас, сурах бичиг, хандивын зардлыг ядуурлын гурван үндсэн шалтгааны нэг гэж тодорхойлж байна.

Сүүлийн үеийн бичиг үсэгт тайлагдалт, сургуульд хамрагдалтын талаарх статистик тоо баримтууд нь хөдөөнөөс Улаанбаатар хотод шилжин ирээд сур-

гуульд ороогүй, сургууль завсардсан олон хүүхдийг хамарч чадахгүй байна. Статистик мэдээлэлд хамрагдаж чадахгүй байгаагийн нэг шалтгаан нь шилжин ирсэн өрхүүд нийслэл хотод оршин суух бүртгэл хийлгэдэг байсантай холбоотой. 1997 оноос эхлэн бүртгэл хийхдээ хураамж авах болсон бөгөөд хураамжийн хэмжээг 2001 онд нэмэгдүүлэн насанд хүрсэн хүнээс 50000 төгрөг, хүүхдээс 25000 төгрөг хураан авах болжээ. Шилжин ирсэн өрхүүдээс хүүхдээ сургуульд сургах, ажилд орохоос өмнө оршин суух эрхийн бүртгэлийн хураамж төлсөн байхыг шаарддаг байв. 2003 оны 7-р сарын 1-нд

Монгол улсын Хүний Эрхийн Комиссоос нэхэмжлэл гаргаж, давж заалдсаны үндсэн дээр Улсын Дээд Шүүхийн Иргэний хэргийн танхим шилжин ирсэн өрхүүдээс хураамж авч байгаа нь Монгол улсын иргэдийн оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан, зарим бүлгүүдийг хураамжаас чөлөөлснөөрөө ялгаварлан гадуурхсан арга хэмжээ болсон гэсэн дүгнэлт гаргажээ. Бүртгэлийн хураамжийн төлбөр авах шийдвэрийг Улаанбаатар хотод цуцалж, улмаар бусад хотууд ч ийм журмыг хүчингүй болгожээ.

Орон сууц, дэд бүтцийн хангамж

Хүний хөгжлийн таатай нөхцлийг бүрдүүлэхийн тулд үндсэн дэд бүтэц, орон сууцанд боломжийн хөрөнгө оруулалт шаардлагатай. Монгол оронд ийм хөрөнгө оруулалт газар зүйн байршил, орон сууцны төрлөөс шалтгаалан харилцан адилгүй байна.

Эдүгээ нийт хүн амын бараг тал хувь нь байшин, орон сууцны байранд, үлдсэн нь гэрт амьдарч байгаагаас хөдөөгийн хүн амын 78.3 хувь, хотын хүн амын 28.3 хувь гэрт амьдарч байна. Гэр, орон сууцны байшин нь дулаан, ус, ариун цэврийн хангамж, нөхцлийн хувьд өөр хоорондоо ихээхэн алгаатай.

Хүснэгт 2.7 Хот, хөдөөгийн орон сууцны нөхцөл, хувиар

Засаг захиргааны нэгж	Гэр ¹⁴				Байшин/нийтийн эзэмшлийн сууц			Бүгд
	5-аас доош ханатай	5 ханатай	6 ханатай	6-гаас дээш ханатай	1 өрөөтэй	2 өрөөтэй	3 болон түүнээс дээш өрөөтэй	
Хот	1.3	5.6	0.5	0.1	11.3	0.3	6.4	36.6
Аймгийн төв, суурин газар	1.7	4.7	1.5	0.3	4.7	4.2	2.1	19.1
Сум, баг	7.4	18.9	7.6	1.2	5.2	3.0	0.9	44.3
Бүгд	10.5	29.3	9.6	1.6	21.2	18.5	9.4	100.0

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны тооллого, 2000, УСГ.

¹⁴ Уламжлалт сууц болох гэрийн хэмжээ нь гэрийн хананы тоогоор тодорхойлогддог.

Хүснэгт 2.8 Байшин, орон сууцны нөхцөл, хувиар

Амьдрах оршин	Халуун, хүйтэн ус	Хүйтэн ус	Гүний болон инженерийн хийлгэж хууцаг	Төвлөрсөн халдлаг	Халуун усны өрөө	Гал зуухны өрөө	Цахилгаан эрчим хүчинд холбогдсон	Утас	Бохирын хөөллий, суваг	Дотроо бие засах өрөө
Хот	59.5	4.2	29.5	60.4	59.9	85.6	99.2	40.4	94.0	64.8
Аймгийн төв, суурин газар	20.5	15.7	46.7	31.8	31.4	78.5	96.4*	30.1	85.2	38.7
Сум, баг	0.0	2.2	49.1	0.0	0.0	57.4	66.0*	5.2	81.3	0.0

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны тооллого, 2000, УСГ.

Тэмдэглэгээ: * Төлөвлөгөөний дагуу цахилгаан эрчим хүчинд холбогдох гэж буй өрхүүдийг оруулав.

Хүснэгт 2.9 Гэрийн нөхцөл, хувиар

Засаг захиргааны нэгж	Гүний болон механик жуулсан хууцаг	Гал зорион, булаг шанд	Бусад	Цахилгаан насос	Утас	Бохирын хөөллий, суваг	Насос	Бие засах өрөө
Хот	78.0	8.7	13.3	89.6	4.2	73.0	77.4	95.4
Аймгийн төв, суурин газар	35.6	54.8	9.6	79.5	10.3*	76.4	78.2	90.6
Сум, баг	65.6	21.7	12.5	24.6	2.1*	71.6	42.8	70.2

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны тооллого, 2000, УСГ.

Тэмдэглэгээ: * Төлөвлөгөөний дагуу цахилгаан эрчим хүчинд холбогдох гэж буй өрхүүдийг оруулав.

Хөдөөгийн оршин суугчидтай харьцуулахад хотын оршин суугчид сууцандаа халуун усны өрөө, телефон утастай төдийгүй төвлөрсөн халаалтын болон усны системд холбогдсон байдаг. Гэтэл хотын гэр хорооллынхны 25.0 орчим хувь нь хог хаягдал, бохирын цэггүй байна. Гэр хорооллынхон усаар гачигдаж байгаагийн улмаас ил задгай, бохирдсон эх үүсвэрээс ундны ус авч хэрэглэхэд хүрч байна. Энэ байдал нь хүн амын өндөр нягтралтай нэгдэж нийлэхээрээ элдэв халдварт өвчин тархах нөхцлийг бүрдүүлж байна. Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн нийслэлүүдийн нэгд тооцогдож байгаа ч хотын ядуучуудын дийлэнхи нь төвлөрсөн халаалтын системд холбогдож чадаагүй байгаа билээ. Том хотуудад орон сууцны байшингууд нь төвлөрсөн халаалтын болон ус түгээх шугам, гэрэл цахилгаан, халуун усны болон гал зуухны тусдаа өрөөтэй.

Хотод амьдрагсад орон сууцандаа халуун усны өрөө, телефон утастай, төвлөрсөн халаалтын болон усны системд холбогдсон байдаг.

Улаанбаатар хотын орон сууцны нэг оршин суугч хоногт 240-450 литр ус хэрэглэж байхад гэр хорооллынхон дөнгөж 8-10 литр ус хэрэглэж байна. Монгол улсын орон сууц хувьчлалын үеэр хүмүүс хууль ёсны дагуу эзэмшиж байсан байраа үнэгүй хувьчилж авсан бол хөдөөгийн иргэдийн дийлэнх нь энэ хувьчлалд хамрагдаж, үр шимээс нь хүртэж чадаагүй юм.

Хотын хүн амын 60.0 хувь нь халуун, хүйтэн усаар хангагдсан байхад аймгийн төв, суурин газруудад энэ үзүүлэлт 21.0 хувьтай байна. Харин сум, багуудад халуун, хүйтэн усны хангамж байхгүй. Хотын оршин суугчдын 60.0 хувь, аймгийн төвийн оршин суугчдын 32.0 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон, халуун усны өрөөтэй байхад сум, багийн төвд ийм нөхцөлд амьдарч байгаа хүн үндсэндээ байхгүй юм. Мөн хотын иргэдийн 65.0 хувь, аймгийн иргэдийн 39.0 хувь орон сууцандаа бие засах өрөөтэй бол сум, багуудад ийм байранд амьдарч буй хүн нэн ховор. Хотын гэр хорооллын оршин суугчдын 90.0 хувь цахилгаан хэрэглэж бай-

хад, энэ үзүүлэлт аймгийн төв, суурин газруудад 80.0 хувь, сум, багуудад 25.0 хувьтай байна. Хотын гэр хороололд оршин суугчдын зөвхөн 4.0 хувь нь телефон утастай байхад энэ үзүүлэлт аймгийн төвд 10.0 хувь, сум, багт 2.0 хувьтай байгаа юм.

Шилжилтийн жилүүдэд орон сууцны байшин барих ажил үндсэндээ зогссон боловч саяхнаас дахин сэргэж эхлээд байна. Шинэ байр сууц худалдан авах нь хотын дийлэнхи иргэдэд эдийн засгийн хувьд төвөгтэй асуудал юм. Энэ нь хөдөөнөөс шилжин ирсэн иргэд гэр хороололд амьдарч байгаагийн нэг шалтгаан болж болох юм. Гэр хороололд шилжин ирж буй өрхийн хүүхдүүдийн тооны өсөлт шинээр баригдаж буй сургуулиудын тооны өсөлтөөс давж гараад байна. Иймээс зарим гэр хорооллын сургууль гурван ээлжээр хичээллэхэд хүрлээ. Хотын төвийн гэр хороололд газар ховордож, шилжин ирэгсэд хотын захад үерийн далангийн хажууд, эгц уулын хормойд, эсвэл дулааны шугамын дэргэд гэрээ барих болов. Хатуу хучилттай зам тавиагүй учраас дулааны улиралд гэр хорооллын гудамжууд шавар шавхайтайгаа хутгалдаж байна.

Гэр бол нүүдлийн хэв маягийн амьдралд зохицсон уламжлалт сууц юм. Гол төлөв гурван метрийн урттай, тав хүртэлх тооны ханатай, нүүдэл суудал хийхэд хялбар, авсаархан. Ханын тоо олон байх тусам хэмжээ нь томордог. Эсгий бүрээсийг нь халуун, хүйтний нөхцөлд тохируулж болдог. Гэрт амьдрах нөхцөл болон гэрийн эсгийг хамгаалж, гадуур нь давхар бүрээс хийх өртөг өндөр байдаг зэргээс шалтгаалан хотын зарим айлууд модон байшин барьж суух боллоо.

Шигтгээ 2.6

Төв аймгийн Арбулаг сумын малчдын санал, бодол 1999 оны 8-р сарын 31

Хөрш зэргэлдээ аймгуудаас Төв аймагт шилжин суурьшихад нөлөөлж буй хүчин зүйлүүд:

- Хил хязгаар нэвтрэн зорчих талаар улсын хяналт, хориг байдаггүй;
- Засаг захиргааны хяналт алдагдсан;
- Мал аж ахуйн бүтээгдэхүүн өндөр үнэтэй;
- Хөрш зэргэлдээ нутаг, сумдад Оросын Холбооны Улсаас хил даван малын хулгай дээрэм хийх явдал гардаг;
- Сургууль, эмнэлэг, нийслэл хотод ойр;
- Зах зээлд ойр, өргөн хэрэглээний барааны үнэ илүү боломжийн

Хүн амын хэт төвлөрлийг даган гарч буй үр дагаврууд:

- Өвөлжөө хүрэлцдэггүй;
- Усны хэрэгцээ өссөн;
- Бэлчээр доройтол, өвөлжөө булаалдсан зөрчилдөөн;
- Зах зээлийн өрсөлдөөн нэмэгдсэн;
- Зуны соргог бэлчээр булаалдсан зөрчилдөх болсон;

- Малын жин буурч, малыг олноор нь нядлах болсон, малын ашиг шим буурсан;
- Хот суурин газраас хулгайн анчид ирж байгаль ан амьтан сүйтгэх;
- Ярилцаж хэлэлцэх замаар бэлчээрийн зөрчилдөөнийг зохицуулан шийдвэрлэх.

Тэнцвэртэй байдлыг бий болгох талаар малчдын өгсөн саналууд:

- Хөрш зэргэлдээ аймаг, орон нутгийг хөгжүүлэх;
- Улс төрийн тогтвортой байдлыг бүрдүүлэх;
- Мал аж ахуйн бүтээгдэхүүний үнийг нэмэх;
- Бүс нутгийн хөгжил;
- Төрөөс тэтгэвэр олгох;
- Засгийн газраас тогтоол гаргаж наймаачдын зүгээс малын үнийг өөрсдийн үзэмжээр тогтоож буй явдлыг зогсоох;
- Түлш, шатахууны үнийг Засгийн газар зохицуулах зэрэг болно.

Эх сурвалж: ГТТХАА Тайлангууд. Үнэлгээний ажлын хэсгээс боловсруулсан зорилготой бүлгийн хэсгийн тайлан, “Монгол улс дахь цөлжилтэй тэмцэхэд чиглэсэн цогцолбор менежмент,” Говь гурван сайхан тусгай хамгаалалттай газар, Хамгаалалттай газрын менежментэд олон нийтийн оролцоог хангах, хуудас 16-17.

Цахилгаан шугам сүлжээнд холбогдоогүй хөдөөгийн иргэд ойгоос мод бэлтгэн түлшиндээ хэрэглэдэг. Эрс тэс цаг ууртай Монгол орны нөхцөлд өвлийн улиралд орон байраа дулаалах явдал чухлаар тавигддаг. Гэр хорооллын оршин суугчид мод, нүүрсийг түлшиндээ зонхилон хэрэглэж байгаагаас хотын агаарыг бохирдуулах болов. Мод, нүүрсний утаа нь хүйтний улиралд үзэгдэх орчинг хязгаарлаж, амьсгалын замын болон зүрх судасны өвчин үүсгэх нэг шалтгаан болж байна.

Мэдээллийн хүртээмж, ашиглалт

Даяаршин буй ертөнцөд шинэ соргог мэдээлэл, технологийн хүртээмж өрсөлдөөний нэн чухал хүчин зүйл болон хувирч буй өнөө үед хот хөдөөгийн хооронд энэ тал дээр ялгаа байсаар л байна. Ардчилал хөгжиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө хангагдаж, гадаад харилцаа өргөжиж, мэдээлэл, харилцаа холбооны салбарт гадаадын хөрөнгө оруулалт их хэмжээгээр хийгдсэний үрээр сүүлийн 10 жилд Монгол улсад мэдээллийн хүртээмж эрс сайжирлаа. Гэвч энэхүү хөгжил дэвшил зөвхөн хотууд болон томоохон суурингуудад явагдаж, шинэ мэдээлэл хангагдах нөхцөл нь сайжирч байна. 2000 оны АТОАҮС-д хамрагдагсдын үзэж буйгаар хөдөө орон нутаг мэдээллийн өлсгөлөнд автагдсан хэвээр байгаа бөгөөд харилцаа холбооны үйлчилгээ туйлын

Хөдөөд сонин, хэвлэл унших, телевиз үзэх, утсаар ярих боломж хязгаарлагдмал, зарим газар хүмүүс хуучин сонин сэтгүүл гар дамжуулан уншицгааж байна.

их эрэлттэй байгаа ажээ. Хүмүүс улсын хэмжээнд батлан гаргасан хууль тогтоомж, бодлогын асуудлаар мэдээлэл авах хүсэл ихтэй, эдгээр хууль тогтоомж орон нутагт нь хэрэгждэггүй талаар ярьжээ. Хөдөөгийн иргэдийн хувьд утсаар ярих, цахилгаан, шуудан явуулахад харилцаа холбооны үйлчилгээ нэн чухал байдаг. Нэгдэл, сангийн аж ахуй тарснаар хурал цуглаанаас л мэдээлэл олж авах болсон байна.

Шилжилтийн жилүүдэд хөдөө орон нутагт мэдээллийн солилцоо үнэндээ багасчээ. Сонин хэвлэл унших, телевиз үзэх, утсаар ярих боломж хязгаарлагдаж, зарим газар хүмүүс хуучин сонин сэтгүүлийг гар дамжуулан уншицгааж байна. Социализмын үеийн сум багт сонин хэвлэл хүргэдэг байсан тогтолцоо үгүй болсон атал түүнийг орлох тогтолцоо бүрдээгүй байна. Хөрөнгө мөнгөний хомсдолоос шалтгаалан орон нутгийн олон сонин тогтмол хэвлэгдэн гарахаа больж, найман аймагт сонин хэвлэх ажил үндсэндээ зогсчээ. Алс хязгаарын сумдад сонин ховор зүйлд тооцогдох болов. 2000 оны байдлаар 160 сонин, 37 сэтгүүл тогтмол хэвлэгдэж байсан бөгөөд бараг бүх сонин, ихэнхи сэтгүүлийг хот, томоохон суурин газруудад борлуулж байв. Ерөнхийдөө нэг хүнд ногдох хэвлэмэл материалын тоо 3.6 байснаа 1.2 болж буурчээ. Нийтийн номын сангийн тоо 1990 онд 421 байсан бол 2002 онд 305 болж цөөрсөн төдийгүй 331 сумын тэн хагас нь номын сангүй болсон юм.

Малчдын авах мэдээлэл богино долгионы радиогоос ихээхэн хамаарч байна. Тун саяхнаас хэд хэдэн аймагт богино долгионы радио станц, радио цэгүүд ажиллаж эхлэв. 2002 оны байдлаар 35 радио станц, 27 телевиз, 11 кабелийн телевиз тогтмол нэвтрүүлэг явуулж байлаа. Улаанбаатар хотод 30000 гаруй өрх кабелийн телевизтэй байхад хөдөөд ийм үйлчилгээ бараг байхгүй байна. Улаанбаатар хотод эмэгтэйчүүдийн 5.0 хувиас бусад нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглаж байхад Баруун болон Зүүн бүсийн эмэгтэйчүүдийн 90.0, түүнээс дээш хувь нь ийм боломжоор хангагдаагүй байна.

Улсын хэмжээнд 2002 онд бараг 260 мянган хүн гар утас ашиглаж байгаа бөгөөд сум, багуудад сургууль, эмнэлэг зэрэг албан байгууллагуудад л ердийн утас хэрэглэх төдий байна. Өвөлжөөндөө буусан эсвэл багт амьдарч буй малчид ойрын телефон утасны цэгээс хэдэн зуун километрийн цаана алслагдсан байх нь ч бий. Ийм нөхцөлд түргэн тусламж дуудах боломж бараг үгүй, үүний тулд морь, мотоциклоор хол зай туулахад хүрдэг. Өвөл цас их орж, зам хаагдсан үед тусгаарлагдмал байдал бүр ч нэмэгддэг. Иймээс хот суурин газар 20-30 минутын дотор гар утсаар дамжуулан түгээж болох хурим найр болон бусад ёслолын арга хэмжээний зар хөдөөд 2-3 хоногийн дараа ам дамжин хүрч байна.

Мэдээллээс хол тасархай хүмүүс илүү эмзэг байдалд аж төрж, эдийн засгийн болон бусад боломжуудаас хүртэж чадахгүй байна. Жишээлбэл, хотын иргэд ажил хайх, бизнес гэрээ байгуулах, олон улсын зах зээлд орох, бизнесээ санхүүжүүлэх эх үүсвэр хайхдаа мэдээллийг ашигладаг. 2002 онд

судалгаанд хамрагдсан малчид арьс шир, ноос, ноолуураа аль болох ашигтай үнээр борлуулахын тулд зах зээлийн үнийг байнга хянаж, судалж байх сонирхолтой байдгаа илэрхийлж байв. Мэдээлэл нь малчид, аялагчдад цаг агаарын гэнэтийн хүндрэлийн талаар урьдчилан сэрэмжлүүлэх, алслагдсан хүмүүсийг холбох, Засгийн газрын үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

Оролцоо

Газар зүйн байршил нь улс төр, нийгмийн оролцоонд ч нөлөөлж байна. Хэдийгээр орон нутгийн болон улсын хэмжээний сонгуульд оролцох түвшин хөдөөд хотынхоос өндөр байсан боловч орон нутгийн сонгуульд оролцсон оролцоо улсын хэмжээний сонгуулиудад оролцсон түвшингээс хавьгүй доогуур байв. 2000 оны Улсын Их Хурлын сонгуульд хотын сонгогчдын 76.0 хувь, хөдөөгийн сонгогчдын 86.0 хувь саналаа өгчээ.



Улсын Их Хурлын сонгуульд оролцож өгсөн саналын тоо хотод 8.0 хувиар, хөдөөд 11.0 хувиар тус тус буурсан байна. Жишээ нь, 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуульд хотын сонгогчдын 79.0 хувь, харин хөдөөгийн сонгогчдын 84.0 хувь оролцож саналаа өгчээ. Хотод шилжин ирсэн хүмүүс оршин суух газраа бүртгүүлсний дараа сонгуульд оролцох эрхтэй болдог тул бодит байдал дээр сонгуульд оролцсон хүмүүсийн эзлэх хувь үүнээс доогуур ч байж болох талтай.

Мэргэжлийн холбоо, эсвэл хөдөлгөөнүүдийг оролцуулаад Төрийн бус байгууллагууд (ТББ)-ын тоо 1997-2001 онд 410-аас 2214 хүртэл хэд дахин өссөн боловч шийдвэр гаргах үйл явцад тэдний дуу хоолой төдийлөн сонсогдохгүй байна. Энэ тал дээр ч хот, хөдөөд ялгаатай байдал үүсчээ. Хотын иргэд оролцооны байдлаараа ямар нэг хэмжээгээр давуутай байгаа билээ.



Дүгнэлт

Монгол орны цаг агаар, газар зүйн нөхцөл байдал, хүн ам зүйн бүтэц нь нийт хүн амд үйлчилгээг нэгэн жигд үзүүлэхэд бэрхшээл учруулж байна. Хүн амын нягтрал ихтэйн улмаас үйлчилгээний өртөг зардал хямд байдаг хэдхэн том хотуудад эрүүл мэнд, соёлын үйлчилгээ, өргөн хэрэглээний бараа, ажлын байр төвлөрчээ. Эдүгээ илт мэдэгдэх болсон хот, хөдөөгийн ялгааг социализмын жилүүдэд хүн амын шилжих хөдөлгөөнийг хязгаарлах, бүс нутгийн хөгжлийг дэмжиж чадах бүтэц байгууламжуудыг хөдөө орон нутагт байгуулах замаар тогтоон барьж байв. Гэвч эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжих явцад хот, хөдөөгийн ажил эрхлэх боломжид тэгш бус байдал үүсч, ялгаатай байдал гүнзгийрэх болсныг эрүүл мэнд, боловсрол, орлогын талаарх статистикийн тоо баримтууд харуулж байна.


Хот, хөдөөгийн хүн амын боломжид үүссэн ялгаатай байдлыг бодлогод тусгахад анхаарах хэрэгтэй болжээ. Хөдөөгийн хүмүүс хотод шилжин ирж хотын ядуурлыг нэмэгдүүлж байна. Иймд хөдөөгийн ядуурлын асуудал нь хүн амын аж байдлын нэн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нь хөдөө орон нутагт сонголтын боломж хомсдоны илрэл юм. Шилжих хөдөлгөөн нь хөдөөгийн хүмүүсийн хувьд шилжилтийн үед нүүрлээд байсан бэрхшээл хүндрэл, тодорхойгүй нөхцөл байдлыг даван туулах арга замуудын зөвхөн нэг нь байсан билээ. Хөдөөгийн иргэдийн үр бүтээлтэй ажиллах, сайн сайхан амьдрахын аль алинд нь учирсан саад бэрхшээлийг дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийх замаар шийдвэрлэх боломжтой. Орон нутгийн төвшинд төвлөрөлийг сааруулж, мэдээллээр хангагдсан иргэний нийгмийг байгуулснаар хөдөөг хөгжүүлж, шилжих хөдөлгөөний шалтгаан болж буй бүс нутгуудын хөгжлийн тэнцвэргүй байдлыг арилгаж чадна. Өсөн нэмэгдэж буй орон зайн ялгаатай байдлын шалтгааныг тодруулж, бодлогын арга хэрэгслүүдээрээ дамжуулан хүмүүст учруулж буй бэрхшээл, зовлонг багасгаж, хүмүүсийн хариу үйлдэл үзүүлэх чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ бий болжээ.



БҮЛЭГ 3



**ӨӨРЧЛӨЛТӨД
ҮЗҮҮЛЖ БУЙ
ХАРИУ ҮЙЛДЭЛ**



Өөрчлөлтөд үзүүлж буй хариу үйлдэл

Монгол улс эдийн засаг, улс төр, бүтцийн огцом өөрчлөлт хийн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцад орон зайн тэгш бус байдал болон хүмүүсийн баталгаагүй байдал нэмэгдсэн юм. Төрөөс хүний аюулгүй байдлыг хангах тухай уламжлалт ойлголт үгүй болж, төр үүрэг, хариуцлага шинээр тодорхойлж байсан энэ үедээ санхүүгийн хувьд туйлдан доройтсон байлаа. Тиймээс өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлын улмаас хүмүүс шинэ нөхцөл байдалд амьжиргаагаа залгуулах аргыг эрэлхийлэх боллоо. Бодлогоын өөрчлөлт нь сул, удаан байсан төдийгүй, нэмэгдэж буй орон зайн тэгш бус байдал, хүмүүсийн бэрхшээл зовлонг шийдвэрлэхэд төрөөс бага анхаарчээ.

Нийгмийн өөрчлөлт

Шилжилтийн эдийн засагтай зарим улс орнуудын адилаар Монгол улс ахар богинохон хугацаанд өмч хувьчлах, үнэ чөлөөлөх, худалдааны хориг саадуудыг цуцлах арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн үүрэг оролцоог бууруулах замаар эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөө хэрэгжүүлсэн билээ. Үүний улмаас ядуурал, инфляци, эдийн засгийн баталгаагүй байдал огцом нэмэгдэж, орлого хуваарилалтын тэгш бус байдал гүнзгийрчээ. Шилжилтийн эхний жилүүд буюу 1990-1993 онд олон тооны үйлдвэр, аж ахуйн газрууд дампууран үйлдвэрлэл нь уналтанд орж, олон мянган хүн ажилгүй болов. Мөн хугацаанд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 41.0 хувиар буурчээ. Хүнс, нэхмэл сүлжмэл, хувцас, арьс шир боловсруулах, төмөрлөг болон уул уурхайн олборлох үйлдвэрлэл зэрэг бараг бүх салбарт үйлдвэрлэлийн хэмжээ ихээхэн буурав. Монголд ажилгүйдэл, ядуурал бодит үзэгдэл болов. Энэ нь хотын олон иргэдийг хөдөө орон нутаг руу нүүж, мал маллахад хүргэв. Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдын тоо 1990-1994 онд 258.8 мянгаас 336.6 мянга болж өсчээ (Шинэ

Монгол Улсын эдийн засгийн шилжилттэй холбоотой бүтцийн өөрчлөлт нь үнэ чөлөөлөх, өмч хувьчлал, худалдааны хориг саадыг цуцлах, Засгийн газрын цомхотгол, үйлдвэрлэлийн эрс уналт, ажилгүйдэл, ядуурал газар авахад хүргэсэн.

фермерүүдийн нэлээд нь газар, тариалангийн талаар ямар ч мэдлэггүй байв). Мал маллах арга ажиллагааны талаар мэдлэг нимгэн малчдын тоо ч нэмэгдэв. Эдгээр нь хөдөө аж ахуйн салбарын бүтээмж эрс буурахад нөлөөлж байгаа юм.

Мал аж ахуй, газар тариалангийн салбар руу чиглэсэн хүмүүсийн урсгал эрчимжсэн боловч энэ салбарт зээл авах боломж өргөжсөнгүй. Хөдөөг хөгжүүлэхэд шаардлагатай банк, санхүү, даатгалын тогтолцооны дэмжлэг үндсэндээ байсангүй. Шилжилтийн эхний жилүүдэд зарим томоохон

банкууд дампуурч, олон мянган малчид хадгаламжаараа хохирч үлдсэн сургамж хөдөөгийн малчдын банкинд итгэх итгэлийг алдагдуулав. Өнөөдөр ч хөдөө орон нутагт зээл авах, хадгаламж эзэмших, өмч хөрөнгөө даатгуулах боломж хомс хэвээр байна. Үүний зэрэгцээ банкны зээлийн хүү өндөр, хугацаа богино байгаагаас малчид, тариаланчид зээл авах сонирхол бага, нөгөөтэйгүүр зээл авахыг хүссэн ч барьцаанд тавих өмч хөрөнгө тэр бүр байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд хөдөө нутагт мал хөрөнгөө даатгуулах сонирхол өсч байгаа хэдий ч эрсдэл өндөртэй мал аж ахуйг даатгах сонирхолтой даатгалын байгууллагууд байхгүй байна. Хэрэгцээт бараагаа мал, түүхий эдээр сольж авдаг бартерын худалдаа өнөөг хүртэл хийгдсээр л байна. Хөдөө аж ахуйн нэгдлүүд тарж, түүхий эд нийлүүлэх төвлөрсөн тогтолцоо задарсны улмаас хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэрүүд хаагдсан юм. Үүний улмаас малчид нэлээд бэрхшээлтэй тулгарсан. Юуны өмнө, малчид бэлтгэсэн түүхий эдээ худалдах шаардлагатай атал шинээр гарч ирсэн хувийн хэвшлийнхэн хуучин нэгдлийн гүйцэтгэж байсан үүргийг хүлээн авах чадвар ч үгүй, сонирхол ч үгүй байв. Энэ нь түүхий эдийг боловсруулалгүйгээр экспортлоход хүргэсэн билээ. 2002 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт бэлтгэгдсэн ноосны 65.0 хувь, хонины ноосны 60.0 хувь, тэмээний эм ноосны 65.0 хувь, бодын ширний 20.0 хувь, бог малын ширний 35.0 хувийг анхан шатны боловсруулалтад оруулж, ноолуурын 30.0 хувь, нэхийний 30.0 хувийг тус тус эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглажээ. Эдгээр анхдагч түүхий эдийг огт боловсруулалгүйгээр, эсвэл анхан шатны боловсруулалтад оруулан экспортлож байгаагаас улс орны эдийн засаг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн ихээхэн хэмжээний нэмэгдэл өртөг олох боломжоо алдаж, худалдааны нөхцөл муудахад хүрч байна. Хөдөөгийн малчид, бизнес эрхлэгчид зах зээлээс алслагдсаны зэрэгцээ бизнесийн хэрэгцээтэй мэдээллээр дутагдаж байна.

Төрийн өмчийг эхлээд эрхийн бичгээр, дараа нь худалдах журмаар хувьчлах ажил 1990 оноос эхэлж, өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Энэ нь өмчийн олон хэлбэрт тулгуурласан эдийн засгийн тогтолцоо байгуулах үйл явцыг амжилттай хэрэгжүүлж, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох шинэ шинэ боломжуудыг хүмүүст олгож, харилцан адилгүй хэмжээгээр өргөжүүлсэн юм. Жижиг, дунд үйлдвэр, мал сүрэг, тоног төхөөрөмжийн хувьчлалаар үйлдвэр аж ахуйн газрууд дадлага, туршлагагүй хүмүүсийн гарт очжээ. Эдгээр үйлдвэрийн газруудын дийлэнхи нь хөрөнгө, тоног төхөөрөмж, түлш шатахуун, түүхий эд материалын хомсдолын улмаас үйл ажиллагаагаа зогсоосон байна. Түүнчлэн хувьчлал хот, хөдөө дэх нөөц баялгийн хуваарилалтад ч нөлөөлжээ. Хувьчлалын үр шимийг хүн бүр адил тэгш хүртэж чадаагүй бөгөөд хувьчлал нь баян

Шилжилтийн явцад Монголын хот, хөдөө хоорондын ялгаа ихэссэн.

хоосны, хот, хөдөөгийн тэгш бус байдал ихсэх гол шалтгааны нэг болсон юм.

Монгол улс эдийн засгийн шилжилтийн зэрэгцээ улс төр, бүтэц, зохион байгуулалтын томоохон өөрчлөлтүүдийг хийв. 1992 оны “Үндсэн хууль” нь Монголд сайн засаглалын зарчмуудын үндэс суурийг тавьж өгсөн юм. Иргэдийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох, улс төрийн нам, сайн дурын бусад байгууллагад чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулав. Иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхээр ч хангагдлаа.

Монгол улсын “Үндсэн хууль” болон “Төрийн албаны тухай” хуулиар төрийн үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж өгөв. Монгол улс төрийн үйлчилгээний тогтолцоог 1995 оноос

Улс төрийн өөрчлөлт шинэчлэлтийн хүрээнд хүчирхэг иргэний нийгэм, үр нөлөө бүхий шүүхийн тогтолцоо, хүний эрх, хууль дагаж мөрдөх журам болон сайн засаглалын төрийн дэмжлэг бүхий хөгжил багтаж байв.

бүрдүүлж эхэлсэн хэдий ч төрийн албаны байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бэхжүүлэх шаардлагатай байна. Сөрөг намууд засгийн эрхийг ээлжлэн авсан

1996, 2000 онуудад “Төрийн албаны тухай” хуульд заасан зарчмууд, төрийн алба нь үзэл суртлаас ангид байх тухай журмыг олонтаа зөрчсөн талаар мэдээлж байв. Мөн хугацаанд ажил үүргээ гүйцэтгэж байсан олон арван төрийн албан хаагчдыг албан тушаалаас нь халсан болохыг Хүний эрхийн үндэсний комиссоос олж тогтоожээ. Засгийн газрын Төрийн албаны Зөвлөл эдгээрийн аль аль тохиолдолд гавъяа зүтгэлийн (мерит) зарчимд суурилсан тогтолцоог хамгаалах үүргээ үр нөлөөтэй гүйцэтгэсэнгүй. Засаглалын бүтэц, зохион байгуулалт хувьсан өөрчлөгдсөөр ирсэн бөгөөд энэ нь цаашид ч үргэлжлэх хандлагатай байна.

Иргэдээс үзүүлж буй хариу үйлдэл

Улс орны эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийн дүнд: 1) хөдөөгийн нүүдэлчид, 2) хот суурин газрын

Бүх салбарыг хамарсан эдийн засгийн өөрчлөлтийн хариуд монголчуудын дийлэнхи нь шинэ боломж бололцоо хайн өөр газар руу шилжин суурьших, цар хүрээгээ улам бүр тэлсээр байгаа албан бус секторт ажиллах, төрөлтөө цөөлөх, мал маллаж амьжиргаагаа залгуулах зэрэг янз бүрээр дасан зохицохыг чармайж байна.

гэр хорооллын-хон, 3) орон гэргүй хүмүүс, 4) хотын орон сууцанд оршин суугчид, 5) аймаг, сумын төвд амьдарч буй хүмүүс гэсэн хүн амын 5 ялгаатай бүлгүүд бий болжээ.

1990-ээд оны эдийн засгийн шилжилтийн

хүнд хэцүү цаг үед дасан зохицож, амьжиргаагаа залгуулахын тулд монголчууд янз бүрийн аргуудыг хэрэглэж байв. Бүхий л салбарыг хамарсан эдийн засгийн өөрчлөлтийн хариуд монголчуудын дийлэнх нь шинэ боломж бололцоо хайн өөр газар руу шилжин суурьших, улам бүр өргөжин тэлсээр байгаа албан бус секторт ажиллах, төрөлтөө цөөлөх, мал маллаж амьжиргаагаа залгуулах зэрэг янз бүрээр дасан зохицохыг чармайх болжээ. Тухайлбал, аж үйлдвэр уналтад орж, Засгийн газар орон тооны цомхотгол хийж байх үед жижиг үйлдвэр хөгжих таатай нөхцөл болж чадах хоёрдмол шинж бүхий албан бус секторт олон хүн ажил эрхлэх болов. Хүмүүс шилжих хөдөлгөөнд хэдэн арван мянгаараа оролцож, хотжилтыг эрчимжүүлсээр байна. Үүний зэрэгцээ монголчууд цөөхөн хүүхэдтэй байхыг илүүд үзэх болжээ. Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, ядуурал буурах нөхцөлд хүмүүсээс үзүүлж буй хариу үйлдлүүд эдгээрт зохицож, өөрчлөгдөх төлөвтэй байна. Албан бус секторт ажил эрхлэх, хол явж худалдаа наймаа хийх зэрэг амьжиргааны зарим аргуудыг орлогоо нэмэгдүүлэх гол эх үүсвэр болгон ашиглах боломжтой боллоо.

Төрөлтийн түвшний бууралт

Эдийн засгийн хямралын үед дундаж орлого огцом буурснаар эмэгтэйчүүд олон хүүхэд төрүүлж, өсгөх санхүүгийн дарамтаас зайлсхийх сонголт хийснээр төрөлтийн түвшин буурав. Хүн ам 1989 онд 2.7 хувиар өсч байсан бол 1999 онд жилийн дундаж өсөлт 1.4 хувь болж буурчээ. Эдийн засгийн эмзэг байдалд орохгүйн тулд цөөн хүүхэд төрүүлэх, төрөлт хоорондын зайгаа уртасгах болсноор төрөлтийн түвшин сүүлийн 10 жилийн дотор бараг 52.0 хувиар буурсан байна.

Ийнхүү төрөлт буураагүй бол 2000 онд хүн ам 9.0 хувиар илүү бөгөөд нэг хүнд ногдох орлого доогуур, ядуу амьдралтай хүмүүсийн тоо их байх байжээ. Энэ бол оновчтой хариу үйлдэл байв. Хагас эсвэл бүтэн өнчин хүүхдүүд, ахмад настангууд, олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд, тахир дутуу иргэд болон ажилгүйчүүд нь эдийн засгийн шок, дарамтад илүү өртөмтгий хүн амын бүлэгт тооцогддог.

Мөн хугацаанд гэрлэлтийн түвшин ойролцоогоор 40.0 хувиар буурсан, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийг түгээмэл хэрэглэх болсон, жирэмслэлтээ зогсоохын тулд үр хөндөлтөд найдах нь нэмэгдсэн, төрөлт хоорондын зай уртассан зэрэг нь төрөлтийн түвшин буурахад нөлөөлсөн хүчин зүйлс болж байна.

Эдийн засгийн эмзэг байдалд орохгүйн тулд цөөн хүүхэд төрүүлэх, төрөлт хоорондын зайгаа уртасгах болсноор төрөлтийн түвшин сүүлийн 10 жилийн дотор бараг 52.0 хувиар буурсан байна.

Өнөөдөр төрөлтийн нийлбэр коэффициент нөхөн үржихүйн насны нэг эмэгтэйд 2.1 байгаа нь хүн амын эргэн нөхөгдөх түвшинг дөнгөж л хангаж

байгаа юм. 2002 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн ерөнхий коэффициент 19.1 байсан нь 1989 оны 35.5 коэффициенттэй харьцуулахад 47.5 хувиар бага байна. Хот суурин газар, зүүн бүс, нийслэлд оршин суудаг болон 4-өөс доош жилийн боловсролтой эмэгтэйчүүдийн хувьд төрөлт илүү буурчээ. Үндсэндээ хөдөө нутагт тооцогддог баруун бүсэд төрөлтийн ерөнхий коэффициент 1989 онд 1000 хүн ам тутамд 40 ногдож байснаа 27 болж буурав. 1998 оны НҮЭМС-гаар нэг эмэгтэй дунджаар 3 хүүхэд төрүүлж байсан бөгөөд энэ үзүүлэлт хотод 2.5, хөдөөд 3.7 байв.

Хотын эмэгтэйчүүд мэдээлэл олж авах, үр хөндүүлэх, жирэмлэлтээс урьдчилан сэргийлэх, хүнд хэцүү тохиолдолд сонголт хийх боломж сайтай байгаа учраас хотод төрөлт илүү буурсан байна. Төрөлтийн түвшний энэ хандлага шилжилтийн эдийн засагтай бусад орнуудын сүүлийн 10 жилийн хандлагатай ижил төстэй байна. Гэхдээ манай улсын нэг гол өвөрмөц ялгаа нь төрөлтийг бүхий л талаар урамшуулан дэмжих хатуу бодлого хэрэгжүүлсээр байтал төрөлт буурсан явдал юм. Төрөөс хүн амын бодлогоор дамжуулан хүн амын жилийн өсөлтийг 1.8 хувиас доошгүй хэмжээнд байлгах нөхцлийг бүрдүүлэхээр чармайн ажиллаж байна. Энэ хүрээнд нялхас, 5 хүртэлх настай хүүхдийн эндэгдлийг 1990 оны түвшингээс гуравны нэгээр, эхийн эндэгдлийг мөн үеийнхээс 50.0 хувиар бууруулахаар зорьж байна. Үүний үр дүнд төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг уртасгах бас нэгэн зорилго тавьсан билээ. Эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар 1992 онд бүх аймаг, хотын захиргаанд төлөөлөл бүхий Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамыг байгуулав. Засгийн газраас гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдээллийг тараах боллоо. Эдийн засгийн баталгаагүй байдлын улмаас төрөлтийн түвшин буурсан учир төрөлтийн түвшинг нэмэгдүүлэх хамгийн үр ашигтай арга зам бол эдийн засгийн хөгжлийг дэмжих, түүний дотор боловсрол, дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт хийх явдал гэдгийг олон хүмүүс хүлээн зөвшөөрөх болжээ.

Хүснэгт 3.1 Хүн ам зүйн үзүүлэлтүүд, бүсээр, 1989, 2000

Бүс	Төрөлтийн ерөнхий коэффициент		Нас баралтын ерөнхий коэффициент		Ердийн өсөлтийн коэффициент	
	1989	2000	1989	2000	1989	2000
Улаанбаатар	30.4	15.2	7.6	6.5	22.8	8.7
Зүүн	36.3	20.2	9.3	7.0	26.9	13.2
Төв	35.9	20.6	8.0	6.8	27.9	13.8
Хангай	42.2	22.1	9.3	6.4	32.9	15.7
Баруун	39.8	27.2	8.2	5.8	31.6	21.3

Эх сурвалж: Хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн, 2000, УСГ.

Хүснэгт 3.2 Тооллого хоорондын хүн амын өсөлт, бүсээр, 1979-1989, 1989-2000

Бүс	Тооллого хоорондын өсөлт (%)	
	1979-1989	1989-2000
Улсын дундаж	42.7	15.3
Баруун	35.8	-5.0
Хангай	55.2	7.9
Төв	55.7	-5.8
Зүүн	41.8	4.4
Улаанбаатар	36.7	44.6

Эх сурвалж: Монгол улсын хүн ам, орон сууцны 1979, 1989, 2000 оны тооллогын мэдээлэлд үндэслэсэн тооцоо, УСГ.

Мал маллах болсон нь

1990-ээд оны эхэн үед зонхилж байсан хотоос хөдөө уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн нь ажил эрхлэлтэд гарсан бүтцийн гүнзгий өөрчлөлттэй давхцсан юм. Хотын ажилгүй иргэд хөдөө рүү шилжин, хөдөө аж ахуйн салбарт ялангуяа, шинэхэн хувьчлагдсан мал аж ахуйн салбарт ажиллаж амьжиргаагаа залгуулах болов. Шилжилтээс өмнөхөн ажиллах хүчний гуравны нэг хүрэхгүй хувь нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байсан бол 2000 оны байдлаар ажиллах хүчний тэн хагас нь хөдөө аж ахуйн салбарт ажил эрхэлж байв. Энэ үзүүлэлт сүүлийн 11 жилийн хугацаанд 45.0 хувиар өссөн байна.

Түүнчлэн 1993 оноос ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин өсчээ. Барилга угсралт, тээвэр худалдаа, харилцаа холбоо, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн уналттай зэрэгцэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 1991 онд 14.1 байснаа 1993 онд 35.1 болж эрс өссөн байна.

Энэ үеэс хөдөө аж ахуйн салбарт мал аж ахуй ихээхэн давамгайлах боллоо. 1989 онд хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд мал аж ахуй 70.0 хувийг, үлдэх хэсгийг нь газар тариалан эзэлж байсан бол 1999 онд мал аж ахуй 90.0 хувийг эзэлж байв. 1990 онд мал маллан амьжиргаагаа залгуулдаг өрхийн тоо 74710 байсан бол 2000 онд 191526-д хүрсэн байна. Харин ийм хүн амын тоо 1990 онд 147508 байсан бол 2000

онд 421392 болжээ. Өнгөрсөн арван жилийн эцэс гэхэд хөдөө аж ахуй эдийн засгийн хамгийн томоохон салбар болж, үйлдвэрлэлд мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн зонхилох болсон байна. Хотоос олон арван мянган ажилгүйчүүд амьжиргаагаа залгуулахын тулд энэхүү салбар руу шилжин ирэх үед төрөөс үзүүлж байсан үйлчилгээ, дэд бүтэц үгүй болсон юм. Шинэ ажиллах хүчнийг шингэсэнээрээ уг салбарын нэг хүнд ногдох бүтээмж амиа аргацаах төдий хэмжээнд хүртлээ буурч, мал аж ахуйн салбарт шилжих явдал өрхийн амьжиргаагаа залгуулах нэг арга болохоос хэтэрсэнгүй. Мал аж ахуйн салбарт хүмүүс олноор шилжин ирсний зэрэгцээ дадлага туршлагагүй малчдын тоо нэмэгдэв.

Малчид орлогын олон эх үүсвэртэй болох, өмч хөрөнгөө зарах, төрөл садангийн харилцаа холбоогоо зузаатгах, албан бус секторын мөнгө хүүлэгчдээс зээл авах зэргээр өөрчлөгдөн буй нөхцөл, хямралт байдалд хариу үйлдэл үзүүлсээр иржээ. Гэвч амь зуух бусад аргуудын нэгэн адил эдгээр нь эрсдлийг бууруулдаг бүтэц, байгууламжууд устаж үгүй болсны хариуд хийгдсэн алхмууд бөгөөд үүнээс өөр арга зам үнэн хэрэгтэй байсангүй. Гэхдээ мал аж ахуй амьжиргааны тогтвортой бус, ашиггүй арга хэрэгсэл болж хувирахад хэд хэдэн хүчин зүйлс нөлөөлсөн байна. Нэгдүгээрт, 1990-2000 онд нэг малчин өрхөд ногдох малын тоо толгой 54.0 хувиар, нэг малчинд ногдох малын тоо 59.0 хувиар буурсан нь хөдөлмөрийн бүтээмж унахад нөлөөлжээ. Мөн хугацаанд улсын хэмжээнд малын нийт тоо толгой өссөн хэдий ч зах зээлийн нөлөөгөөр сүргийн бүтэц нэлээд өөрчлөгдөв. 1990-1999 онд малын тоо толгой 25.9 саяас 33.6 сая болж 29.7 хувиар өссөн юм. Эдгээр жилүүдэд ноосны зах зээл хумигдаж байсан ч хонин сүргийн тоо толгой харьцангуй тогтвортой байлаа. Харин Хятад болон бусад орнуудад ноолуур экспортлох шинэ боломжууд бий болсноор ямаан сүргийн тоо толгой 215.3 хувиар өсчээ. Тэмээний махыг бага орлоготой өрхүүд хүнсэндээ хэрэглэж байгаагаас тэмээн сүргийн тоо толгой 34.0 хувиар буурсан байна. Харин адуун сүргийн тоо толгой 40.0 хувиар өссөн нь малчдын тоо өссөнтэй холбоотой байж болох талтай.

Шигтгээ 3.1

Эмэгтэйчүүд ба ноолуур

Шилжилтийн жилүүдэд Өмнөд бүсэд ноолуурын ямааг төрөлжүүлэн өсгөх болсон нь орлогын гол эх үүсвэр болжээ. Хонь, ямааны харьцаа 1:1 байснаа 3:1 болов. Хөдөлмөрийн хуваарийн дагуу эмэгтэйчүүд голлон малладаг уламжлалтай ямааны ноолуурын эрэлт өссөн нь ямаан сүргийн тоо толгойг нэмэгдүүлэв. Түүхий ноолуурыг самнаж авах нь хүнд бэрх бөгөөд гар хөдөлмөр ихээр шаардсан ажил юм. Бэлчээр нутаг ихтэй, ажиллах хүчин хямд байдаг нь манай улсын өрсөлдөх давуу тал билээ. Хөдөөгийн зах дээр самнаагүй ноолуурыг килограммыг нь 13-30 ам.доллараар худалддаг боловч үүн дээр наймаачдын үнэ нэмэгдэнэ. Эмэгтэйчүүд түүхий

ноолуур боловсруулах үйл ажиллагаанд түлхүү оролцдог бөгөөд зах зээлд борлуулах үйл ажиллагаанд эрчүүдтэй хамтран оролцож байдаг. Төрийн өмчийн үйлдвэр болох “Говь” болон бусад худалдаачид шинэ зах зээлд тодруулбал Хятад улстай хил орчмын худалдааг хийх болов. Харамсалтай нь, Хятадтай хийдэг хил орчмын худалдаанд хятадын тал импортын хориг тавьсан юм. Олон малчин түүхий ноолуураа зуучлагчдад худалдах эсвэл тэдэнтэй бараа солилцох хэлбэрээр арилжаалж байна. Янз бүрийн зах зээлүүдээс үнэ, ханшны мэдээлэл авахгүйгээр алс хязгаарын малчид ашигтай нөхцөлөөр худалдаа хийж чадахгүй юм.

Эх сурвалж: Монголын эмэгтэйчүүд: Шилжилтийн үйл явцыг зураглахуй, 2001, НҮБЭХС.

Мал аж ахуйг амьжиргааныхаа эх үүсвэр болгосноор өрхийн доторх эмэгтэйчүүд, эрэгтэй хүүхдүүдэд нөлөөлөх өөрчлөлтүүд бий болсныг энд тэмдэглэх нь зүйтэй. Сүргийн бүтцэд бий болсон өөрчлөлт нь мал маллагааны арга ажиллагааг илүү ихээр шаардах болж, энэ ачааг өрхийн эмэгтэйчүүд, хөвгүүд үүрэх болов. Улмаар эрэгтэй хүүхдүүдийн сургууль завсардалтын түвшин эрс өссөн юм. Эсгий хийх, өрхийн хоол хүнс бэлтгэх гэх мэт өрхийн хэрэгцээнд чиглэсэн ажил эрхэлдэг хөдөөгийн амьдралын хэв маягт шилжсэнээр эмэгтэйчүүдийн ажлын ачаалал хоёр дахин нэмэгдсэн байна. Эмэгтэйчүүдэд үйлдвэрлэлийн эдгээр үүргээс гадна өрхийн болон хүүхэд өсгөх, хүмүүжүүлэх зэрэг үүрэг хариуцлага бас ногддог.

Мал аж ахуйн бүтээмжийг бууруулсан хоёр дахь бүлэг хүчин зүйлс нь мал аж ахуйг дэмжиж, малчдыг зохицуулж байсан 281 нэгдэл 1990 онд тарснаас үүдэлтэй юм. Нэгдлүүд худаг гаргах, гэнэтийн аюулын үед хэрэглэх малын тэжээлийг хадгалах хашаа саравч, өвөлжөө бэлтгэхийн зэрэгцээ, малын өвчний тархалтыг хязгаарлах үүднээс мал эмнэлгийн



үйлчилгээ үзүүлж байв. Түүнчлэн малчдаас бэлтгэсэн түүхий эдийг худалдан авч борлуулдаг байжээ. Нэгдэл бүр өөрийн гэсэн нутаг дэвсгэртэй байсан бөгөөд гэнэтийн аюул тохиолдсон үед ашиглах бэлчээр нутгийг нөөцөлж, дэвсгэр нутгийнхаа хүрээнд бэлчээр ашиглах эрхийг тогтоож өгдөг байлаа. Тухайлбал, аль нэгэн нэгдлийн гишүүн урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр өөр нэгдлийн нутаг дэвсгэрт харьяалагддаг бэлчээрийг ашиглаж чаддаггүй байв.

Улсын бэлтгэлийн систем задарснаар түүний гүйцэтгэж байсан үүргийг наймаачид аажмаар орлох болжээ. Гэхдээ, тэд тооны хувьд харьцангуй цөөн байгаагаас зах зээлд ямар ч өрсөлдөөн байхгүй, дангаар ноёрхох байдал үүсэв. Цаашилбал, малыг хөдөө төхөөрч, ачааны тэргээр зөөвөрлөн зах зээлд хүргэж байна. Мал зах зээлээс алслагдахын хэрээр тээврийн зардал төдийчинээ өсч, малчин өөрийн бүтээгдэхүүнээ хүссэн үнээрээ худалдаалж чадахгүй байна. Нэгдэл байхгүй болсноор малчид төрөл садан, найз нөхдийн холбоогоо улам бэхжүүлэх, малаа өсгөх, аливаа үйлчилгээнд ойртохыг чухалчлан үзэх болжээ.

Нэгдэл тарсны эдийн засгийн үр дагавар байгаль орчинд сөргөөр нөлөөлөх болов. Нэгдлээс үзүүлж байсан нийтийн үйлчилгээнд мал эмнэлэг, усан хангамж багтаж байсан юм. Эдгээрийн аль аль нь үгүй болсноор малчид мал эмнэлгийн үйлчилгээ бүхий хот суурин газар болон ажиллагаатай усны үүсвэрийн ойролцоо төвлөрч эхэлсэн бөгөөд ингэснээр эргэн тойрных нь бэлчээр талхлагдах боллоо. Үүнтэй зэрэгцэн улс орны нутаг дэвсгэрийг хамарсан бэлчээрийн ашиглалт, зохицуулалт суларчээ. Газар нийтийн өмчлөлд байдаг ихэнх орнуудад газрын урт хугацааны тогтвортой байдлыг хангах үүднээс ашиглалтыг нь зохицуулдаг байгууллагууд ажилладаг. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн хүчин зүйл болох малын бэлчээр манайд ямарваа нэгэн зохицуулалтгүйгээр нийтэд нээлттэй байгаагаас “нийтийн өмч байхын уршиг”-ийг амсаж, хамтын эзэмшлийн бэлчээр нутаг доройтож байна. Социализмын үеийн нэгдлүүд бий болохоос өмнө малчид нутаг бэлчээрээ албан бус байдлаар зохицуулж байжээ. Зарим газар энэ хэлбэр сэргэж байгаа боловч хамрах хүрээ багатай, сул дорой хэвээр байна.

Хүснэгт 3.3 1977-2002 оны зуданд нэрвэгдсэн малын тоо толгой (мянгаар)

1977	2036,4
1983-1984	3042,0
1993	1641,8
2000-2002	11167,7

Эх сурвалж: Мал тооллого, Монгол улсын Статистик эмхтгэл, 2002, УСГ.



1999-2000 онд тохиолдсон зуд мал аж ахуйн бүтээмжид нөлөөлсөн сүүлийн том цохилтыг өгсөн бөгөөд зөвхөн 2000 онд л гэхэд малын тоо толгой 10.0 орчим хувиар буурчээ. 2000-2002 онд нийтдээ 11.2 сая толгой мал хорогдож, 15000 гаруй малчид малгүй болсон байна. Энэ нь аймаг, сумын төв болон хот руу хөдөөгийн иргэдийн шилжих хөдөлгөөнийг эрчимжүүлсэн байна. Малгүй болсон зарим малчид амьжиргаагаа залгуулахын тулд бусдын малыг маллах болов. 2001-2002 онд малчдын тоо 4.2 хувиар, мал маллаж амьдардаг өрхийн тоо 5.2 хувиар буурсан байхад мөн хугацаанд хотын хүн ам 4.2 хувиар өсчээ. Энэ үйл явдал мал аж ахуйн эрсдлийг тод харуулж байна.

Шигтгээ 3.2.

Зуд

Байгалийн аливаа гамшгийг сөрөн мал маллаж буй хөдөөгийн иргэд амь насаа алдах тохиолдол гарсаар байна. Зөвхөн 1991-2001 онд 300 орчим хүн байгалийн гамшигт амь эрсэджээ. 2003 оны хүний хөгжлийн илтгэлийг бичих хүрээнд хийгдсэн судалгаагаар Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын 40 гаруй өрх, Бүрд сумын 83 өрх, Төв аймгийн Эрдэнэсант сумын 120 өрх, Лүн сумын 76 өрх огт малгүй үлдсэн болохыг тогтоожээ. Эдгээр өрхүүд сумын төв рүү нүүцгээж, өрхийн гишүүд нь эрхэлсэн ажилгүй, хүндхэн нөхцөлд амьдарч байна.

Эх сурвалж: Байгаль орчны байдал, 2002, БОЯ.

Шигтгээ 3.3

Мянгат малчин

1961 оноос хойш 32 жил Баяннуур суманд жолоочоор ажиллаж байгаад 1993 онд тэтгэвэрт гаран малчин болсон. Одоо 900 гаруй бог мал, 100 гаруй бод малтай. Мал маллагаа нь хүн хүч, асар их хөдөлмөр шаардсан ажил, нөгөө талаас мал маллагаанд байгаль цаг агаарын үзүүлэх нөлөө асар их байдаг тул цаашид малынхаа тоог цөөрүүлэн 300-400 орчим болгох бодолтой байна. Боломжийн амьдрахад ийм тооны мал хангалттай юм.

Бидний амьдарч буй газар хүн огт амьдарч болохгүй гэж хэлж бас болохгүй. Бүх юм хүнээс өөрөөс нь л шалтгаалж байна. Мэдээж, зах зээл муу хөгжсөн, малчид малын ашиг шимээ борлуулах боломжоор хомсхон байгаа нь малчдыг хязгаар нутгаас төв суурин газар луу нүүхэд хүргэж байна.

Уг нь байгаль, цаг агаарын байдал тийм ч муу байгаагүй юм. Сүүлийн 4-5 жилийн дотор их гандаж байна. Цаашилбал, малын хулгай ч бас гол хүчин зүйлүүдийн нэгд зүй ёсоор тооцогдож байна.

Төр засгаас үүний эсрэг арга хэмжээ авч, малыг хулгайгаар хил давуулах боломжгүйгээр хилийн хамгаалалтыг сайжруулан, хилийн баганы тоог нэмж, ойр ойрхон байрлуулах болсон боловч мал хулгайлан хил давуулах үзэгдэл арилахгүй байгаа нь магадгүй хилийн ажилтнууд, мөн дотоодын иргэдтэй холбоотой байхыг үгүйсгэхгүй. Малчдын хөдөлмөрийг үнэлэх тал дээр улсаас их бага анхаарч байгаа юм шиг санагддаг. Оны эцэст л нэг удаа тийм тийм малчин оны сайн малчин боллоо хэмээн шалгаруулахаас өөрөөр шагнаж, урамшуулж буй юм алга.

Малчдыг малжуулах талаар авч явуулж буй арга хэмжээ ч алга. Хоршоо, хоршоолол ч их муу хөгжиж байна. Малчид өөрсдөө ч хөдөлмөр хоршин, хамтран ажиллах тал дээр их муу анхаарч байна. Мал, түүхий эдийн үнэ жил ирэх тутам унасаар байна. Жишээ нь, ноолуурын үнэ буурсаар л байна. Малчид байнга бэлэн мөнгөний хомсдолтой, ямарваа нэгэн хязгаарын нэмэгдэл байхгүй байна. Эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлнэ гэхээр суурин газар тэжээдэг малтай болчихно. Гэтэл мал гэдэг амьтан тэгж суурин газар байж, тэжээлгэх үү гэдэг нь бас л асуудал. Багийн даргын үйл ажиллагаа их сайн байх хэрэгтэй байна. Ер нь малчид малчдын эрх ашгийг бүхий л талаар нь хамгаалж чадахуйц, зөв хүнийг олж сонгох тал дээр анхаарах хэрэгтэй юм.

Хөдөөд бага хувьчлал ерөөсөө ямар ч үр дүнгүй явагдсан. Миний хувьд, барьж байсан машинаа л хувьчилж авсан. Хөдөө, орон нутагт банк, санхүүгийн үйл ажиллагааг хөгжүүлэх тал дээр төр, засгаас анхаарах хэрэгтэй юм. Банк ер нь хэр найдвартай бол гэж их эргэлздэг. Гэхдээ би хэдэн төгрөгөө банкинд хадгалуулсан.

Эцэст нь, хөдөлмөрлөж байж л амжилтанд хүрнэ гэдгийг хүн бүр санан, цаг нартай уралдан малтайгаа ажиллаж, хөдөлмөрлөвөл хаана ч амьдарч болж байна шүү гэдгийг хэлбэ.

З.Д. эрэгтэй, нас 65, жолооч мэргэжилтэй, мянгат малчин, эхнэр, гурван хүүхдийн хамт амьдардаг.

Албан бус сектор

Нийслэл хотын ажил эрхлэлтэнд томоохон хувийг эзэлдэг албан бус сектор эдийн засаг, үйлдвэрлэл эрхлэлтийн чухал эх үүсвэрт тооцогддог. Албан бус секторын талаар найдвартай тоо баримт байхгүй байна. Гэвч төрийн байгууллага болон аж үйлдвэрийн салбараас ажилгүйдэлд өртсөн олон мянган хүмүүсээс гадна хөдөө орон нутгаас шилжин ирэгсдийг Улаанбаатар дангаараа шингээжээ. Энэхүү хоёрдмол шинжтэй эдийн засаг гуйлгачид, биеэ үнэлэгчид, жижиг мухлагийн эзэд, жижиглэнгийн худалдаачид, таксины жолооч, жижиг үйлдвэрлэгчид, валютын ченжүүд, барьцаалан эзэлдүүлэх газар (ломбард) болон зөврийн телефон үйлчилгээ зэрэг олон төрлийн үйлчилгээг багтаадаг. Үүний нөлөөгөөр бүтээгдэхүүн, үйлчилгээний олон нэр төрөл бий болж, амьжиргааны өртөг хотод буурсан зэрэг эерэг үзэгдэл илэрч байна. Албан бус сектор зарим тохиолдолд албан сектортой холилдон, өөр хооронд нь ялган зааглахад түвэгтэй үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудыг өөртөө агуулж байдаг билээ.

Хүснэгт 3.4 Албан бус секторт ажиллагсдын нийт ажил эрхлэлт, үйлдвэрлэлд эзлэх хувийн жин, хот, хөдөөгөөр, 1999

	Үйлдвэрлэл		Ажиллагсд	
	Тоо	Нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жин	Тоо	Нийт ажиллагсдад эзлэх хувийн жин
Бүгд	469209	100.0	244482	100.0
Албан сектор	351954	75.0	184200	75.3
Албан бус сектор	117255	25.0	60282	24.7
Улаанбаатар	94049	80.2	47037	78.0
Аймагууд	23206	19.8	13245	22.0

Эх сурвалж: Кийт Гриффин, Монгол улсад ядуурлыг бууруулах нь, 2003.

Монгол улс, хуучин ЗХУ-ын харьяанд байсан Бүгд Найрамдах улсуудын албан бус сектор нь боловсрол өндөр, ур чадвар сайтай олон тооны хүмүүсийг багтааж байгаагаараа бусад хөгжиж буй орнуудаас ялгаатай юм. Манайд орлого буурч байгаа, төрөөс иргэдийн эдийн засгийн

аюулгүй байдлыг хангах чадавхи доройтсон зэргийн улмаас амьжиргаагаа залгуулахын тулд хүмүүс албан бус сектор руу орж байна. 1997 онд Дэлхийн банк (ДБ)-наас Улаанбаатар хотын албан бус секторын талаар явуулсан судалгааны тайлан илтгэлд тооцноор албан бус сектор нийслэлийн өрхүүдийн 15.0 хувийг ядуурлын шугамнаас дээгүүр амьжиргаатай болгосон байна. АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг 1999 онд Улаанбаатар, Орхон, Увс, Завхан, Архангай, Хэнтий, Дорноговь аймгуудад албан бус секторын талаар судалгаа хийжээ. Энэхүү судалгаанд хамрагдсан хотын албан бус секторын үйл ажиллагаа мөнгөн дүнгээрээ 117.3 тэрбум төгрөг (114.7 сая ам.доллар) болсон нь 1999 оны ДНБ-ий 13.0 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн гэж дүгнэжээ.



Албан бус секторыг ихэнх тохиолдолд төдийлэн ойшоодоггүй. Гэтэл албан бус сектор нь шинээр аж ахуй эрхлэгчид хотын зах зээлд үйл ажиллагаа явуулахад суралцах, алдаа оноон дээрээ тулгуурлан микро аж ахуйгаа хөгжүүлэх орчин, бизнес инкубатор болдог юм. Иймд ажилгүйдлийг бууруулах микро түвшний үй олон хариу үйлдэл нь эдийн засгийн өсөлтийг хурдасгах боломжийг бий болгож болох юм. Энэхүү хөгжлийн стратегийг Засгийн газрын бодлого, хөрөнгө санхүүгээр дэмжих хэрэгтэй. Ингэснээр ядуучууд хөгжлийн үйл явцад идэвхтэй оролцох боломжтой болно. Хүн амын гуравны нэг нь ядуу, тэдгээрийн олонхи нь албан бус секторт санаачилгатай, авъяас самбаатай ажиллаж байгааг харгалзан үзвэл ядуурлыг бууруулахад чиглэсэн Засгийн газрын бодлого ач холбогдлоо өгч чадна.

Ерөнхийдөө албан бус сектор гэдэгт бүртгэлд хамрагдаагүй, аливаа зохицуулалт болон татвараас гадуур байдаг учраас албан статистикт хамрагдаагүй, хэмжээгээр бага, хөдөлмөр шингээлт ихтэй, хувиараа аж ахуй эрхлэх бизнесийг хамруулж ойлгодог. Энэ секторт ажиллахад аж ахуйн нэгжүүдэд гарааны зардал бага шаардагддаг, өндөр орлогын татвар төлдөггүй учраас саад бэрхшээл бага тохиолддог. Монгол улс албан бус үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох арга замыг эрэлхийлж байна. Албан бус секторт ажиллагсад тухайн нутаг дэвсгэрийнхээ эрх бүхий байгууллагад бүртгүүлж, орлогоос хамаарсан

татварын оронд тогтмол татвар төлдөг. Сард төлж буй энэхүү татварын хэмжээ нь албан секторынхтой харьцуулахад бага юм. Албан бус сектор дахь аж ахуйн нэгжүүдийн дийлэнхи нь дээрх шаардлагыг мөрдөх ёстой. Гэвч албан сектор дахь татварын



дарамт сүүлийн жилүүдэд нэмэгдсэн нь албан бус секторын өсөлтийг эрчимжүүлж байна гэж үздэг. Тухайлбал, 1999 онд ДНБ-ий 20.0 хувьтай тэнцүү байсан татварын дарамт 2000 онд 26.0 хувь, 2001 онд 29.0 хувь болжээ.

Албан бус секторт ажиллагсад гол төлөв 20-40 насныхан байгаа бөгөөд 40-60 насныхан дараагийн томоохон бүлгийг бүрдүүлж байна. Албан бус секторт эмэгтэйчүүд тодорхой байр суурь эзэлж байгаа бөгөөд ажиллах хүчний 54.0 хувийг эзэлж байна. Тэд бөөний болон жижиглэнгийн худалдаа, хувийн үйлчилгээ, хоол хийж зарах, аялал жуулчлал болон хүнс бэлтгэх зэрэг зохион байгуулалт муутай зах зээлд давамгайлан ажиллаж байна.

Үнэн хэрэгтээ өөр төрлийн бизнес эрхэлдэг атлаа Монголд эмэгтэйчүүд өөрсдийгөө ихэвчлэн гэрийн ажилтай буюу ажилгүй хэмээн тооцдог учраас бизнес дэх оролцоог нь тодорхойлоход ихээхэн бэрхшээлтэй. Эрэгтэйчүүд гарааны хөрөнгө оруулалт ихээхэн шаардагддаг тээврийн үйлчилгээнд гол төлөв давамгайлж байна. Албан бус сектор янз бүрийн насны ажиллагсдыг багтаадаг бөгөөд жижиг бизнес эрхлэхэд бизнес эрхлэгчдээс нэмэлт ажиллах хүчнийг шаарддаггүй. 2001 онд НҮБХХ-ийн санхүүжилтээр ОУХБ-аас явуулсан Монголын албан бус секторын талаарх судалгаагаар албан бус сектор дэх хүүхдийн хөдөлмөр нэмэгдсэн тоо баримт илэрсэн байна. Тэд ямар ч хамгаалалтгүй, маш бага төлбөртэй төрөл бүрийн ажил эрхэлж байгаа бөгөөд үүнд, зах дээр болон гудамжинд хүнс, сонин зарж борлуулах, мод, цаас, архи ундааны шил, лааз цуглуулан зарах, гутал тослох, машин угаах зэрэг үйл ажиллагаа багтаж байна.

Шигтгээ 3.4

Албан бус сектор

Нөхөр маань техник мэргэжлийн сургууль, би өөрөө Хөнгөн, хүнсний техникум төгссөн. Бид хоёр гэрлээд 10 гаруй жил болж байна. Хоёул тогтсон ажилгүй. Нөхөр маань зундаа өвс хадланд яваад, өвөл уурхайд ажилладаг. Өглөө 8-9 цагийн үед ажилдаа яваад орой 22 цагийн үед л ирдэг. Өдрийнх нь дундаж орлого нүүрсний ханш сайн үед 7000-8000 төгрөг байдаг. Би гэрээрээ юм оёж, хагас, бүтэн сайнд зах дээр зардаг.

Нас гуч гарчихаар үйлдвэрт ажиллах хүндрэлтэй. Би хувийн аж ахуйтай болохыг их мөрөөддөг. Одоо газар аваад ногоо тарьдаг ч юм уу эсвэл ямар нэгэн байдлаар аж ахуй эрхлэх бодолтой байна.

С. эмэгтэй, тусгай дунд боловсролтой, ам бүл 5, Улаанбаатар, Налайх дүүрэг.

Шилжих хөдөлгөөн, хотжилт

Социализмын үед Засгийн газар хөдөө орон нутагт хөрөнгө оруулалт хийх, хөдөөнөөс хот руу чиглэсэн хөдөлгөөнийг хатуу хяналтанд байлгах замаар хот, хөдөөгийн амьдралын нөхцөл, боломжийг тэгшитгэх оролдлого хийж байв. Монголын эдийн засагт гүн гүнзгий бүтцийн өөрчлөлт явагдан, ядуурал газар авч, нийгмийн хамгааллын тогтолцоо бүрдээгүй байсан энэ үед хүмүүс амьжиргаагаа залгуулах арай илүү боломж, арга хэрэгслийг хайн, шилжих хөдөлгөөнд оролцож болжээ. Шинэ Үндсэн хууль иргэдэд чөлөөтэй шилжин суурьших боломж олгосон юм. Хүмүүс хот суурин газраас хөдөө, орон нутаг руу нүүн суурьшдаг байсан бол 1990 оны сүүлээр хөдөө орон нутгаас хот, суурин газрыг зорин шилжих боллоо. 2000 оны байдлаар нийт хүн амын 21.0 хувь нь шилжих хөдөлгөөнд оролцсон байв. Өөрчлөлт, шинэчлэлт

явагдсан сүүлийн арван жилийн хугацаанд янз бүрийн ашиг сонирхлын үүднээс шилжих хөдөлгөөний эсрэг урсгал бий болсон нь ажиглагдаж байна. Шилжих хөдөлгөөний урсгал ийнхүү өөрчлөгдөхөд улс орны хөгжлийн дорой байдал мөн нөлөөлсөн юм. Тухайлбал, ДНБ-д аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувь буурсан байхад хөдөө аж ахуйнх нэмэгджээ. Хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний тоо өссөн ч нэг хүнд ногдох хөдөлмөрийн бүтээмж буурсан байна.

Шилжилтийн жилүүдэд “цочроох эмчилгээ”-ний аргыг хэрэглэсний улмаас аж үйлдвэр, барилгын салбар, төрийн удирдлага, засаг захиргааны байгууллагуудын мянга мянган ажилчид ажилгүй болсон юм. Тэдгээрийн багагүй хэсэг нь мал хувьчлалаас хувь

хүртэхээр хот суурин газраас нүүсэн бөгөөд 1990-1993 оны хооронд малчдын тоо 136.0 хувиар өсчээ. Мал аж ахуй давамгайлсан хөдөөгийн эдийн засаг шинэ ажиллах хүчнийг шингээх чадвартай

байсан ч мал аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж буурсан юм. Хотоос хөдөө рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн нь хотын иргэд төрсөн нутаг оронтойгоо хэлхээ холбоо сайтай байсныг гэрчилнэ. Самт, аймгийн төвүүдэд үйлдвэрлэл зогсохын хамт, аймгуудын хооронд болон хотоос хөдөө рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн явагджээ. Найман аймгийн төвийн хүн амын тоо шилжилтийн үед үлэмж хэмжээгээр буурчээ. Тухайлбал, Алтайд 3.6 хувь буурсан нь хамгийн бага, Мандалговьд 35.5 хувь буурсан нь хамгийн их хэмжээтэй байв. Харин бусад аймгуудад аймгийн төвийнх нь хүн амын тоо өсчээ. 1999-2000 онд сая, сая толгой мал хорогдсон зудад нэрвэгдсэн бөгөөд хотоос хөдөөг чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал эсрэг байдалтай болж 1998-1999 онд нийт хүн амын 50.0 хувийг эзэлж байсан хөдөөгийн хүн ам 41.0 хувь болтлоо буурчээ.

Шигтгээ 3.5

Шилжих хөдөлгөөн

Ажил олдохгүй байсан учраас Шивээ-Овоогоос 3 жилийн өмнө хотод шилжиж ирсэн. Хөдөө байхад өөрийн гэсэн орон гэргүй байсан ба идэх хоолгүй, хоосон хонох үе тохиолдож байв. Харин хотод ирснээр орон гэртэй, идэх хоол, өмсөх хувцастай болж амьдрал дээшиллээ. Барилгын мэргэжилтэй боловч байнгын ажил олж хийж чадахгүй л байна. Түр ажил эрхлэх замаар сард 30.0-40.0 мянган төгрөгний орлого олдог. Төв аймгийн иргэний харьяалалтай, хотод бүртгэлгүй тул шинэ төрсөн хүүхдээ эмнэлгийн хяналтад хамруулж чадахгүй байна. Бас цахилгаан гэрэлтэй болж чадахгүй байгаа.

Лаа барьж гэрэл залгуулж байна даа. Сонин хэвлэл захиалдаггүй, зурагт, цахилгаан байхгүй тул айлд орж зурагт үзэх замаар мэдээлэл олж авдаг. Усан хангамж муу, зөөврийн ус хэрэглэдэг ч тэр нь алдаг оног л ирэх юм. Одоо газартай болох санаатай. Амьдрал сайжирна гэдэгт итгэдэг.

3.Т. өрхийн тэргүүн, эрэгтэй, ам бүл дөрөв, эхнэр болон бага насны 2 хүүхдийн хамт амьдардаг.

Үүний зэрэгцээ хот суурин газрын иргэд мал аж ахуйгаас хоол хүнсээ залгуулна гэж найдаж байсан тэр үед хөдөөгийн иргэд ажил хайн, хот суурин газарт төвлөрсөн үйлчилгээ бараадан шилжих болжээ. Тухайн бүсийг нутгийн бусад хэсэгтэй холбосон төмөр зам, хатуу хучилттай замын сүлжээ ч шилжих хөдөлгөөнд мөн нөлөөлсөн юм. Малчид, хөдөө аж ахуйд ажиллагсад нийгмийн үйлчилгээ үзүүлж байсан улсын байгууллагуудыг татан буулгасны улмаас хөдөө орон нутагт ажилгүйдэл нэмэгдсэн.

Өнөөдөр нийслэлийн хүн амын гуравны нэгийг шилжин ирэгсэд бүрдүүлж байгаа нь хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний далайцыг харуулж байна. Зөвхөн 1999 онд л гэхэд хотын хүн ам 5.0 хувиар өссөн байна. Хөдөөгөөс шилжин ирэгсэд хотын захын дүүргүүдэд ил задгай газар гэрээ барьж, хотын захын хаяаг тэлж, борчуудын эгнээг өргөжүүлэх болов.

Хөдөө орон нутгаас хот суурин газрыг чиглэсэн шилжих хөдөлгөөн зонхилж буй өнөө үед хүмүүс зөвхөн том хотуудад бус аймаг, сумын төвүүдээр ажил хайн хөдөө орон нутгийг орхин явах боллоо.

Хөдөөгөөс хот уруу чиглэсэн шилжих хөдөлгөөнөөр хөдөө нутаг хөдөлмөрч, авьяаслаг хүмүүсээ алдахад хүрч байна. Монгол улс улам бүр хотжих тусам хүн ам зүйн хүчин

зүйлсээс шалтгаалан нийслэл хот болон бусад хоёр том хотод хангамж, үйлчилгээ төвлөрсөөр байна. Шилжих хөдөлгөөний тасралтгүй урсгалын улмаас Улаанбаатар хот байнга өргөжин тэлж, 1990-2000 оны хооронд нийслэл хотын хүн ам 27.0 гаруй хувиар өсчээ.

Шилжих хөдөлгөөн нэмэгдсээр байгаа нь хүн ам харьцангуй хөдөлгөөнтэй байгааг тод томруун харуулж байна. Эрт дээр үеэс Монгол орон нүүдэлчдийн өлгий нутаг байсан бөгөөд өнөөдөр хүн амын бараг тэн хагас нь гэрт амьдарсаар л байна. Аймгийн төвүүд бүгд жижгэвтэр тул тэдгээрийн нэгээс нөгөө рүү нүүх нь өрхийн амьдралын хэв маягийг мэдэгдэхүйц өөрчилдөггүй. Нүүдэл нь ямагт суурьшилд хүргээд байдаггүй. Шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд давамгайлж байна. Ажил хайн гэр орноо орхиж явсан гэр бүлийн гишүүдийн гэртээ ирүүлж буй мөнгө хот, хөдөөгийн ялгааг багасгах чухал гүүр болж байна.

Хот, хөдөөгийн хоорондох шилжих хөдөлгөөнөөс гадна хил хязгаар, алслагдмал нутгаас төв рүү чиглэсэн, хот суурин газраас гадаад улс орныг зорин шилжих боллоо.

Улс орноо орхин одсон монголчуудын талаар дорвитой судалгаа хийгдээгүй байна. Тэдний зарим нь хилийн чанад дахь Орос, Казак зэрэг уугуул үндэстэнтэйгээ нэгдэж нийлэх зорилгоор шилжицгээсэн юм. 1989 онд хүн амын 2.8 хувийг гадаадаас гаралтай үндэстнүүд бүрдүүлж байсан бол 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор энэ үзүүлэлт 0.3 хувь болж буурчээ. Шилжин явагсдын дийлэнх нь хуучны ЗХУ-ын иргэд байв.

Орлогын хомсдолд үзүүлсэн хариу үйлдлүүдийн нэг нь Өмнөд Солонгос, Казакстан, БНЧех Улс болон бусад улсууд руу гарч буй цагаачлал гарцаагүй мөн. Үүний зэрэгцээ казак үндэстний цөөнхийн тоо 1989-2000 онд 20000-аар буурчээ. Энэхүү бууралтад нэлээд тооны Казак иргэд Казакстан руу цагаачилсан явдал нөлөөлсөн юм. Эдүгээ манай улсын Казак үндэстнүүдийн дийлэнхи буюу 78.4 хувь нь баруун бүс болон Баян-Өлгий аймагт амьдарч байна.

Шилжих хөдөлгөөн нь эдийн засгийн хөгжлийн ердийн үзэгдэл бөгөөд бүс хоорондын ялгаатай байдлыг багасгах чухал арга хэрэгсэл билээ. Гэвч шилжин очсон газарт нь ажил эрхлэлт болон орлогын боломж байхгүй бол энэ нь хот, хөдөөгийн аль алиных нь ядуурлын түвшинг мэдэгдэхүйц нэмэгдүүлэхэд хүргэнэ. Шилжих хөдөлгөөний урсгалыг зохицуулах, хот, хөдөөд таатай боломжийг бүрдүүлэхэд бэрхшээл тулгараад байна.

Байгаль орчны нөлөө

Эдийн засгийн шилжилтийн зэрэгцээ иргэд байгаль орчныг ашиглах шинэ шинэ боломжуудыг эрэлхийлэх боллоо. Самар хурааж, түлшний мод бэлтгэн борлуулах зэрэг жижиг цар хүрээтэй арилжааны үйл ажиллагаа нь хот, хөдөөгийн иргэдийн аль алинд нь нэмэлт орлого олох, эрүүл хоол, хүнс, түлшээр хангагдах боломжийг олгож байна. Гэвч байгаль орчин нь хязгаарлагдмал нөөцтэй бөгөөд бэлчээрийн доройтол, агаарын бохирдолт, ойн нөөцийн хомсдол гэсэн гурван хүндрэлтэй асуудалтай тулгараад байна. Хөдөө аж ахуйн салбарт зохицуулалт алдагдаж, нэгдлүүдийг тараасан нь бэлчээрийн талбайг зүй зохистой ашиглах явдлыг үгүй хийсэн бөгөөд энэ нь цөлжилт үүсэх хандлагыг бий болгов. Хэт хурдацтай явагдсан шилжих хөдөлгөөний улмаас хотын гэр хорооллоос ялгарах утаа, гар дамжин хуучирсан, үр ашиг багатай байдаг машинуудаас ялгарах утаатай нийлэн хотын агаарыг бохирдуулах боллоо. Түүнчлэн, ядуурал нь ойн нөөц хомсдоход хүргэж байна.

Бодлогын хариу үйлдэл

Монгол улсын Засгийн газраас өсөн нэмэгдэж буй бүс нутгийн ялгаатай байдал болон ядуурлыг

бууруулах зорилгоор бодлогын чанартай хэд хэдэн арга хэмжээг эхлүүлээд байна.

Үр ашигтай шүүх эрх мэдлийн тогтолцоо, хүний эрх, хууль цаазат эрх зүйт ёс, иргэний нийгэм болон сайн засаглалын хөтөлбөрийг хөхүүлэн дэмжих чиглэлд төр идэвхитэй үүрэг гүйцэтгэх боллоо. Монгол улс Үндсэн хуулиараа нутгийн өөрөө удирдах ёсыг баталгаажуулсан бөгөөд “Төв, орон нутгийн засаг захиргаа орон нутгийн өөрөө удирдах ёс болон төрийн удирдлагыг хослуулсны үндсэн дээр хөгжинө.” гэж заажээ.

Засгийн газар “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал” хөтөлбөр болон Монгол улсын Засгийн газрын 2000–2004 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөөрөө сайн засаглалын зарчмуудыг хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлсэн юм. Тодруулбал, Засгийн газрын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх; Засгийн газар, ажил олгогчдын холбоо болон үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, гэрээний үндсэн дээр Засгийн газрын зарим чиг үүргийг гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд ТББ-ыг татан оролцуулах; Үндэсний хүний эрхийн хороо байгуулах замаар хууль эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх; Засгийн газрын байгууллагуудын ил тод байдлыг сайжруулах; авилгалтай тэмцэх зэрэг арга хэмжээг тусгасан байна.

Шигтгээ 3.6

Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн зорилтууд

- Шүүх эрх мэдлийн хараат бус байдал, чөлөөт хэвлэл мэдээллийг хөхүүлэн дэмжих замаар иргэдийн үндсэн эрх, ардчилалын суурь зарчмуудыг баталгаажуулсан ёс зүй бүхий ардчилсан иргэний нийгмийг хөгжүүлэх;
- Эрх мэдлийн хууль эрх зүйн үндэс, шүүх эрх мэдлийн бүтцийг сайжруулж, шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хангахад чиглэгдсэн шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлж, нэр хүндийг нь сайжруулах иж бүрэн арга хэмжээ авах;
- Эрх болон хуулийн өмнө хүлээх хариуцлагын тунхаглал бүхий хүний эрхийн эрх тэгш байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх;
- Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хууль тогтоомжийг сайжруулж, хариуцлагын механизмыг бүрдүүлснээр төрийн бодлогыг иргэдэд ойртуулах;
- Хууль ёсны үр ашиг бүхий тогтолцоог бүрдүүлэх;
- Иргэдийн хууль эрх зүйн боловсролыг сайжруулах;

- Төрийн үйлчилгээний хариуцлагын механизмыг сайжруулж, авилгал, хээл хахууль болон эрүүгийн гэмт хэргийн эсрэг шийдвэртэй тэмцэх;
- Олон нийттэй харилцах харилцааны удирдлагыг сайжруулж, төрийн байгууллагуудын ил тод байдлыг ханган, түншлэлийн схемийн хүрээнд ТББ-тай сайн харилцаа тогтооход дээд зэргийн дэмжлэг үзүүлэх;

Эх сурвалж: Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр, 2001, Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ.

Ядуурлыг бууруулах нь Засгийн газрын хөгжлийн стратегийн цөм юм. Энэ нь Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан (ОУВС), Азийн Хөгжлийн Банк (АХБ), НҮБ зэрэг олон улсын байгууллагууд, Герман, Япон, Нидерланд, Швед, Их Британ зэрэг улсуудын хоёр талт хамтын ажиллагааны байгууллагуудтай хийж буй үйл ажиллагаануудын анхдагч зорилго юм. “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги” хэмээх Ядуурлыг Бууруулах Стратегийн Баримт Бичиг (ЯБСББ)-ийн бүрэн эхийг Монгол улсын Их хурлаас 2003 оны зун баталсан билээ. Уг баримт бичгийг одоогоос зургаан жилийн өмнө буюу 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тулгуурлан боловсруулсан бөгөөд энэ баримт бичигт Мянганы хөгжлийн зорилтуудтай уялдуулан 2005 он гэхэд нэн ядуучуудын тоог 25.0 хувиар, 2015 он гэхэд 50.0 хувиар бууруулахаар заасан байна. Эдгээр зорилтуудыг биелүүлэхийн тулд ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 5.5-аас 6.0 хувьд хүргэх стратегийг ЯБСББ-т тусгажээ. ЯБСББ-г а) макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах; б) экспортын чиглэлийн аж үйлдвэрийг хөхүүлэн дэмжих зэргээр хувийн хэвшил давамгайлсан өсөлтийг бий болгох; в) голчлон ядуучуудад чиглэсэн үйлчилгээг боловсронгуй болгох замаар орлогын тэгш хуваарилалтыг бий болгох; эмзэг бүлгийнхний амьжиргааг баталгаажуулах нийгмийн хамгааллын сүлжээг бүрдүүлэх зэрэг асуудлууд тусгагдсан байна. ЯБСББ нь Засгийн газраас өмч хувьчлал болон хувийн хэвшлийн өсөлтийг хангах талаар тууштай баримталж буй бодлогод тулгуурласан өсөлтийг дахин хуваарилахтай хослуулах стратегид суурилсан юм.

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Цагаан хувьсгал”, “Ногоон хувьсгал” хөтөлбөрүүд хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хангамжийг сайжруулан, хөдөөгийн малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна. Эдгээр хөтөлбөрүүдийн хүрээнд сүүн бүтээгдэхүүний боловсруулалтыг сайжруулах талаар нэлээд арга хэмжээг авч хэрэгжүүлэв. “Ногоон хувьсгал” хөтөлбөрийн үр дүнд газар тариалангийн үйлдвэрлэл



нэлээд өссөн. Энэ нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн уналтыг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Өөрөөр хэлбэл, уг салбарт харьцангуй тогтворжих хандлага бий болжээ. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн 2003 оны тайланд “Цагаан хувьсгал хөтөлбөр”-т нийт 21 аймаг, 300 сумын 198400 өрх хамрагдсан бол “Ногоон хувьсгал” хөтөлбөрт 2400 аж ахуй нэгж, 121000 өрх хамрагдсан болохыг тэмдэглэжээ. Энэ нь эдгээр хөтөлбөрүүд хөдөөгийн ядуурлыг бууруулж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлсөн болохыг харуулж байна.

Засгийн газраас ядуурлыг бууруулах хөтөлбөр, хүнсний бүтээгдэхүүний үнэ өсгөх, боловсролын салбарын шинэчлэлт, Засгийн газрын төвлөрлийг сааруулах, нийгмийн үйлчилгээг сайжруулах зэрэг эдийн засаг, улс төрийн өөрчлөлтүүдээр хариу үйлдэл хийсэн.

болон эхийн эндэгдэл буурч, халдварт өвчнөөр өвчлөх тохиолдлын тоо багасч байна. Түүнчлэн, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ сайжирч байна. Сумын эрүүл мэндийн төвүүдийн хөгжлийн хөтөлбөр нь орон нутаг дахь эмнэлгийн үйлчилгээг сайжруулах анхдагч арга хэрэгсэл болж байна.

Иргэдэд боловсрол эзэмших сонголт хийх боломж бүрдүүлэх, орчин үеийн мэдлэг олгох, орчин нөхцлийг сайжруулах замаар хүний нөөцийн

Эрүүл мэндийн салбарын 18 хөтөлбөрөөс тавыг нь нийтийн эрүүл мэндийн чиглэлээр явуулах иж бүрэн бодлогын хүрээнд 2003 оноос хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр хөтөлбөрийн үр дүнд хөдөөд тав хүртэл настай хүүхдийн

чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн төрийн бодлогыг Засгийн газраас авч хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, “Бага, дунд боловсролын тухай” хууль зэрэг багц хуулиудыг батлан гаргаснаар зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургалтын агуулга болон технологийг шинэчлэхэд чиглэсэн өөрчлөлтүүдийг боловсролын салбарт авч хэрэгжүүллээ. Төрийн өмчийн зарим их дээд сургууль, коллежуудыг бүтцийн өөрчлөлтөнд хамруулсан бөгөөд эдгээр байгууллагуудтай удирдлагын гэрээ, хэлцлүүдийг хийх бэлтгэл ажил явагдаж байна.

Монгол улсын Засгийн газар төвлөрлийг сааруулж, орон нутгийн засаг захиргааг бэхжүүлэх арга хэмжээг авч, удирдлагын тогтолцоонд өөрчлөлт хийв. 1992-1996 оны хооронд Засгийн газар “Удирдлагын хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд төвлөрлийг сааруулж, орон нутгийн өөрөө удирдах ёсыг төлөвшүүлэх асуудал уг хөтөлбөрт тусгагджээ. Энэ нь төвлөрлийг сааруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, нутгийн өөрөө удирдах ёсыг дэмжих хууль эрх зүйн орчинг бүрдүүлэн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын санхүүгийн эрх мэдлийг өргөжүүлэх ажлын зөвхөн эхлэл юм.

Монгол улсын Их хурал 2001 оны 6 сард “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталсан¹⁵. Энэхүү үзэл баримтлалын гол зорилго нь байгаль орчин, хөдөө аж ахуй, газар болон хүний нөөцийг зохистой ашиглан, эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийг хурдасгах замаар хүн амын хэт төвлөрөлтийг сааруулж, хот, хөдөөгийн ялгаатай байдлыг багасгах таатай нөхцлийг бүрдүүлэх явдал юм. Бүсчилсэн хөгжлийн энэхүү үзэл баримтлалын дагуу тодорхой бүс нутгийн бүх иргэд сурч, боловсрох, мэдээллийг хүртэх, нийгмийн амьдрал идэвхитэй оролцох тэгш боломжоор хангагдах болно. Мөн боловсрол, эрүүл мэнд, соёл, мэдээлэл болон нийгмийн үйлчилгээнээс хүртэх ижил боломжоор хангагдах юм.

2001 онд Монгол улсын Их хурал улс орны баруун хэсгийг зүүн хэсэгтэй, хойд хэсгийг урд хэсэгтэй холбох хэвтээ болон босоо чиглэлийн таван замыг тавих “Мянганы зам” төслийг баталсан билээ. Эдгээр зам нь зөвхөн бүс нутгийн бус Монгол улсын гадаад худалдаа, хамтын ажиллагааг өргөтгөн, Евро-Азийн нэгдсэн сүлжээнд холбогдсоноор далайтай болон Транс-Азийн хурдны замтай холбогдох гарцыг нээж өгөх юм. Уг төслийн хүрээнд Улаанбаатар-Багануур чиглэлийн замыг хатуу хучилттай болгох, Улаанбаатар-Сүхбаатар-Алтанбулагийн чиглэлийн 400 км замыг сайжруулах, Налайх-Чойрын чиглэлд 200 км, Дархан-Эрдэнэтийн чиглэлд 184 км хатуу хучилттай зам

¹⁵ Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги, 2003, Монгол улсын Засгийн газар.

тавих, баруун чиглэлийн авто замыг сайжруулах, Улаанбаатар-Арвайхээрийн чиглэлийн 420 км замыг шинэчлэхээр төлөвлөөд байна¹⁶. Мөн хугацаанд хандивлагчдын санхүүжилт өссөн бөгөөд 2000-2002 онд зам барих ажил нэлээд өргөжлөө. Засгийн газар болон түүний харьяа байгууллагуудаас улс орны хөгжилд үндсэн үүрэг гүйцэтгэх хүний чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн нэлээд олон арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Цаашилбал, Засгийн газар улс орны өмнө байгаль орчны бэрхшээлтэй асуудлууд тулгарч байгааг хүлээн зөвшөөрсөн бөгөөд Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл байгаль орчны бодлогын зорилгууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлжээ. Улсын Их хурлаас байгаль орчны тогтвортой байдал, нөөцийн талаар 20 гаруй хууль баталжээ. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах олон улсын нэлээд олон хууль тогтоомжид нэгдэж орсон. Гэсэн хэдий ч дээрх зорилтуудад хүрэхийн тулд сийрэг хүн ам, өргөн уудам газар нутгаас үүдэлтэй томоохон бэрхшээлүүдтэй учирна гэдгээ эрх баригчид хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Дүгнэлт

Шилжилтийн эхний арван жилийн эцэст Монголын хүн ам олон талаар өөрчлөгдөж, нийгэм, эдийн засгийн янз бүрийн бүлгүүд үүсч, иргэд эдийн засаг, улс төрийн өөр тогтолцоонд дасан зохицож амьдарч эхэлсэн байна.

Хүмүүс ядуурал, ажилгүйдэлтэй анх удаа тулгарсан хэдий ч эдгээр үзэгдэлд идэвхигүй байр сууринаас хандсангүй. 1990-ээд оны эхээр хотын иргэд мал хувьчлалыг дагаад мал аж ахуй эрхлэхээр хөдөөг зорьж байсан бол хотжихын хэрээр хүмүүс амьжиргаа залгуулах стратеги болох хоёрдмол шинж бүхий эдийн засаг (албан бус сектор)-ыг бий болгосон юм. Тогтвортой амьжиргааг нь хангана хэмээн хүмүүсийн итгэж найдаж байсан мал аж ахуйн салбарт эхлээд бүтээмж нь буурч, дараа нь хэдэн сая мал зуд турханд үхэж, үрэгдэж байх үед олон мянган хүн шинэ боломжийг эрэлхийлэн шилжих хөдөлгөөнд оролцох болов. Хариу үйлдлийн нэг хэсэг нь хүн ам зүйн хүчин зүйл, тухайлбал, төрөлтийн түвшний бууралттай ч бас холбоотой.

Засгийн газар нэгэнт буй болсон тэгш бус байдал, доройтлыг арилгах зорилгоор ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Мөн хүний хөгжлийг хурдасгахын тулд төвлөрлийг сааруулах, иргэний нийгмийг байгуулах, хууль цаазат төрт ёсыг тогтоох зэрэг шинэчлэлүүдийг хийж байна. Эдгээр санаачлагууд нь эрх тэгш байдлыг дэмжиж, эмзэг бүлгийн иргэдийг илүү бүтээлч, өөртөө итгэлтэй болоход нь туслахуйц хөгжлийн стратеги алхам боллоо. Дээр дурдсанаас үзвэл хүмүүс Засгийн газраас түрүүлж хариу үйлдэл хийж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Иймд чиглэлээ зөв тодорхойлсон, хүний хөгжлийг хурдасгахуйц илүү үр ашигтай стратеги, бодлого шаардагдаж байна.

¹⁶ Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратеги, 2003, Монгол улсын Засгийн газар.





БҮЛЭГ 4

УРАГШЛАХ ЗАМД



Урагшлах замд

Сэтгэл сэдхийм хэмжээнд хүрсэн орон зайн тэгш бус байдал иргэдийн амьдралын баталгааг алдагдахад хүргэх боллоо. Шилжилтийн хүсээгүй үр дагавар болох энэ асуудлыг төр анхаарлынхаа төвд байлгаж, шийдвэрлэх нь зүйтэй юм. Даяаршлын үйл явц хурдацтай явагдаж, улс орон дэлхийн зах зээлтэй ойртон нягтрах үйл явц эрчимтэй өрнөж буй өнөө үед асуудлыг цаг алдалгүй нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна. Монгол улс ДХБ-д гишүүнээр элссэнээр бий болж буй асар их боломжийг орон зайн ялгаатай байдлаас үүссэн хөгжлийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэхэд биш, харин багасгахад зохистой ашиглах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, арилжаа, худалдааны үр ашгийг өргөн уудам газар нутаг, хүн амд жигд хүртээхэд чиглэсэн бодлогыг төрөөс боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлыг бууруулахын ач холбогдол дараах учир шалтгаануудаар тайлбарлагдана. Үүнд, тэгш байдлын үүднээс авч үзвэл, хот, хөдөөгийн хоорондын болон оршин сууж буй иргэдийн амьжиргааны ялгаатай байдал нь нийгмийн шударга бус байдал бий болоход хүргэдэг. Ялгаварлан гадуурхах явдлыг гаргалгүйгээр иргэдийнхээ амьжиргааг зохистой түвшинд хүргэх нь Засгийн газрын эн тэргүүний зорилтуудын нэг байх ёстой. Эдийн засгийн үр ашгийн үүднээс авч үзвэл, хөгжлөөр хоцрогдож буй бүс нутгийг шинээр бий болж буй зах зээлтэй холбохын тулд хөдөө орон нутгийн дэд бүтэц, тээвэр, харилцаа холбоог хөгжүүлэх нь чухал юм. Ингэснээр бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлыг бууруулж, экспортын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулах боломжтой.

Хот, хөдөөгийн хоорондын ялгааг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үүднээс авч үзэх хэрэгтэй. Бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах нь байгаль орчинд учруулах хор хөнөөлийг багасгаж, ирээдүй хойч үеийнхнээ хот, хөдөөд амьдарч буйгаас нь үл хамааран, адил тэгш боломжоор хангах ач холбогдолтой. Орон зайн тэгш бус байдлыг бууруулахгүйгээр үндэсний эдийн засгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг зорилтууд амжилтанд хүрч чадахгүй юм. Эцэст нь, уг асуудлыг хүний аюулгүй байдлын үүднээс авч үзвэл, хот, хөдөөгийн хоорондын ялгаа ихсэх нь үндэсний тогтвортой байдалд аюул учруулдаг. Ядуурал, өлөн зэлмүүн байдал, өвчин зовлон, гэмт хэрэг, хэлмэгдүүлэлт, хувь хүний сэтгэлийн хямрал зэрэг үзэгдлүүд даамжрах нь нийгэмд хүчирхийлэл, зөрчил, тогтворгүй байдлыг бий болгож болзошгүй бөгөөд улмаар, эдийн засгийн өсөлт, хүний хөгжлийн тогтвортой байдалд мэдэгдэхүйц хэмжээгээр нөлөөлж болох юм.

Тэргүүлэх дөрвөн чиглэл

Монгол улсын Засгийн газар олон улсын байгууллага, иргэний нийгэмтэй түншлэлийн

харилцааг бий болгох үндсэн дээр улам бүр өсөн нэмэгдэж буй хот, хөдөөгийн ялгааг бууруулахад чиглэсэн хүчин чармайлтаа эрчимжүүлэх шаардлагатай болжээ. Хүний хөгжилд нөлөөлөх дээрх ялгааг шийдвэрлэхийн тулд тэргүүлэх ач холбогдол бүхий дөрвөн чиглэлийг тодорхойлж байна.

Ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлт

Монгол улсын сүүлийн хэдэн жилийн хөгжлийн түүхээс үзэхэд ядуурлыг бууруулах асуудалд дутуу анхаарч иржээ. Энэ нь зарим талаар тухайн үеийн бодлогын үр дүн хэдий ч, нөгөө талаар бодлогын хүрээнд, ялангуяа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогын өсч буй тэгш бус байдлыг бууруулах чиглэлд дорвитой арга хэмжээ аваагүйтэй холбоотой юм.

Хэдийгээр сүүлийн жилүүдэд эдийн засаг сэргэж, цар хүрээ нь өргөжиж байгаа боловч эдийн засгийн үндэс суурь сул дорой хэвээр байна. Монгол улс бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг макро эдийн засгийн удирдлагатай нягт уялдуулан хийх нь зүйтэй юм. 1990 оны эхээр өмч хувьчлах, үнэ чөлөөлөх арга хэмжээг ахар богино хугацаанд авч хэрэгжүүлсэн нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг эрс бууруулахад хүргэсэн билээ. Тиймээс, цаашид хийгдэх хөрөнгийн худалдаа, газрын шинэчлэлийн явцад хүн амын ядуу хэсгийн сонирхол, эрх ашгийг умартах аюул дахин давтагдвал аюултай юм. Хөдөө аж ахуйн салбар, ялангуяа мал аж ахуй амиа аргацаах байдалтай байгаа бөгөөд уг салбарын бүтээмж, үр ашиг буурчээ. Энэ байдлыг сайжруулах үүднээс үйлдвэрлэлийг дэмжих, үйлчилгээний (худаг гаргах, мал эмнэлгийн үйлчилгээ, г.м) хангамжийг сайжруулах замаар малчдад зээл олгох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа шаардлагатай байна.

Засгийн газрын макро эдийн засгийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэсэн бодлого хэт хатуу байгаа бөгөөд энэ нь ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах зэрэг чармайлтыг мэдэгдэхүйц хэмжээнд сааруулж байгаа тухай баримт олширсоор байна. Эрх баригчдаас төсвийн алдагдлаа бууруулж, мөнгөний хатуу бодлого хэрэгжүүлэхийг шаардаж байгаа нь эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтэд сөргөөр нөлөөлжээ. Гадаадаас үлэмж хэмжээний зээл, тусламж авч байгаа нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг чангаруулж байгаа юм. Төгрөгийн ханшны уналтаас сэргийлэх арга хэмжээ нь экспортын өсөлтийг хязгаарлаж байна. Зээлийн хүү, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш өндөр байгаа зэргээс болж үндэсний бизнесийн өрсөлдөх чадвар буурах боллоо. Үүний зэрэгцээ, төсвийн алдагдлын ихээхэн хэсгийг хандивлагчдын тусламж бүрдүүлж байгааг умартан, төсвийн буруу менежментийн илрэл болох төсвийн алдагдлыг нийгмийн үйл ажиллагааны “үндсэн” зардлуудыг хорогдуулах замаар шийдвэрлэхийг эрмэлзэж байна. Гэтэл нийгмийн салбарт зарцуулах төсвийн зарцуулалтыг бууруулах явдал нь иргэдийг ядууралд оруулах эрсдлийг бий болгож байна.

Хүснэгт 4.1 Хөрөнгө оруулалтын түвшин, ДНБ-д эзлэх хувиар, 1995-2000

Хөрөнгө оруулалтын хэлбэр	1995	1996	1997	1998	1999	2000
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	0.8	1.7	2.0	2.1	3.5	4.2
Дотоодын хөрөнгө оруулалт	15.7	20.3	20.7	23.7	25.6	24.7

Эх сурвалж: Кийт Гриффин, Монгол улсад ядуурлыг бууруулах нь, 2003.

Эдийн засгийн шинэчлэлтийг хийхдээ хувийн хэвшлийг цаашид хөгжүүлэх бололцоог өргөтгөх тал дээр онцгой анхаарах нь зүйтэй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хүн амын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжих нь чухал. Гэтэл гадаадын шууд хөрөнгө оруулалт уул уурхай, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт голчлон хийгджээ. Монголд хөрөнгө оруулагч орнуудын жагсаалтыг Хятад улс тэргүүлж байгаа бөгөөд 1990-ээд онд хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын 29.0 хувийг эзэлж байна. Цаашид олон улс орны гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, хөхүүлэн дэмжих бодлогоор дамжуулан аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгтэй.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд Засгийн газраас хөрөнгө оруулалтын нөхцлийг сайжруулахад ихээхэн анхаарах шаардлагатай байна. Ажиллах хүчний чадавхийг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг дэмжих зохицуулалтын хүрээг тодорхойлох, санхүү, эдийн засгийн тогтвортой бодлого баримтлах зэрэг нь түлхүү анхаарах асуудлын хүрээнд байх нь зүйтэй юм. Гэхдээ гадаадын шууд хөрөнгө оруулалт гол төлөв хотод төвлөрч байна. Бусад орнуудын нэгэн адилаар, Монголд хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр дүн нь гол төлөв нийгмийн дунд давхаргынхны орлогыг өсгөсөн боловч ядуу иргэдийн нөхцөл байдлыг төдийлэн өөрчилсөнгүй. Хэдийгээр хот суурин

газарт бараа, бүтээгдэхүүн элбэгшиж, үйлчилгээний хангамж сайжирсан боловч хот, хөдөөгийн ялгаатай байдал даамжирч, хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдэв.

Нийгмийн ядуу хэсгийн эрх, ашиг сонирхлыг дэмжихэд чиглэгдсэн эдийн засгийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхийн тулд улсын хэмжээнд нийгмийн салбарын зардлыг дахин нягталж үзэх нь зүйтэй. Доорх хүснэгтэнд Засгийн газраас нийгмийн салбарт зарцуулсан хөрөнгийн хэмжээг үзүүлэв. Улсын төсвийн зардалд нийгмийн салбарт зарцуулсан зардлын хэмжээ мэдэгдэхүйц өөрчлөлттэй байна. Нийгмийн салбарт зарцуулсан хөрөнгийн хэмжээ 1999 оны улсын төсвийн нийт зардлын 56.0 хувийг эзэлж байсан бол 2001 онд 67.0 хувь болон өсч, харин 2002 онд 51.0 хувь болж буурчээ. Эдгээр хөрөнгийн ихээхэн хэсэг нь хөрөнгө оруулалт хийх, хүнийг хөгжүүлэх чиглэлд бус харин ашиглалтын болон захиргааны зардалд зарцуулагджээ. Нийгмийн үйлчилгээг хувьчлах, гэрээний үндсэн дээр нийгмийн үйлчилгээгээр хангах зэргээр төсвийн зардлыг мэдэгдэхүйц хэмжээнд багасгах бололцоотой юм. Гэхдээ эдгээр арга хэмжээ нь жирийн ард иргэдийн чанартай сайн үйлчилгээ хүртэх өртөг зардлыг нэмэгдүүлэх ёсгүй билээ.

Хүснэгт 4.2 Нийгмийн салбарын санхүүгийн зардал

	2000	2001	2002
Төсвийн нийт зардал (сая.төг)	429 653.1	489 730.5	536 549.3
Нийгмийн салбарын нийт зардал (%)	52.3	55.3	52.0
Боловсролын үйлчилгээ (%)	19.1	20.2	19.2
Эрүүд мэндийн үйлчилгээ (%)	10.7	10.8	10.7
Нийгмийн даатгал ба нийгмийн халамж (%)	17.2	17.6	17.9
Орон сууц, төрийн үйлчилгээ (%)	1.6	1.4	1.0
Амралт, спорт, соёл урлаг (%)	3.3	3.1	3.2

Эх сурвалж: Монгол улсын Статистикийн эмхтгэл, 2002, УСГ; Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг, 2003, Монгол улсын Засгийн газар.

Эцэст нь, эдийн засгийн шинэчлэлийн хүрээнд ядуу иргэдэд ажил эрхлэх боломжийг бүрдүүлэхэд түлхүү анхаарах шаардлагатай байна. Үүний зэрэгцээ, хувийн хэвшил үйл ажиллагаагаа өргөтгөх нөхцлийг ч бүрдүүлэх шаардлагатай. Энэ нь төрөөс нийгмийн үйлчилгээний хүрээнд ялангуяа, дэд бүтцийн хөгжилд ухаалгаар, сайтар цэгнэж дүгнэсний үндсэн дээр зөв хөрөнгө оруулалт хийхийг шаардаж байна.

Тэнцвэртэй хөгжил

Монгол улс иргэдээ боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээ болон мэдээлэл хүртэх тэгш боломжоор хангаж чадахуйц бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Энэ нь хот, хөдөөгийн хоорондох болон хотын төв доторх хөгжлийн ялгаатай байдлыг багасгахад тус дөхөм үзүүлнэ. Түүнчлэн, бодлогоороо хүний хөгжлийг дэмжих замаар эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлж, улмаар эрх тэгш, тогтвортой байдлыг хөхүүлэн дэмжих учиртай. 2001 онд Монгол Улсын Их Хурлаас бүс нутгуудын хөгжлийг хангах стратегийн баримт бичиг болох бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг баталсан билээ. Төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтыг зохистой харьцаанд барих замаар тэнцвэртэй хөгжилд Засгийн газар шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжтой. Тухайлбал, орон нутагт хөдөө аж ахуйн маркетинг, агро-бизнес болон үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх замаар орон нутгийн орлогыг нэмэгдүүлж, цаашид хийх хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх бололцоотой болж чадна.

Цаашид хэрэгжүүлэх газрын шинэчлэл нь даац хэтэрсний улмаас бэлчээрийн доройтол бий болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэх нь зүйтэй юм. Хөдөө орон нутагт малчдад үйлчилгээ үзүүлэх байгууллагууд, шинээр худаг гаргах зэрэг үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх нь мал аж ахуйн үр ашгийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой. Шилжилтийн эхний жилүүдэд хотоос нүүдлэн очсон олон иргэдийн амь зуулгын эх үүсвэр болж, эдийн засгийн хамгийн том салбар байсаар байгаа мал аж ахуйд ахиц гаргах нь амин чухал юм.

Жижиг бизнесийг дэмжих, зээлийн хүртээмжийг сайжруулах механизм, орон нутгийн зах зээлийг төрөлжүүлэн өргөжүүлэхэд чиглэсэн бүхий л арга хэмжээг хөхүүлэн дэмжиж, бэхжүүлэх шаардлагатай байна. Зам тээврийн салбарт хөрөнгө оруулалт хийх нь хөдөөг хот суурин, гадаад зах зээлтэй холбоход ихээхэн ач холбогдолтой бол боловсрол, технологийн салбарт хөрөнгө оруулалт хийж, мэдээллийн хүртээмжийг сайжруулснаар хөдөөгийнхний бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Бүтэц, зохион байгуулалтын болон татварын шинэчлэлийг хэрэгжүүлснээр улсын хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж болно. Тухайлбал, газрын түрээсийн төлбөрийг бий болгон, түүгээрээ мал аж ахуйн

салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж болох юм.

Үүний нэг адил, хот суурин газрын орон сууцны барилга, дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар хотын гэр хорооллын ахуйн нөхцлийг сайжруулах боломжтой. Үндэсний эдийн засагт гарсан өөрчлөлтийн дүнд үүсч тэлсэн албан бус секторыг Засгийн газраас хөрөнгө нөөцийн оновчтой зарцуулалтаараа дэмжих нь зүйтэй. Албан бус секторын үйлдвэрлэл эрхлэгчид, ажиллагсдын өмнө бага хүүтэй зээл олж авах боломж, шинэ технологи, түүхий эд, тоног төхөөрөмжөөр хомсдох зэрэг бэрхшээлүүд учирч байна.

Монгол улс хүмүүсийн ажил эрхлэх боломжийг дээд зэргээр хангаж чадахуйц хөдөө аж ахуйн болон аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Үүнийг аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэх, байгалийн онгон төрхөө хадгалах асуудлын тэнцвэрт байдлыг хангах үндсэн дээр хэрэгжүүлэх нь чухал байна.

Шилжих хөдөлгөөнийг зохицуулах хамгийн үр ашгатай арга хэрэгсэл бол бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах явдал юм. Шинэ боломж хайж буй хүмүүсийн шилжих хөдөлгөөн нь аажмаар бүс нутгийн ялгаатай байдлыг тэнцвэржүүлдэг билээ. Ажлын байрны хомсдол, эрүүл мэнд, боловсролын чанаргүй үйлчилгээ, зах зээлээс алслагдмал байдал, байгаль орчны доройтол зэрэг нь шилжих хөдөлгөөнийг “түлхэх” хүчин зүйлс болж байна. Хоршооллыг байгуулж хөгжүүлэх нь малчдын хувьд зардал багатай, илүү ашигтай бизнес эрхлэх, сум, багийн өмнө тулгарсан асуудлыг хамтран шийдвэрлэх, тэдний нийгмийн оролцоог хөхүүлэн дэмжих, орон нутагт иргэний нийгмийг бэхжүүлэх зэрэгт онцгой ач холбогдолтой. Малчид хоршоолол үүсгэн байгуулахын ач холбогдлыг ухамсарлан ойлгож, тааламжтайгаар хүлээн авч байна. Иймээс ч Засгийн газраас 2003 оныг “Хоршооллын жил” болгон зарлалаа. Үүнээс гадна, хөдөөгийн эдийн засагт бүтээлч, өндөр мэргэжил бүхий хүний нөөцийг бий болгох нь нэн чухал асуудал болоод байна.

Төвлөрлийг сааруулах үйл явцыг бэхжүүлэх

Монгол Улсын “Үндсэн хууль” ардчиллын үнэ цэн, хүний эрхийг дээдэлсэн засаглалын тогтолцоог баталгаажуулсан билээ. 1992 онд Улсын их хурлаас баталсан “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуульд засаг захиргаа, нутаг дэвсгэр, нэгжийг удирдах эрх бүхий орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын бүтэц, гүйцэтгэх үүргийг тодорхойлсон юм. Засгийн газар 1996 онд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудыг бэхжүүлэх замаар төвлөрлийг сааруулахад чиглэсэн мөрийн хөтөлбөрийг боловсруулан гаргасан. 2000 оноос засгийн эрх барьж буй Засгийн газар энэ бодлогыг залгамжлан хэрэгжүүлэхдээ засаг захиргааны илүү том нэгжийг үүсгэн байгуулах замаар хэрэгжүүлэх “Бүсчилсэн

хөгжлийн үзэл баримтлал”-ын дагуу төвлөрлийг сааруулах өөр хувилбарыг боловсруулан гаргалаа.

Төвлөрлийг сааруулах бодлого амжилттай хэрэгжихэд орон нутгийн засаг захиргаа үйл ажиллагаагаа өөрийн хөрөнгөөр бие даан санхүүжүүлэх явдал зайлшгүй чухал. Ихэнх аймгууд улсын төсвөөс хуваарилах татаасаас ихээхэн хараат байдалд байгаа өнөөгийн нөхцөлд энэ нь ойрын үед хэрэгжүүлэх зорилго болж хараахан чадахгүй юм. Засгийн газрын төв байгууллагуудад ажиллаж байгаа төрийн захиргааны өндөр ур чадвар бүхий мэргэшсэн албан хаагчид мэдээлэл олж авах, сургалтанд хамрагдах, чадавхиа бэхжүүлэх чиглэлээр бусад үйл ажиллагаанд хамрагдах боломжоор илүү хангагдаж байна. Иймд аймаг, орон нутгийн төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулахад түлхүү анхаарах шаардлагатай болжээ. Боловсрол, эрүүл мэнд болон нийгмийн бусад үйлчилгээ үзүүлэх чиглэлд орон нутгийн захиргааны чадавхийг бэхжүүлэх нь чухал юм. Орон нутгийн төсвийг бүрдүүлж хуваарилах, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, орон нутгийн хөгжлийг төлөвлөх, бодлого боловсруулах зэрэг чиглэлд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай байна.

Эдгээр шинэчлэлийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоо юу юунаас илүү чухал үүрэгтэй. Ардчиллын талаарх дутмаг ойлголт, ардчилалд үл итгэх байдал, өмнөх тогтолцооноос уламжлагдсан бие даан шийдвэр гаргахаас зайлсхийж, дээд удирдлагын амыг харах хандлага, доод түвшинд хариуцсан үүргээ биелүүлэхгүй байх зэрэг нь төвлөрлийг сааруулах үйл явцад саад тотгор учруулж байна.

Төвлөрлийг сааруулах аливаа хүчин чармайлт бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдаатай байх нь чухал. Төвлөрлийг сааруулах үйл ажиллагааны хүрээнд засаглал болон хөгжлийн чиг үүргийг захиргааны аль болох хамгийн доод шатанд хүртэл шилжүүлэх нь зүйтэй. Ийм бодлогын хүрээнд Засгийн газар нь нийгмийн хамгаалал, батлан хамгаалах, хууль эрх зүйн асуудлуудаа хариуцаж, харин орон нутгийн засаг захиргаа эрүүл мэнд, цэцэрлэг, анхан ба дунд шатны боловсролын үйлчилгээ зэргийг хариуцдаг байх боломжтой.

Хэрэгжүүлсэн бодлого эрх мэдэл, хариуцлагыг шилжүүлэх, ажил, үүргийн давхардлыг арилгах зэргээр төвлөрлийг жинхэнэ утгаар нь сааруулж чадаагүй бол тэдгээрийг дахин боловсруулах шаардлагатай юм. Хэдийгээр орон нутгийн засаг захиргаа Засгийн газрын татаас болон орон нутгийн татварын орлогоос олсон төсвийн хөрөнгийг зарцуулах эрхтэй боловч татварын түвшинд аливаа нэгэн өөрчлөлт хийх, татвараа нэмэгдүүлэх зэрэг эрх мэдэлгүй байна. Үүний нэгэн адилаар, орон нутгийн удирдлага нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг тогтооход санхүүгийн хариуцлага хүлээдэг боловч орон нутагт шилжин орж ирсэн нөөц хөрөнгийг шийдвэр гаргах түвшинд хянах эрхгүй байдаг. Гэхдээ тэд хуваарилагдсан

хөрөнгийг зардлын ангиллын дагуу хэрэглэх эрхтэй.

Аймгийн түвшинд шийдвэр гаргах, төсвийн орлого зарлагыг хянах зэрэг үйл ажиллагаа Засгийн газрын дүрэм, журмын хүрээнд явагдаж байна. Орон нутгийн захиргаа орон нутгийн болон ядуу хүн амын хэрэгцээг тодорхойлох, хүн амд тэтгэмж, үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээдэг.

Төвлөрлийг сааруулах нь дан ганц дээрээс доош чиглэсэн захиргааны болон хүнд суртлын үйл ажиллагаа биш юм. Захиргааны болон санхүүгийн эрх мэдлийг шилжүүлэх хүчин чармайлтын хүрээнд хүмүүсийн оролцоог бүхий л түвшинд хөхүүлэн дэмжих явдал чухал байна. Ард иргэдэд өөрсдийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлж, эн тэргүүнд шийдвэрлэх асуудлуудыг авч хэлэлцэх боломжийг олгох зорилгоор чуулга уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах нь чухал юм. Цаашилбал, ТББ болон орон нутаг дахь иргэний нийгмийг бэхжүүлэн, хөгжүүлэх шаардлага тулгарчээ. Төвлөрлийг сааруулах үйл явцын амжилт төр болон хувийн хэвшлийн байгууллагын хоорондын түншлэлийн шинэлэг харилцаанаас ихээхэн хамаарах болно.

Хөгжлийн санхүүжилт

Монгол улсын хувьд хүний хөгжлийг хурдасгах, хот, хөдөөгийн ялгаатай байдлыг арилгахад чиглэсэн хүчин чармайлтын амин чухал хэсэг бол санхүүжилтын асуудал юм. Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэргүй байдлыг бууруулахын тулд төсвийн орлогын бүрдүүлэлт, хуваарилалтын зарчмыг өөрчлөх хэрэгтэй юм. Хөдөө орон нутагт дэд бүтцийн хөгжил болон нийгмийн суурь үйлчилгээг хүргэхэд хотод зарцуулж байгаагаас илүү их хөрөнгө шаардагддаг. Иймээс улсаас хийж буй хөрөнгө оруулалтын арай ахиухан хэсгийг нь хөдөө, орон нутагт зарцуулах хэрэгтэй байгаа боловч төсвийн алдагдал их, татварын орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа өнөөгийн нөхцөлд энэ нь амаргүй хэрэг билээ. Засгийн газар аймгийн төвшинд бус, илүү алсыг харсан төсвийн зарцуулалтыг бий болгох замаар бүсчилсэн, тэнцвэртэй хөгжилд хүрэх асуудалд анхаарах шаардлагатай байна.

Хотоос алслагдсан хөдөө нутагт нийгмийн үйлчилгээг хүргэх, иргэдийн төлөөлөгчдийн хурлын байгууллагууд, гүйцэтгэх болон шүүх засаглалын байгууллагуудын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд илүү өндөр зардал шаарддаг.

Алслагдах тутам хөдөө нутгийн хүн амд үзүүлж буй нийгмийн үйлчилгээний чанар муудах хандлагатай. Үүнээс үзэхэд, нэг талаас орон нутагт нийгмийн үйлчилгээг сайжруулах шаардлага, нөгөө талаас орон нутгийн төсвийн хомсдолтой байдал хоёрын хооронд зөрүүтэй байдал үүсчээ. Алслагдсан аймгуудад нийгмийн үйлчилгээнд зарцуулах зардлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага илүүтэй байгаа боловч бодит байдал үүнтэй төдийлөн нийцэхгүй байна. Тооцооноос үзэхэд, 2002 онд нийслэлээс 400 км хүртэл алслагдсан 8 аймагт нэг хүнд ногдох

төсвийн зарлагын хэмжээ улсын дунджаас 15.0 хувиар дээгүүр байгаа бол 400-900 км-т алслагдсан 8 аймагт 3.4 хувь, 900-1600 км-т алслагдсан 5 аймагт 0.6 хувь тус тус доогуур байлаа¹⁷. Харин хүн амын нягтрал хамгийн багатай 8 аймагт нэг хүнд ногдох төсвийн зарлага улсын дунджаас 11.5 хувиар дээгүүр байна¹⁸.

Орон нутгийн төсвийн мэдээнээс харахад, хотууд өөрийгөө санхүүжүүлэх түвшинд дөхөж очсон байхад харин аймгуудын төсөв алдагдалтай, төвлөрсөн төсвөөс татаас авсан хэвээр байна. “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн дагуу зарим объектуудыг төрийн өмчлөлөөс орон нутгийн өмчлөлд шилжүүлсэн нь орон нутаг төсвөө бие даан бүрдүүлж, хуваарилах чиглэлд хийгдсэн анхны алхам мөн билээ.

Олон жилийн туршид Монгол улс хөгжлийг санхүүжүүлэх гадны зээл, тусламжаас туйлын хамааралтай байгаа юм. Хуучин ЗХУ-аас Монгол улсад үзүүлдэг байсан бүхий л тусламж гэнэт зогсч, 1990 оноос эхлэн гадаадын бусад улсаас зээл, тусламжийг авах болсон. Эдгээр нь шилжилтийн эхэн үеийн

Хүснэгт 4.3 Хөгжлийн албан ёсны тусламж, 1991-2001

Он	Хөгжлийн албан ёсны тусламж (ДНБ-д эзлэх хувиар)	Нэг хүнд ногдох хөгжлийн албан ёсны тусламж (ам. доллар)
1991	20	45
1992	33	68
1993	36	93
1994	25	77
1995	18	99
1996	18	90
1997	25	113
1998	21	84
1999	24	81
2000	17	67
2001*	20	84

Эх сурвалж: Кийт Гриффин, Монгол улсад ядуурлыг бууруулах нь, 2003;

Тэмдэглэгээ: *Дэлхийн хүний хөгжлийн илтгэл, 2003, НҮБ.

хүнд хэцүү байдлыг даван туулахад нэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Гадаад орнуудаас Монгол улсад үзүүлж буй зээл, тусламжийн шинж чанар өөрчлөгдсөөр байна. Эхэн үедээ гадны зээл, тусламж нь шилжилтийн хүнд хэцүү байдлыг даван туулахад чиглэгдэж байсан бол яваандаа төслийн хүрээний зээл тусламжийг үзүүлэх болжээ. 1990-ээд онд Хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ ДНБ-ий 24.0 хувьтай тэнцэх хэмжээнд хүрч, 1991-2000 онд 1.9 тэрбум ам.долларын зээл тусламж авчээ. Социализмын жилүүдэд, тодруулбал, 1989 онд ЗХУ болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын үзүүлж байсан тусламж тухайн үеийн ДНБ-ий гуравны нэг орчимтой тэнцэж байжээ. Үүнээс үзвэл хөгжлийн албан ёсны тусламж нь ЗХУ, ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудаас үзүүлж байсан тусламжийг орлосон төдийгүй, шилжилтийн эхэн үеийн хямралаас гарахад тус дөхөм үзүүлсэн юм. Гэвч өнөөгийн байдлаар гадаад өр өссөөр байна. Гадаад өрийн ДНБ-д эзлэх хувийн жин 1997-2001 онд 60.7-аас 89.9 хувь хүртэл өсчээ. Хамгийн сүүлийн үеийн (2001 оны) тоо баримтаас үзвэл, Монгол улс гадаадын тусламжаас хараат байдлаараа дэлхийд есдүгээр байранд орох болж, Палестины бүс нутаг, Малави, Соломоны арлын зэрэг орнуудтай ойролцоо түвшинд хүрсэн байна.

Хүснэгт 4.4 Хөгжлийн албан ёсны тусламжийн гол хандивлагч улс орон, байгууллагууд (1991-2002 онд ам. доллараар үзүүлсэн нийт тусламж)

Буцалтгүй тусламж		Зээл			
Япон	602.79	Хоёр талт		Олон талт	
АНУ	137.27	Япон	236.85	АХБ	376.25
Герман	114.82	ОХУ	104.15	ДБ	181.56
Европын холбоо	42.20	Герман	57.81	ОУВС	90.28
АХБ	42.03	Өмнөд Солонгос	26.33	Нордын сан	12.83
НҮБХХ	37.70	Хятад	15.54	ХААХОУС	2.83

Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагаа, бодлого зохицуулалтын газар, 2002, СЭЗЯ.

¹⁷ Монгол улсын Статистикийн эмхтгэл 2002-т тулгуурлан хийсэн тооцоо

¹⁸ Монгол улсын Статистикийн эмхтгэл 2002 -т тулгуурлан хийсэн тооцоо

1990-ээд онд хөгжлийн албан ёсны тусламж дунджаар ДНБ-ий 24.0 орчим хувьтай тэнцэж, бага орлоготой орнуудын дунджаас 10 дахин их байсан атлаа эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад төдийлөн нөлөөлж чадаагүй тул гадаадын зээл, тусламжийн үр ашгийн тухай асуудал хурцаар тавигдах болов. Үүнээс үүдэн хөгжлийн тусламжийн үр нөлөөг нарийвчлан тооцох, тусламжийн удирдлага, зохицуулалтын механизмыг бэхжүүлэх чиглэлд илүү харилцан зөвшилцөх байдлаар хүчин чармайлт тавих шаардлагатай болж байна.

Үүнтэй холбоотой өөр нэг зүйл бол гадаад өрийн асуудал юм. 1991-2000 онд Монгол улс нийт 1,897.1 сая ам.долларын тусламж авснаас 903.1 сая ам.долларыг (48.0 хувь) зээлийн хэлбэрээр, үлдсэнийг нь буцалтгүй тусламжийн хэлбэрээр авчээ.

өөрчлөгдөх байсан биз ээ. Гадаад өр, ДНБ-ий харьцаа, хүүгийн төлбөр, ДНБ-ий харьцаа болон бусад үзүүлэлтүүдийг ашиглан олон улсын нийтлэг жишгээр 2010 оны үнэлгээг хийж үзвэл 2009 онд Монгол улс хамгийн их өртэй, ядуу орны ангилалд багтах төлөвтэй байна.

Хүний хөгжлийг түргэтгэж, ядуурлыг бууруулахын тулд Монгол улс олон тооны бэрхшээлийг даван туулах шаардлагатай болжээ. Гэвч 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтыг тодорхой хэмжээнд биелүүлнэ гэдэгт эргэлзэх хэрэггүй юм. Хөгжлийн үр шимийг хотод оршин сууж буй хүн ам давуу байдлаар хүртэх бус, Монгол улсын бүх иргэд тэгш хүртэх бололцоог бүрдүүлэхэд анхаарах нь нэн чухал юм. Орон зайн ялгаатай байдлыг арилгах нь Монгол улсын хүний хөгжилд зайлшгүй шаардлагатай үндсэн асуудал мөн билээ.

Хүснэгт 4.5 1991-2000 онд Монголд үзүүлсэн хөгжлийн албан ёсны тусламж (сая ам.доллар)

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	Нийт
Зээл	60.9	82.4	85.6	62.7	90.6	96.0	142.0	94.4	109.7	78.6	903.7
Тусламж	34.8	65.6	121.0	110.3	135.4	114.2	125.2	107.3	98.5	81.7	994.0
Нийт тусламж	95.7	148.0	206.6	173.0	226.0	210.2	267.2	201.7	208.2	160.5	1897.1

Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагаа, бодлого зохицуулалтын газар, 2001, СЭЗЯ.

1991-2001 онд гадаад валютаар төлөгдөх өрийн хэмжээ ДНБ-ий 6.0 хувиас 85.0 орчим хувьд хүртэл огцом өссөн юм. 2001 он гэхэд зээлийн хүүгийн жилийн төлбөрийн хэмжээ ДНБ-ий 4.0 хувь буюу улсын төсвийн орлогын 15.0 орчим хувьтай тэнцэх хэмжээнд хүрэв (буцалтгүй тусламжийг хасч тооцсоноор).

Хоёр болон олон талт албан ёсны зээлдүүлэгчдийг зээл олгосон хэмжээгээрээ АХБ, ДБ болон Япон улсууд тэргүүлж байгаа бөгөөд тэдэнд бүх зээлийн өрийн дийлэнх хэсэг нь ногдож байна. Хөрвөх валютаар төлөх эдгээр өрөөс гадна хуучин ЗХУ-д төлөх ёстой байсан ихээхэн хэмжээний өрийн асуудал хөндөгдөөд байна.

Дээрх өрийн талаар эргэлзээтэй олон асуудал байна. ДБ, ОУВС-аас Монгол улсын өрийг тодорхой нөхцлүүдийн хүрээнд тогтвортой байгаа, бүтцийн өөрчлөлт хийх шаардлагагүй гэж үзэж байна. Хэрэв эдийн засгийн өсөлт, зээлийн санхүүжилт, шилжих рублийн өрийн зохицуулалтын асуудлуудаар өөдрөг үзэл бодол байгаагүйсэн бол магадгүй энэ дүгнэлт



2003 оны Монголын Хүний Хөгжлийн Илтгэлд зориулан бэлтгэсэн эх материал (хэвлэгдээгүй)

- Ц.Адьяасүрэн, 2002. *Хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдалд байгаль, цаг уур, газар зүйн хүчин зүйлсийн үзүүлэх нөлөө.* Улаанбаатар, Монгол
- Н.Баяртсайхан, 2002. *Эдийн засаг ба хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдал.* Улаанбаатар, Монгол
- Ч.Дагвадорж, 2002. *Хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдалд хүн ам, ядуурал, эмзэг байдал, аюулгүй байдлын үзүүлэх нөлөөлөл.* Улаанбаатар, Монгол
- Г.Чулуунбаатар, 2002. *Засаглал ба хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдал.* Улаанбаатар, Монгол
- М.Энхсайхан, 2002. *Хандивлагчдын хөрөнгө ба хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдал.* Улаанбаатар, Монгол
- Х.Энхжаргал, 2002. *Хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдалд олон нийт, иргэдийн оролцоо, мэдээллийн хүртээмж, жендерийн үзүүлэх нөлөөлөл.* Улаанбаатар, Монгол

Ашиглагдсан бусад материалууд

- Т.Амгалан, Н.Оюунчимэг, 2003. *Жендерийн нэр томъёо, тодорхойлолт, үндсэн ойлголтууд.* Улаанбаатар, Монгол
- Азийн Хөгжлийн Банк, 2002. *Монгол улсад тусламж үзүүлэх хөтөлбөрийн үнэлгээ.*
- Багэ, Леннарт. Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Олон Улсын Сангийн ерөнхийлөгч, 2002. *Дэлхийн Банк ба Олон Улсын Валютын Сангийн Хөгжлийн Хороонд хийсэн мэдэгдэл.* 2002 оны 9 сарын 28, Вашингтон, ДС
- Б.Баясгалан, П.Цэцгээ, Р.Ноиперт, Ж.Баянсан, 1993. *Хүн ам зүйн гарын авлага.* Улаанбаатар, Монгол
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, НҮБХХ, НҮББСШУБ, НҮБХС, НҮБХАС, Дэлхийн Банк. *Монгол улсын бүх нийтийн боловсролын талаарх үндэсний тайлан 2000.* 2000 оны 1 сар, Улаанбаатар, Монгол
- К. Гриффин, 2003. *Монгол улсад ядуурлыг бууруулах нь.* Австрали, Соут Вуд Пресс
- Ц. Дашдондов, 2000. *Хүний эрх ба хэвлэлийн эрх чөлөө.* Хүний Эрхийн Үндэсний Бага Хурал, Улаанбаатар, Монгол

Дэлхийн банк, 2002. *Төсвийн зарлага, санхүүгийн удирдлагын тойм судалгаа: Төсвийн зарцуулалтын удирдлага, зохион байгуулалт дахь цоорхойг нөхөх нь* 2002 оны 6 сар (Ядуурлыг Бууруулах, Эдийн Засгийн Менежментийн Салбарын Нэгж, Зүүн Ази Номхон Далайн бүс)

Дэлхийн банк, 2002 оны 5 сар. *Тогтвортой амьжиргаа хөтөлбөрийн эхний шатны хэрэгжилтийг дэмжих Тогтвортой амьжиргааны төсөл.*

Дэлхийн банк, Андерсон Жеймс Х, 1998. *Шилжилтийн үеийн Монгол улс дахь албан бус секторын хэмжээ, үүсэл, шинж чанар.* Бодлого судлалын ажлын баримт бичиг №1916

Дэлхийн банк, 2002. *Монгол улс: Тусламжийн үнэлгээ.* Вашингтон

Жорж Сорос, 2000. *Даяарчлал.* Нью Йорк, ББС

И.М. Майский, 1921. *Орчин цагийн Монгол улс: Автономит Монгол Улс XX зууны эхэнд.*

Монгол улсын Гаалийн ерөнхий газар, 1995-2002. *Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл.* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Их хурал, 1992. *Монгол улсын үндсэн хууль.* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Их хурал, 1993. *Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Монгол улсын хууль.* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Их хурал, 1997. *Төрийн бус байгууллагын тухай хууль.* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Засгийн газар, 1999. *Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр.* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Засгийн Газар, 1999. *Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны стратеги. 1999-2002,* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Засгийн Газар, 2000. *Хүрээлэн буй орчны өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр.* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Засгийн газар, НҮБХХ, СИДА, Очирбат сан. *Монгол улс дахь хүний аюулгүй байдал: Бага хурлаас төрсөн бодол.* 2000 оны 7 сар, Улаанбаатар, Монгол

Монгол улсын Засгийн газар, 2001 оны 6 сар. *Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг.* Улаанбаатар, Монгол

Монгол улсын Засгийн газар, 2001. *Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр.* Улаанбаатар, Монгол

- Монгол улсын Засгийн газар, 2002. *Хөдөөгийн хөгжил-Хандивлагчдын бага хурал, дүгнэлтийн баримт бичиг*. 2002 оны 5 сарын 27-28, Улаанбаатар, Монгол
- Монгол улсын Засгийн газар, 2002. *2003 оны Нийгэм эдийн засгийн хөгжлийн Засгийн газрын чиг баримжаа, 2004-2006 онуудын хөгжлийн хандлага*. Улаанбаатар, Монгол
- Монгол улсын Засгийн газар, 2002. *Монгол Улсын 2003 оны төсвийн төсөл*. Улаанбаатар, Монгол
- Монгол улсын Засгийн газар, 2003. *Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр*. Улаанбаатар, Монгол
- Монгол улсын Засгийн газар, 2003. *Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дэмжин, ядуурлыг бууруулах стратеги*. Зөвлөлдөх уулзалт, 11 сарын 19-21, Токио, Япон
- Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, 2001. *Монгол улс дахь хүний эрх ба эрх чөлөө: Нөхцөл байдлын тайлан 2003*. Улаанбаатар, Монгол
- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Хүн амын сургалт, судалгааны төв, НҮБХАС, 2001. *Дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа*. Улаанбаатар, Монгол
- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Үндэсний статистикийн газар, НҮБЭХС, Монгол улс ба НҮБХХ, 2002. *Хөдөөгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй судалгаа*. Улаанбаатар, Монгол
- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, НҮБХХ, 2002. *Монгол улс дахь дэд салбаруудын микро санхүүжилтийн судалгаа*. Улаанбаатар, Монгол
- “Нийгмийн Дэвшил-Эмэгтэйчүүд” Хөдөлгөөн, 2001. *Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал-Иргэдийн оролцоо*. Улаанбаатар, Монгол
- НҮБ-ын АНДНЭЗК, 2001. *Ялгааг багасгах нь: Ази Номхон Далайн орнуудын хот, хөдөө болон бүс нутгуудад тэнцвэртэй хөгжлийг хангах нь*. НҮБ, Нью Йорк
- НҮББОХ, 2003. *Дэлхийн байгаль орчны дүр төрх 3*. Лондон Earthscan. (<http://www.unep.org/geo/>)
- НҮБ, 1996. *Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийн тогтолцоо*. Нью Йорк
- НҮБ, 2003. *Мянганы хөгжлийн зорилтууд*. Нью Йорк (<http://www.un.org/millenniumgoals/>)
- НҮБХХ, 1995, 1996. *Хүний хөгжлийн илтгэл*, 1995, 1996. Нью Йорк, Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн Газар (<http://www.hdr.undp.org/reports/global/1996/en/>) (<http://www.hdr.undp.org/reports/global/1995/en/>)
- НҮБХХ, Монгол улсын Засгийн газар, 1997, 2000. *Монголын хүний хөгжлийн илтгэл*. 1997, 2000, Улаанбаатар, Монгол
- НҮБХХ, 1999. *Хүний хөгжлийн илтгэл*, Европ ба ТТУХН. Москва
- НҮБХХ, Зөвлөх ба бизнес төв, удирдлагын академи, Тогтвортой хөгжлийн жендэр төв, ЗБН Зөвлөлдөх нэгж, 2000. *Монгол улсын нийгмийн секторт ТББ хэрэгжүүлсэн тусламж судалгааны тайлан*. Улаанбаатар, Монгол
- НҮБХХ, 2001. *Монгол улсад ядуурлыг бууруулах стратеги 2001: Хөгжлийн стратегид тэгш байдал, ядуурлыг бууруулах асуудлыг тусгах нь*. Профессор Гриффиний багийн тайлан, Улаанбаатар, Монгол
- НҮБХХ, 2001. *Хүний хөгжлийн илтгэл 2001: Технологи Хүний Хөгжилд*. Нью Йорк, Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн Газар (<http://www.hdr.undp.org/reports/global/1996/en/>)
- НҮБХХ, 2001. *Монгол Улс дахь Мэдээлэл, Харилцааны Технологийн өнөөгийн байдал ба “Ногоон” Хоршооллын Хөгжил-судалгааны тайлан*. ИнфоСон ХХК
- НҮБХХ, 2002. *Латви улс: Хүний хөгжлийн илтгэл*. 1999-2001.
- НҮБХХ, 2003. *Хүний хөгжлийн илтгэл 2003: Мянганы хөгжлийн зорилтууд: Хүний ядуурлыг арилгахын төлөө улс үндэстнүүд нэгдэх нь*. Нью Йорк, Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн Газар
- НҮБХХ, Дэлхийн банк, 2002 оны 7 сар. *Монгол улсад тохиромжтой хөдөөгийн хөгжлийн стратегийг хандивлагчдаас дэмжих нь*.
- НҮБХХ, НҮБЭХС 2003. *Монгол улсын хөдөө дэхь жендэрийн байдлыг зураглахуй: Бодлого боловсруулахад зориулсан мэдээлэл*. Улаанбаатар, Монгол
- НҮБХС, 2000. *Монголын эмэгтэйчүүд, хүүхдийн өнөөгийн байдал: Үнэлгээ ба дүн шинжилгээ*. Улаанбаатар, Монгол
- НҮБХС, 2002. *Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал: Хүүхдийн оролцоо*. Нью Йорк, Оксфордын Их Сургуулийн Хэвлэлийн Газар
- НҮБХС, Боловсрол соёл шинжлэх ухааны яам, 2001. *Ном болон бусад хэвлэлийн хүртээмж*. Асуудал хөндсөн баримт бичиг, Улаанбаатар, Монгол
- НҮБЭХС, 2001. *Монголын эмэгтэйчүүд: Шилжилтийн үеийн дэвшлийг зураглахуй*. Улаанбаатар, Тоонотдринт ХХК

- Ричард Жолли, 2003. *Хүний хөгжлийн болон нео-либерализмын парадигмыг харьцуулах нь*. ХХИ хэвлэл, Хүний хөгжлийн талаархи нийтлэл, Оксфордын Их сургуулийн Хэвлэлийн Газар
- Санхүү эдийн засгийн яам, Ядуурлын судалгааны нэгж, 2003. *Малчдын хөрөнгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах арга замын үнэлгээ*. Улаанбаатар, Монгол
- Скаутын холбоо, НҮБХС 2000. *Монголын өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээний үнэлгээ*. Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 1991-2002. *Монгол улсын статистикийн эмхтгэл*. Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, НҮБХАС, 1999. *Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа 1998*, Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, НҮБХХ, 1999. *Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998*, Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, НҮБХХ, 2000. *Цаг ашиглалтын туршилтын судалгаа*. Улаанбаатар, Монгол
- ҮСГ, НҮБХС, 2000. *Хүүхэд ба хөгжил*. Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 2000-2002. *Статистикийн бюллетень*. Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 2001. *2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн*. Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, Дэлхийн Банк, 2001. *Амьжиргааны түвшнийг оролцооны аргаар үнэлэх судалгаа*. Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 2002. *2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Дотоод шилжих хөдөлгөөн ба хотжилт*. Сэдэвчилсэн судалгаа, Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 2002. *2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Монгол улсын хүн амын хэтийн тооцоо*. Сэдэвчилсэн судалгаа, Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 2002. *2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Боловсрол, бичиг үсгийн мэдлэг*. Сэдэвчилсэн судалгаа, Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 2002. *2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Хүн амын эдийн засгийн идэвх*. Сэдэвчилсэн судалгаа, Улаанбаатар, Монгол
- Үндэсний статистикийн газар, 2002. *2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Монгол Улс дахь жендэрийн байдал*. Сэдэвчилсэн судалгаа, Улаанбаатар
- Үндэсний статистикийн газар, 2002. *2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Монгол улс дахь өндөр настангууд*. Сэдэвчилсэн судалгаа, Улаанбаатар
- Үндэсний статистикийн газар, 2002. *Хөдөөгийн хөгжлийг оролцооны аргаар үнэлэх судалгаа*. Улаанбаатар, Монгол
- Хэвлэл, мэдээлэл судалгааны агентлаг, 2002. *Монгол улсын хэвлэлийн мониторинг*. Улаанбаатар, Монгол
- К. Ченг, 2000. *Шилжилтийн үеийн Монгол улс дахь өсөлт ба сэргээн босолт*. ОУВС, ажлын баримт бичиг
- Эдийн засгийн бодлогыг дэмжих төсөл, USAID /Бикалес Уильям, Ч. Хүрэлбаатар, Карин Шельциг, *Монгол улсын албан бус сектор: Судалгааны үр дүн, дүн шинжилгээ*. 2000 оны 4 сар
- Эрүүл мэндийн яам, 2000, 2002. *Эрүүл мэндийн үзүүлэлтүүд*. Улаанбаатар, Монгол
- Эрүүл мэндийн яам, ДЭМБ, 2002. *Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх стратегиуд 2002*. Улаанбаатар, Монгол
- Эрүүл мэндийн яам, НҮБХАС, 2001. *Эхийн эндэгдлийн шалтгаан ба тодорхойлогч хүчин зүйлс*. Улаанбаатар, Монгол
- Эрүүл мэндийн яам, 2002. *Эрүүл мэндийн салбарын 80 жилийн ой*. Улаанбаатар, Монгол
- Эрүүл мэндийн яам, 2002. *2000-2006 онд эхийн эндэгдлийг бууруулах стратеги*. Улаанбаатар, Монгол
- Ядуурлыг бууруулах хөтөлбөр, 2001. *Төгсгөлийн товч илтгэл, 1994-2000*. Улаанбаатар, Монгол
- Ядуурлыг бууруулах хөтөлбөр, 2001. *Сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх төсөл, 1997-2001*. Улаанбаатар, Монгол

Хүснэгт XI Хүний Хөгжлийн Индекс, аймаг, хотоор, 2002

Аймаг, хот	Нэг хүнд ногдох ДНБ (PPP ам.доллар)	Дуудаж наслалт (жилээр)	Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин (%)	ХХИ	ХХИ-ийн эрэмбэ
Улаанбаатар	3 678.41	64.95	82.20	0.735	1
Орхон	2 651.82	63.63	79.60	0.705	2
Дархан-Уул	1 671.36	61.53	87.60	0.677	3
Говьсүмбэр	1 904.77	66.36	52.80	0.670	4
Сэлэнгэ	1 600.98	64.59	69.70	0.670	5
Өмнөговь	1 667.14	65.36	60.50	0.663	6
Төв	1 719.77	65.47	57.40	0.662	7
Булган	1 434.46	66.10	60.60	0.660	8
Дундговь	1 424.74	66.92	52.50	0.653	9
Ховд	1 178.42	64.46	72.00	0.652	10
Баян-Өлгий	992.85	66.64	61.60	0.645	11
Архангай	1 232.12	63.36	58.40	0.638	12
Хэнтий	1 289.61	63.72	60.50	0.638	13
Сүхбаатар	1 272.80	64.62	58.50	0.637	14
Завхан	1 225.91	62.09	66.40	0.634	15
Дорноговь	1 193.62	63.01	59.30	0.631	16
Говь-Алтай	1 345.54	61.87	59.60	0.631	17
Баянхонгор	1 392.36	60.21	60.20	0.624	18
Увс	1 098.30	61.25	64.90	0.621	19
Өвөрхангай	792.77	63.57	57.20	0.607	20
Дорнод	956.32	58.33	64.20	0.596	21
Хөвсгөл	976.44	59.42	56.60	0.596	22

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, YCF.

Зураглал XI Хүний Хөгжлийн Индекс, аймаг, хотоор, 2002



Хүснэгт Х2 Хүний Хөгжлийн Индекс, аймаг, хотоор, 1999-2002

Аймаг, хот	Нэг хүнд ногдох ДНБ (PPP ам.доллар)	Дундаж наслалт (жилээр)	Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин (%)	ХХИ	ХХИ-ийн эрэмбэ
Архангай					
1999	1 359.58	63.03	60.3	0.637	11
2000	1 362.76	63.03	64.0	0.641	14
2001	1 257.08	63.21	64.0	0.638	15
2002	1 232.12	63.36	58.4	0.638	12
Баян-Өлгий					
1999	836.10	66.31	56.1	0.627	16
2000	910.04	66.31	62.3	0.639	15
2001	1 006.64	66.49	62.3	0.645	12
2002	992.85	66.64	61.6	0.645	11
Баянхонгор					
1999	1 251.06	58.88	58.1	0.614	19
2000	1 215.24	59.88	61.9	0.616	18
2001	1 425.88	60.06	61.9	0.626	18
2002	1 392.36	60.21	60.2	0.624	18
Булган					
1999	1 663.15	65.77	65.1	0.671	4
2000	1 559.51	65.77	73.6	0.677	4
2001	1 499.18	65.95	73.6	0.676	4
2002	1 434.46	66.10	60.6	0.660	8
Говь-Алтай					
1999	1 167.85	61.54	59.0	0.620	18
2000	1 210.09	61.54	69.8	0.634	16
2001	1 368.65	61.72	69.8	0.642	14
2002	1 345.54	61.87	59.6	0.631	17
Дорноговь					
1999	1 287.98	62.68	62.6	0.637	12
2000	1 382.32	62.68	64.5	0.643	12
2001	1 176.06	62.86	64.5	0.635	16
2002	1 193.62	63.01	59.3	0.631	16
Дорнод					
1999	844.65	58.00	64.0	0.587	22
2000	756.81	58.00	66.7	0.584	22
2001	933.61	58.18	66.7	0.597	22
2002	956.32	58.33	64.2	0.596	21
Дундговь					
1999	1 677.38	66.59	57.2	0.666	5
2000	1 037.27	66.59	63.4	0.646	11
2001	1 378.50	66.77	63.4	0.663	9
2002	1 424.74	66.92	52.5	0.653	9
Завхан					
1999	1 240.44	61.76	56.6	0.622	17
2000	1 146.00	61.76	65.4	0.627	17
2001	1 189.44	61.94	65.4	0.630	17
2002	1 225.91	62.09	66.4	0.634	15
Өвөрхангай					
1999	1 340.49	63.24	52.9	0.630	15
2000	957.14	63.24	56.7	0.615	19
2001	813.02	63.42	56.7	0.607	20
2002	792.77	63.57	57.2	0.607	20
Өмнөговь					
1999	1 428.28	65.03	63.3	0.656	6
2000	1 411.56	65.03	66.4	0.659	5
2001	1 637.93	65.21	66.4	0.668	8
2002	1 667.14	65.36	60.5	0.663	6

Сүхбаатар						
1999	1 487.58	64.29	57.9	0.643	10	
2000	1 514.97	64.29	61.5	0.648	10	
2001	1 341.52	64.47	61.5	0.643	13	
2002	1 272.80	64.62	58.5	0.637	14	
Сэлэнгэ						
1999	1 182.55	64.26	69.1	0.650	8	
2000	961.39	64.26	72.1	0.642	13	
2001	1 541.24	64.44	72.1	0.669	7	
2002	1 600.98	64.59	69.7	0.670	5	
Төв						
1999	1 372.19	65.14	60.8	0.652	7	
2000	1 130.96	65.14	67.8	0.649	9	
2001	1 703.87	65.32	67.8	0.673	6	
2002	1 719.77	65.47	57.4	0.662	7	
Увс						
1999	1 012.30	60.92	59.4	0.608	20	
2000	932.75	60.92	65.9	0.611	21	
2001	1 074.41	61.10	65.9	0.620	19	
2002	1 098.30	61.25	64.9	0.621	19	
Ховд						
1999	1 052.42	64.13	61.5	0.633	14	
2000	1 256.01	64.13	67.4	0.649	8	
2001	1 221.29	64.31	67.4	0.649	11	
2002	1 178.42	64.46	72.0	0.652	10	
Ховсгөл						
1999	1 200.30	59.09	57.4	0.607	21	
2000	1 228.93	59.09	61.4	0.612	20	
2001	1 022.40	59.27	61.4	0.603	21	
2002	976.44	59.42	56.6	0.596	22	
Хэнтий						
1999	1 409.41	63.39	65.5	0.646	9	
2000	1 402.58	63.39	71.6	0.653	7	
2001	1 335.97	63.57	71.6	0.651	10	
2002	1 289.61	63.72	60.5	0.638	13	
Дархан-Уул						
1999	1 235.96	61.20	66.3	0.634	13	
2000	1 114.16	61.20	89.2	0.654	6	
2001	1 552.07	61.38	89.2	0.674	5	
2002	1 671.36	61.53	87.6	0.677	3	
Улаанбаатар						
1999	2 540.12	64.62	75.7	0.705	2	
2000	2 830.95	64.62	73.8	0.709	2	
2001	3 277.91	64.80	73.8	0.718	1	
2002	3 678.41	64.95	82.2	0.735	1	
Орхон						
1999	3 159.70	63.30	96.8	0.732	1	
2000	5 601.63	63.30	86.5	0.753	1	
2001	2 431.89	63.48	86.5	0.707	2	
2002	2 651.82	63.63	79.6	0.705	2	
Говьсүмбэр						
1999	1 335.78	66.03	75.0	0.673	3	
2000	1 355.52	66.03	82.0	0.681	3	
2001	1 770.96	66.21	82.0	0.697	3	
2002	1 904.77	66.36	52.8	0.670	4	

Эх сурвалж: 2003 оны Монголын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан тооцоо, YCF.

Хүснэгт Х3 Шилжилтийн эдийн засагтай орнуудын ХХН, 2003

Улс	Төрөлгөөс тооцсон дундаж насныг (жнээр)	Насан хүргэлийн бичиг үсэгт тавьдагт (15 түүрхэж дээш насныхан, %)	Бага, дунд, дээд боловсролд хамрагдалтын түвшин (%)	Нэг хүнд ногдох ДНБ (PPP ам.доллар)	Дундаж насалтын илэкс	Боловсролын илэкс	ДНБ-ий илэкс	ХХН-ийн эрэмбэ
Албани	73.4	85.3	69	3 680	0.81	0.80	0.60	95
Армани	72.1	98.5	60	2 650	0.78	0.86	0.55	100
Азербайджан	71.8	97.0	69	3 090	0.78	0.88	0.57	89
Беларус	69.6	99.7	86	7 620	0.74	0.95	0.72	53
Босни, Герцеговин	73.8	93.0	64	5 970	0.81	0.83	0.68	66
Болгар	70.9	98.5	77	6 890	0.76	0.91	0.71	57
БН Чех Улс	75.1	---	76	14 720	0.83	0.91	0.83	32
БНХАУ	70.6	85.8	64	4 020	0.76	0.79	0.62	104
Эстони	71.2	99.8	89	10 170	0.77	0.96	0.77	41
Гүрж	73.4	100.0	69	2 560	0.81	0.89	0.54	88
Хорват	74.0	98.4	68	9 170	0.82	0.88	0.75	47
Унгар	71.5	99.3	82	12 340	0.77	0.93	0.80	38
Казакстан	65.8	99.4	78	6 500	0.68	0.92	0.70	76
Киргизстан	68.1	97.8	79	2 750	0.72	0.91	0.55	102
БН Лаос Ард Улс	53.9	65.6	57	1 620	0.48	0.63	0.46	135
Латви	70.5	99.8	86	7 730	0.76	0.95	0.73	50
Литва	72.3	99.6	85	8 470	0.79	0.94	0.74	45
Микелон	73.3	94.0	70	6 110	0.81	0.86	0.69	60
Молдав	68.5	99.0	61	2 150	0.72	0.86	0.51	108
Монгол	63.3	98.5	64	1 740	0.64	0.87	0.48	117
Польш	73.6	99.7	88	9 450	0.81	0.95	0.76	35
Румын	70.5	98.2	68	5 830	0.76	0.88	0.68	72
ОХУ	66.6	96.6	82	7 100	0.69	0.93	0.71	63
БН Словак Улс	73.3	100.0	73	11 960	0.80	0.90	0.80	39
Словени	75.9	99.6	83	17 130	0.85	0.94	0.86	29
Таджикистан	68.3	99.3	71	1 170	0.72	0.90	0.41	113
Туркменистан	66.6	98.0	81	4 320	0.69	0.92	0.63	87
Украйн	69.2	99.6	81	4 350	0.74	0.93	0.63	75
Узбекистан	69.3	99.2	76	2 460	0.74	0.91	0.53	101
Вьетнам	68.6	97.2	64	2 070	0.73	0.83	0.51	109

Эх сурвалж: Дэлхийн хүний хөгжлийн илтгэл 2003, НҮБХХ.

Хүснэгт Х4 Жендрийн Хөгжлийн Индекс ба үзүүлэлтүүд, аймаг, хотоор, 2002

Аймаг, хот	Шалгалтын үр дүн				Бага, дунд, дээд боловсрол		Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
	Төрийн төвшин	Төрийн төвшин	Төрийн төвшин	Төрийн төвшин	Төрийн төвшин	Төрийн төвшин																
Орхон	65.20	71.60	99.20	98.80	80.30	78.90	3 117.30	2 201.80	0.724	0.925	0.543	0.731	1									
Увс	60.50	67.80	99.40	99.20	77.60	86.60	4 018.10	3 357.10	0.652	0.936	0.601	0.730	2									
Дархан-Уул	58.00	65.20	99.10	98.80	82.90	92.30	1 780.30	1 565.30	0.610	0.952	0.469	0.677	3									
Говьсүмбэр	65.50	69.90	97.80	97.60	51.70	53.90	1 984.40	1 811.30	0.712	0.827	0.492	0.677	3									
Сэлэнгэ	61.10	68.70	98.20	98.10	69.00	70.40	1 674.00	1 527.00	0.664	0.887	0.463	0.671	4									
Төв	63.20	68.10	97.20	96.80	55.50	59.30	1 870.90	1 563.60	0.677	0.838	0.474	0.663	5									
Өмнөговь	62.30	68.20	97.00	96.50	57.80	63.20	1 637.40	1 697.30	0.671	0.847	0.470	0.662	6									
Булган	63.60	68.70	97.20	97.00	59.90	61.20	1 691.70	1 177.30	0.685	0.849	0.440	0.658	7									
Дундговь	64.60	69.40	96.60	96.40	49.50	55.60	1 556.10	1 291.20	0.700	0.818	0.442	0.653	8									
Ховд	61.70	67.20	97.60	96.80	69.10	74.80	1 163.70	1 192.60	0.658	0.888	0.412	0.653	8									
Баян-Өлгий	64.90	68.60	98.20	97.10	58.30	65.00	1 150.10	830.10	0.696	0.856	0.379	0.644	9									
Хэнтий	61.70	66.20	96.10	95.80	59.20	61.70	1 373.50	1 205.70	0.649	0.841	0.426	0.639	10									
Сүхбаатар	60.50	68.90	95.40	93.90	54.80	62.30	1 254.00	1 297.50	0.660	0.826	0.425	0.637	11									
Завхан	60.30	63.80	97.00	96.00	64.10	68.70	1 251.20	1 201.10	0.617	0.865	0.418	0.633	12									
Архангай	61.50	65.40	96.60	95.90	54.60	62.10	1 331.80	1 130.20	0.640	0.836	0.418	0.631	13									
Дорноговь	59.10	67.10	97.30	97.30	56.60	61.90	1 220.40	1 166.70	0.634	0.846	0.414	0.631	13									
